

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2011 ОНЫ АРАВДУГААР САР

Диахона



МОРМОНЫ НОМ:
ЕСҮС ХРИСТИЙН БАС
НЭГЭН ГЭРЭЭ



Бурханы бэлэг болон хүчээр, Симон Дювей

Бошиглогч Иосеф Смитийн авчирсан Мормоны Ном бол “зарлигийн замаар, мөн түүнчлэн бошиглолын мөн илчлэлтийн суу билгээр бичигдсэн бөлгөө, мөн тэдгээр нь устгагдахгүй байж болохын тулд бичигдэн, лацдагдаж, мөн Их Эзэний тулд далд хадгалагдсан—Бурханы бэлэг болон хүчээр орчуулагдах” ёстой эртний ялтсуудын

орчуулга юм— . . .

“ . . . Их Эзэний гэрээнүүдийг тэд мэдэж болохын тулд тэд үүрд зайлуулагдахгүй байхын тул Их Эзэн тэдний өвөг дээдэст ямар агуу зүйлүүдийг хийж өгснийг Израилын угсааны үлдэгдэлд үзүүлэх тэрхүү, Есус бол ХРИСТ хэмээн Иудей болон Харийнханд итгүүлэхийн” тулд буюу (Мормоны Номын эхний хуудас).



4



46

Энэ онцгой дугаарт тавтай морилно уу

Энэ дугаар нэлээд хэдэн сэдвийг хөндсөн бөгөөд эдгээр сэдвүүдийн нэг нь Мормоны Ном юм. Энэ дугаарт өнгөрсөн болон өнөө үеийн бошиглогчид, тэрчлэн бүх дэлхий даяарх гишүүд энэхүү гайхамшигтай судрын тухай гэрчилсэн. Уг номын гарал үүсэл үнэхээр ер бусын төдийгүй Сэргээлтийн бодит нотолгоо мөн. Энэ ном бол манай шашны тулгуур чулуу юм. Түүнчлэн энэ ном өнөө үеийнхэнд зориулан бичигдсэн бөгөөд бидний итгэлийг төлөвшүүлж, гэр бүлүүдийг маань бэхжүүлэхийн төлөө Христийн сургаалыг тод томруун бөгөөд энгийнээр заадаг.

Лиахонагаас та нарын тогтмол уншдаг олон хэсэг энэ дугаарт байхгүй ч, Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг (х.4), Айлчлагч багшийн захиас бичиг (х.46) байгаа. Энэ хоёр захиас болон бусад бүх өгүүлэл нь гэрчлэлүүд болон сургаалуудыг Мормоны Номноос хуваалцаж байна.

Энэ дугаарыг залбирч уншин, захиасуудыг нь зүрх сэтгэлдээ хүлээн авч, эдгээрийг болон Мормоны Номын тухай бусадтай хуваалцахыг бид та бүхнээс хүсч байна.

ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Мормоны Номын үнэ цэнэтэй амлалтууд
Ерөнхийлөгч Томас С.Монсон

46 Айлчлагч багшийн захиас бичиг: Хэрэв бид эргэлзэхгүй байвал

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн тал: Зураг чимэглэлийг Жон Лук;
Та нар мэдэж болно, Гари Каппын бүтээл,
Давид Ларсений зөвшөөрлөөр ашиглав.
Ар тал: *Христийн дур зураг Хейнри Хоф-*
маны бүтээл, Хариссон Конрой Кожын зөв-
шөөрлөөр ашиглав. Хууларлаж үл болно.



ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

6 Бошиглогч Иосеф Смит: Мормоны Номын орчуулагч
Боловсролгүй залуу хөвгүүн Бурханы хүчээр энэ “дэлхий дээрх хамгийн үнэн зөв номын” орчуулагч болжээ.

10 Мормоны Ном Бурханы хайрын тухай юу заадаг вэ?
 Ахлагч Рассел М.Нелсон
Та сүнслэг байдлын хувьд дахин төрж, Бурхан хүмүүнийг хайрладаг шиг тийм хайрыг өөртөө бий болгохыг хүсч байна уу? Ийм хайрыг өөртөө хэрхэн бий болгохыг Мормоны Ном тайлбарладаг.

16 Мормоны Номын түүх
Энэ өгүүлэл судрын энэхүү номын чухал түүхүүдийг хүүхдүүддээ заахад тань туслах болно.

20 Мормоны Номын он тооллын дараалал
МЭӨ 2200 оны үеэс МЭ 420 оны үе дэх Жаред үндэстний түүхэн хүмүүсийн тухай өгүүлсэн товч тойм.



22 Мормоны Номыг хэн бичсэн бэ?
Эртний бошиглогчид, урам зоригтой хөрвүүлэгчид болон Хожмын Үеийн орчуулагч нарын хөдөлмөрөөр дамжин Мормоны Ном бидэнд ирсэн юм.

24 Мормоны Ном: Библийн хамт гэрчилдэг
Библид заадаг 14 тулгуур сургаалын тухай доор харуулав. Эдгээр сургаалуудын тухай Мормоны Ном нэмэлт гэрчлэл өгүүлсэн юм.

28 Мормоны Номыг хэрхэн судлах вэ?
 Ахлагч Д.Тодд Кристофферсон
Судрын энэхүү гайхамшигтай номыг судлах гурван шалтгаан хийгээд арга зам буй.

32 Лихайн зүүд: Төмөр бариулаас зууран барь
 Ахлагч Давид А.Беднар
Лихайн зүүд Бурханы үгнээс хэрхэн чанга зууран барихыг бидэнд заадаг.

38 Мормоны Ном: Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэх нь
 Ахлагч Нийл Л.Андерсен
Мормоны Ном биднийг болон гэр бүлүүдийг маань

Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг баяртайгаар хүлээн авахад урьдаг бөгөөд энэ нь гэр бүл өнгөтэй өөдтэй, амжилт бүтээлтэй байхад тусалдаг.

47 Дуу хөгжим: Хоёр мянган залуу дайчид
 2009, Бонни Харт Мюррей, Женис Капп Перри.

48 Манай өнөө үед зориулсан сургаалууд
Мормоны Номноос амьд бошиглогчид, төлөөлөгчдийн хуваалцсан үгнүүд өнөөдөр биднийг удирдаж байна.

52 Мормоны Ном манай шашны тулгуур чулуу
 Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон
Мормоны Номын тухай 25 жилийн тэртээ хэлсэн эдгээр үгс цаг хугацаа улиран өнгөрсөн ч үнэ цэнэ нь хэзээ ч үл буурах гэрчлэл болон зөвлөгөөг агуулдаг.

59 Ариун ажил
 Давид А.Фейц
Нэгэн маш энгийн явдал надад Мормоны Номын ариун шинж чанарт гүн хүндэтгэлтэйгээр хандахыг заасан юм.



60 Хэрэв та үнэхээр мэдэхийг хүсвэл мэдэх болно

Ахлагч Уолтер Ф.Гонзалез
Мормоны Ном Бурханаас сүнслэгээр нөлөөлөгдсөнийг мэдэх дөрвөн арга зам байдаг.

65 Үзүүлэн: Газар шорооноос гарч ирсэн дуу хоолой

66 Миний дотор шатаж буй гал

Майкл Р.Моррис
Эдуардо Контерас уншиж сурсан өдрөө Мормоны Номын тухай гэрчлэлтэй болжээ.

68 Мормоны Ном амьдралыг минь өөрчилсөн нь

Мормоны Ном асуултуудад нь хэрхэн хариулж, тайтгаруулан, сайн мэдээнд хөрвөхөд нь тусалсан тухай гишүүд гэрчилдэг.

72 Хэлтэн болон хүн бүрд

Лиан МкКланахан
Дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд Мормоны Ном төрөлх хэлээр нь байгааг юутай ч зүйрлэх аргагүй юм.



76 Мормоны Номын тухай тогтмол асуудаг асуултууд

Мормоны Номын тухай хүмүүс олонтоо асуудаг асуултуудын энгийн хариулт

80 Гэрчлэл, гэрээ ба гэрч

Ахлагч Жеффри Р.Холланд
Би энэ номыг Гурав болон Найман гэрчийн хамтаар алтан ялтсуудыг харсан мэт гэрчилж байна.



Энэхүү сэтгүүл дээрх олон зураг Лихайгийн хүлээн авсан Лиахонаны зураглалыг тусгасан байдаг. Лиахонаг нуугаагүй боловч яг дээрхтэй адилхан харагдахгүй байж болно гэхдээ та болон танай гэр бүл сэтгүүлийг уншихдаа нийт хэдэн лиахона байгааг олж болно.

2011 ОНЫ АРАВДУГААР САРЫН ДУГААР ЛИАХОНА 09690 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын албан ёсны сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг, Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер, Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс, М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс, Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер
Зөвлөхүүд: Стенли Г.Эллис, Кристоффел Голден Бага, Ешихико Кикүчи

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнет

Редакцийн захирал: Винсент А. Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд, Адам К.Өүлсон

Туслах редактор: Сюзан Баррет, Раян Карр
редакцийн ажилтнууд: Бриттани Бийти, Давид А. Эдвардс, Маттью Д.Флиттон, Ларина Портер Гаунт, Ларри Хиллер, Карри Кастен, Женифер Медди, Лиан МакКалахан, Меллиса Меррил, Майкл Р.Моррис, Салли Ж.Өүдкөрк, Жошуа Ж.Перки, Чад И.Фарес, Жан Пинбороу, Жанет Томас, Паул Ванденберг, Мелиса Зентено

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скотт Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Ахлах дизайнерууд: К.Кимбалл Ботт, Томас С. Чайльд, Коллеен Хинкли, Эрик П.Жонсен, Скотт М.Мооё

Уран бүтээлийн ажилтнууд: Коллетт Небекер Аун, Ховард Ж.Браун, Жюли Бёрдетт, Режиналд Ж.Крисченсен, Ким Фенстермейкер, Катлийн Ховард, Денис Көрби, Жинни Ж.Нилсон, Тай Пилчер
Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик
Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен, Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа Liahona, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
October 2011 Vol. 12 No. 5. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake Distribution Center, Church Magazines, PO Box 26368, Salt Lake City, UT 84126-0368.

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



МОРМОНЫ НОМЫН ҮНЭ ЦЭНЭТЭЙ АМЛАЛТУУД

Олон жилийн тэртээ амь нас нь дээсэн дөрөөн дээр байсан нэгэн залуухан эцгийн орны дэргэд би зогсож байлаа. Тэвдэн сандарч яахаа мэдэхгүй болсон эхнэр нь хоёр хүүхдийнхээ хамт дэргэд нь зогсож байв. Залуу эцэг гарыг минь бариад, цөхөрсөн харцаар намайг ширтсэнээ: “Бишоп оо, би ч тэсэхгүй нь ээ. Намайг нас барахад сүнсэнд минь юу тохиолдохыг хэлж өгөөч” гэв.

Би тэнгэрлэг удирдамжийн төлөө чимээгүй залбирах үедээ орных нь дэргэдэх ширээн дээр гурамсан судар байхыг олж харлаа. Номыг авч, хуудсыг нь эргүүлээ. Тэгтэл би ямар ч зориудын санаагүйгээр Мормоны Номон дахь Алмагийн 40-р бүлэг дээр гэнэт зогсов. Дараах үгсийг түүнд уншиж өглөө:

“Болгоогтун, бүх хүмүүний сүнс энэ зуурдын биеийг орхимогцоо, . . . амьдралыг нь өгсөн Бурханд гэртээ аваачигддаг нь надад нэгэн тэнгэр элчээр мэдүүлэгдсэн билээ.

“. . . Мөнхүү тэгээд зөв шударга тэдний сүнс тэд өөрийн бүх бэрхшээлүүд мөн санаа зоволт хийгээд харамслаасаа амрах диваажин гэж нэрлэгдсэн аз жаргалын байдал, амар амгалангийн байдал, энхийн байдалд хүлээн авагдах болно. (Алма 40:11–12).

Амилуулалтын тухай намайг үргэлжлүүлэн уншихад, залуугийн нүүрэнд улаа бутран, урууланд нь баярын инээмсэглэл тодорч байлаа. Тэгээд би энэ сайхан гэр бүлд баяртай гэж хэлээд тэднийхээс гарсан.

Дараа нь эхнэр, хүүхдүүдтэй нь оршуулга дээр таарч билээ. Сайхь залуу үнэнийг мэдэхийг гуйж, асуултынхаа хариуг Мормоны Номноос сонссон тэр үдшийг би эргэн санаж байна.

Мормоны Номонд бусад үнэ цэнэтэй амлалтууд, түүний дотор хэрэв бид “уг нутгийн Бурхан, Есүс Христэд л зөвхөн үйлчлэх аваас” (Ифер 2:12) бидэнд ирэх амар амгалан, эрх чөлөөний амлалтууд болон адислалууд байдаг.

Энэ номын хуудсуудаас “Бурханы зарлигуудыг дагадаг тэдэнд” “хэзээ ч төгсөшгүй аз жаргал” ирэх болно. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлд биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан болой” (Мозая 2:41) гэсэн амлалт байдаг.

Энэ номын хуудсуудад Түүний өгүүлшгүй сайхан хөвгүүд, охидыг аврахад “Бурханы мутар дахь зэмсэг” болох хүмүүст “ухааршгүй их баясал”-ын амлалт байдаг (Алма 28:8; 29:9).

Энэ номын хуудсанд тараагдсан Израил дэлхий даяарх номлогчдын хүч чармайлтын үр дүнд бидний оролцож байгаа ажил биелэгдсэнээр цуглуулагдах болно гэсэн амлалт бий (3 Нифай 16; 21–22-ыг үз).

Хэрэв бид Есүс Христийн ариун нэрээр Эцэгт хандан залбирвал бидний гэр бүл адислагдах болно гэсэн амлалт энэ номын хуудсуудад байдаг (3 Нифай 18:21-ыг үз).

Энэ номыг судалснаар “амьдралд тань бас гэр оронд тань Их Эзэний Сүнс элбэг дэлбэгээр ирж, Түүний зарлигуудын дагуу амьдрах шийдвэр төгс санаа бодол, Бурханы Хүү амьд гэдэг нь үнэн бодитойг нотолдог бат бөх гэрчлэлтэй болно” гэсэн бошиглолын амлалт биелэгдэж байгааг мэдэх болно.¹

Бид залбирал, чин хүсэл, Христэд итгэх итгэлээр дамжуулан, дээрх амлалтууд үнэн болох нь “Ариун Сүнсний хүчээр” ирнэ гэсэн Моронайн амлалтыг



Мормоны Номын хуудсуудаас мэдэж болно (Моронай 10:4–5-ыг үз).

Миний бие хожмын үеийн бусад бошиглогчдын хамт “энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь”² болох энэ ном, тухайлбал Мормоны Ном, Есүс Христийн бас нэгэн гэрээ үнэн гэдгийг гэрчилж байна. Энэ номын захиас дэлхий даяар тархаж, уншигчдаа үнэний мэдлэгт авчирч байна. Мормоны Ном хүмүүсийн амьдралыг өөрчилдгийг би гэрчилж байна. Бидний хүн нэг бүр энэ номыг дахин дахин уншиж байх болтугай. Энэ номын үнэ цэнэтэй амлалтуудын тухай гэрчлэлээ Бурханы бүх хүүхдүүдтэй баяртайгаар хуваалцацгаая. ■

ЭШЛЭЛ

1. Гордон Б.Хинкли, “A Testimony Vibrant and True,” *Лиакхона*, 2005 оны 8-р сар, 6.
2. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 64.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

“Судруудаас бид хүмүүнд тохиолдох аливаа төөрөгдөл, асуудал, төвөгтэй нөхцөл байдлыг шийдвэрлэх үнэний зарчмуудыг олдог” (*Teaching, No Greater Call* [1999], 51). Та Ерөнхийлөгч Монсонгийн захиасыг гэр бүлтэйгээ хуваалцах үед Мормоны Номон дахь “үнэ цэнэтэй амлалтуудыг” сонсохыг тэднээс хүс. Өөрийн чинь хувьд чухал ач холбогдолтой Мормоны Номон дахь аль нэг амлалтын тухай та хуваалцаж болно.

Бошиглогч Иосеф Смит:

МОРМОНЫ НОМЫН
ОРЧУУЛАГЧ

Мормоны Ном нь онцгой нэгэн судар юм. Хэдийгээр үүнийг эртний бошиглогчид бичсэн ч гэсэн энэ нь Библи шиг бидэнд ирээгүй. Ариун Библи нь Хуучин Дэлхийд их хэмжээний хуйлмал цаасан дээр бичигдсэн салангид номнууд байсан ба олон зууны туршид бичээчид үүнийг хувилж иржээ. Есүс Христ ирсний дараа дөрөвдүгээр зууны үед эдгээр салангид номнуудыг нэгтгэн Ариун Библи нэртэйгээр нэг боть болгон олны хүртээл болгожээ.

Харин Мормоны Номыг эртний бошиглогчид Шинэ Дэлхийд төмөр ялтсан дээр цэдэглэсэн ба М.Э тавдугаар зуунд бошиглогч Мормон (иймээс Мормоны Ном гэж нэрлэсэн) алтан ялтсууд дээр нэг цэдэг болгон хураангуйлсан. Түүний хүү Мородай ялтсуудыг газарт булж, тэдгээр нь 1827 он хүртэл тус газартаа хадгалагдаж байсан ба Мородай амилуулагдсан байдлаар Иосеф Смит нэртэй залуу хөвгүүн дээр хүрч ирэн, ялтсуудыг хүлээлгэн өгчээ.

Энэ нь Иосеф хэрхэн үүнийг хүлээн авч, орчуулж, Мормоны Ном: Есүс Христийн бас нэгэн гэрээ нэртэй цэдэг болгон хэвлэн гаргасан тухай түүхээр үргэлжилдэг. Аврагч Өөрийн биеэр энэ ном нь үнэн гэдгийг гэрчилсэн (С ба Г 17:6-г үз).



Аврагчийн Мормоны Номын талаарх гэрчлэлийн улмаас 1830 оноос хойш сая сая хүн Мормоны Номыг уншиж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд нэгдсэн. Энэ


ном нь Иосеф Смит Бурханы бошиглогч байсан бөгөөд өнөөдөр Аврагч Өөрөө энэ сүмийг удирддаг гэсэн нэгэн нотолгоо билээ. Үнэнийг эрэлхийлэгч хүмүүст өгсөн Моронайн амлалтыг



4. 1823 оны есдүгээр сарын 21-нд Иосеф залбирахад түүний унтлагын өрөө гэрлээр дүүргэгдэж Моронай нэртэй нэгэн тэнгэр элч үзэгдэв. Моронай Иосефт эртний бошиглогчдын бичээсүүдийн тухай хэлэв. Цэдэг нь алтан ялтсууд дээр сийлэгдэж, ойролцоох гүвээнд булагдсан. Иосеф цэдгийг орчуулах хэрэгтэйг хэлэв.



5. Эцэст нь 1827 оны 9-р сарын 22-нд Иосеф ялтсуудыг хариуцаж авах үүрэг хүлээж, Нью-Йоркийн Палмирагийн ойролцоох гүвээнд том чулуун дор дарагдсан чулуун хайрцагаас тэдгээрийг гаргаж авсан.



6. Иосеф Смит үнэндээ боловсролгүй нэгэн байсан ба энэ нь тухайн цаг үед хөдөө тосгоноор нийтлэг байжээ. Түүний орчуулгад туслахаар Бурхан эртний орчуулгын хэрэгсэл болох Урим Тумми-мыг түүнд өгсөн бөгөөд орчуулах хэрэгтэй гэж зөвлөсөн тэдгээрийг бичихэд туслах бичээчээр түүнийг адисалсан. Тэдгээр бичээчид нь дунд түүний эхнэр, Эмма; чинээлэг фермер, Мартин Харрис; мөн сургуулийн багш Оливер Каудери нар байв. Оливер бичээчээр үйлчилж эхэлснээс хойш гурван сарын дотор орчуулгын ажлын ихэнх хэсэг нь дуусжээ.

Иосефын бичээчээр үйлчлэх нь ямар байсан тухай Эмма тайлбарлахдаа: “Хэн ч тэнгэрлэг илэрхийлэлт авалгүйгээр гар бичмэлээс хэлж бичүүлж чадахгүй; [би] түүний бичээчээр ажиллаж байхад [Иосеф] олон цагийн турш

сая сая хүн туршиж үзэж, өөрсдөө тэрхүү үнэнийг олж авсан юм: “Та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулья би; мөн хэрэв та

нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно” (Моронай 10:4).



хэлж бичүүлдэг байсан; мөн хоолны дараа буцаж ирээд эсвэл түр завсарлага авсны дараа тэр дуусгасан газраасаа гар бичмэлийг харалгүйгээр эсвэл үүний өчүүхэн хэсгийг ч түүнд уншиж өгөлтгүйгээр эхэлдэг байсан.”²

Иосеф Мормоны Номын ирэлтийн ач холбогдлыг тайлбарлахдаа: “Бурханы хүчээр би Мормоны Номыг эртний египет хэлээс орчуулж, дэлхийгээс алдагдсан тэр мэдлэгт би ганцаараа эрдэм мэдлэггүй, залуугаараа дэлхийн мэргэн ухаан болон арван наймдугаар зууны олон янзын мунхаглуудтай тулалдахаар шинэ илчлэлттэй зогсож байна”.³

7. Ялтсуудтай хамт байсан 18 сарын хугацаанд Иосеф ганцаараа тэдгээрийг харж эсвэл гартаа бариагүй юм. Оливер Каудери, Давид Витмер, Мартин Харрис нарт тэнгэр элч Моронай алтан ялтсуудыг харуулж мөн тэдгээр ялтсууд “Бурханы хүч болон бэлгээр орчуулагдсан, учир нь түүний дуу хоолой бидэнд үүнийг тунхагласан” гэдгийг мэднэ хэмээн тэд албан ёсоор гэрчилжээ. Мөн өөр найман хүн алтан ялтсуудыг харж мөн барьж үзсэнээ гэрчилжээ.⁴

8. 1829 оны 8 сард Иосеф Нью-Йоркийн Палмирагийн хэвлэгч Эгберт Б. Грандинтай Мормоны Номыг хэвлэх гэрээ хийсэн бөгөөд Мартин Харрис номын хэвлэлд зориулж өөрийн фермийг барьцаалж, 1830 оны 3-р сарын 26 гэхэд Мормоны Ном худалдаанд гарсан юм.

9. 1830 оны 4-р сарын 6-нд Нью-Йоркийн Фейетте дэх дүнзэн байшинд жараад хүн цуглан тэнд, Их Эзэн Есүс Христээр удирдуулан, Иосеф Смит албан ёсоор Аврагчийн сүмийг анх зохион байгуулсан байдлаар нь сэргээж, төлөөлөгч болон бошиглогчоор удирдуулан, Бурханыг төлөөлөн ярих эрх мэдлийг олж авчээ. Дараа нь Иосеф Смитэд Сүмд өгөх нэрний талаар илчлэлт ирсэн: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (С ба Г 115:4-г үз). ■


ЭШЛЭЛ

1. Иосеф Смит, *History of the Church*, 4:536.
2. Interview with Emma Smith by Joseph Smith III, 1879 оны 2-р сар, in *Saints' Herald*, 1879 оны 10 сарын 1, 290.
3. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 60.
4. Мормоны Номын удиртгал хэсэг дэх “Гурван Гэрчийн Гэрчлэл” болон “Найман Гэрчийн Гэрчлэл” -ийг үз.



Ахлагч Рассел М.Нелсон

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын



МОРМОНЫ НОМ

БУРХАНЫ

ХАЙРЫН ТУХАЙ ЮУ ЗААДАГ ВЭ?

*Их Эзэний хайрын хамгийн яруу тод нэлээд хэдэн
жишээг Мормоны Номонд цэдэглэсэн байдаг.*

Христэд итгэгчдийн ихэнх нь Библид тэмдэглэсэн Есүс Христийн зан төлөвийн шинж чанаруудыг мэддэг билээ. Ядуус, өвчтэй хүмүүс болон дорд үзэгдэгсдийг Тэрбээр хайрладаг байсанд хүмүүс гайхдаг байлаа. Өөрсдийгөө Түүний шавь нар гэж үздэг хүмүүс Түүний үлгэр жишээг дуурайж, Түүний хайртай Төлөөлөгчийн: “Бие биеэ хайрлацгаая. Учир нь хайр бол Бурханаас ирдэг. Хайрладаг хүн бүр Бурханаас төрсөн бөгөөд Бурханыг мэддэг юм. . . Учир нь Бурхан бол хайр билээ” (1 Иохан 4:7–8) хэмээх уриаг дагадаг.

Уг үзэл баримтлалыг Мормоны Ном тодруулсан юм. Энэ ном хүн хэрхэн Бурханаас төрдөг хийгээд хэрхэн Түүнийх шиг хайрыг олж авдгийг тайлбарладаг. Энэ нь бас Бурханы хайрын хүчийг бидний амьдралд авчирдаг үндсэн гурван зарчмыг тогтоосон юм.

Нэгдүгээрт, Мормоны Ном нь Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх болон Түүний зарлигуудыг сахихын тулд Түүнтэй гэрээнд

орох нь сүнсээр дахин төрөхийн түлхүүр мөн гэдгийг заадаг. Хаан Бенжамин ийм гэрээ хийсэн Мормоны Номын хүмүүст хандан: “Мөн эдүгээ та нарын хийсэн гэрээний учир та нар Христийн хүүхдүүд, түүний хөвгүүд мөн түүний охид гэж нэрлэгдэх болно; учир нь болгоогтун, энэ өдөр тэрээр та нарыг оюун санаагаар тань төрүүллээ; учир нь, та нарын зүрх сэтгэл түүний нэрэнд итгэх итгэлээр өөрчлөгдсөн хэмээн та нар хэллээ; тиймийн тул, та нар түүнээс төрсөн мөн түүний хөвгүүд мөн түүний охид болсон бөлгөө” (Мозая 5:7) хэмээн хэлжээ.

Хоёрдугаарт, Аврагч Өөрөө Түүнтэй илүү адилхан болох хүч нь сайн мэдээний ёслолуудыг хүлээн авснаар ирдгийг зааж: “Эдүгээ уг зарлиг нь энэ болой. Ариун Сүнсний хүлээн авалтаар та нар ариусагдаж болохын тулд эцсийн өдөр та нар миний өмнө толбогүйгээр зогсож болохын тулд наманчлагтун, мөн надад ирэгтүн мөн миний нэрээр баптисм хүртэгтүн, газар

дэлхийн хязгаарууд, та нар” (3 Нифай 27:20) гэжээ.

Гуравдугаарт, Тэрбээр *Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг* бидэнд зөвлөн “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” гэж ой тойнд ортол асуугаад “Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу” (3 Нифай 27:27) хэмээн хариулсан билээ. Тэрбээр биднийг Өөртэйгөө адил болохыг чин үнэнээсээ хүсдэг юм.



БОШИГЛОГЧ ГЭРЧИЛЖ БАЙНА

“Мормоны Ном Бурханы бэлэг болон хүчээр ирсэн юм. Энэ ном Бурханы Хүү гэрчлэн газар шорооноос гарч ирсэн дуу хоолой болон ярьдаг билээ. Энэ ном Түүний төрөлт, үйлчлэл, Цовдлолт ба Амилалт, Америк тив дэх Өгөөмөр нутгийн зөв шударга хүмүүс дээр Тэрбээр хүрч ирсэн тухай өгүүлдэг.

Энэ бол ойлгож, уншиж, сорьж үзэж болох үнэн бодитой зүйл. Энэ ном бурханлаг гарал үүслийнхээ тухай амлалтыг агуулдаг. Эдүгээ сая сая хүн Мормоны номыг сорьж шалган, үнэн бөгөөд ариун цэдэг мөн гэдгийг нь нотолсон юм.”

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008), “The Great Things Which God Has Revealed,” *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 81–82.

Түүний хайрын хамгийн тод жишээг Мормоны Номонд цэдэглэсэн байдаг. Бид Их Эзэнтэй илүү адил болохыг хичээн чармайсан үед эдгээр үлгэр жишээ бидний амьдралд биеллээ олох болно.

Тэрбээр Лихайг болон түүний гэр бүлийг хайрласны ачаар мөн Түүнийг хайрласан учраас тэд амлагдсан нутаг Америкт ирж хөгжин дэвжсэн билээ.¹

Олон зууны тэртээ ард түмнийхээ ариун цэдгийг хөтлөх хэрэгтэй гэж Нифайчуудын бошиглогчдоод зарлиг болгохоор Тэрбээр сүнсээр өдөөгдсөн нь бидний төлөөх Бурханы хайрын илрэл юм. Тэрхүү цэдэгт агуулагддаг сургамжууд нь бидний аврал, өргөмжлөлийн тухай өгүүлдэг. Эдгээр сургаалууд эдүгээ Мормоны Номонд байдаг. Энэхүү ариун ном нь дэлхий даяарх бүх хүүхдээ хайрлах Бурханы хайрын үнэн бодит нотолгоо болж байна.²

Христийг Шинэ Дэлхийд хүрч ирэхэд хүргэсэн зүйл бол Түүний “бусад хонинуудаа” хайрлах хайр байсан юм.³ Хуучин Дэлхийд Их Эзэн хаалин одсоны дараа Шинэ Дэлхийд байгалийн аймшигт гамшиг тохиож, гурван өдөр харанхуй болсныг бид Мормоны Номноос сурдаг. Тэр үед

МЭДЭХ ГЭДЭГ НЬ ХАЙРЫГ МЭДНЭ ГЭСЭН ҮГ ЮМ

Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн хүн. Иймээс Мормоны Ном миний хувьд ердийн нэг ном биш. Энэ ном бол Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртайн хөдөлшгүй нотолгоо мөн. Мөн эртний Гэгээнтнүүд бидэнд хайртай байсан бөгөөд биднийг гэртээ эргэж хариасай гэж хүсдэг байсны нотолгоо юм. Бурханы аз жаргалын төлөвлөгөө бодитой оршдог бөгөөд төгс төгөлдөр болохын нотолгоо мөн.

Энэ ном үнэн гэдгийг мэдсэнээр та Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү амьд гэдгийг мэдэх болно. Та энэ номыг уншсанаар амьдрал сайхан бөгөөд үүрд мөнх үргэлжилдгийг мэднэ. Та сайн хүн байхын төлөө чадах чинээгээрээ үргэлж хичээж, алдаа гаргасан үедээ наманчилж байх юм бол үргэлж уучлагдах болно гэдгийг энэ ном танд мэдүүлэх болно. Энэ ном танд гэр бүлийн жинхэнэ утга учрыг мэдүүлнэ. Хайртай хэн нэгэн чинь таныг хүлээж байх учраас та тэр эрхэм хүнээ хэзээ ч алдахгүй гэдгийг энэ номноос мэдэх болно. Тэнгэрлэг Эцэгийн адислалуудыг та мэдэж чадна. Амьдралын замд чинь ямар ч аюул занал, саад бэрхшээл тохиолдсон ч та тэдгээрийг даван туулж тайтгарлыг олж чадсанаар, саад бэрхшээл нь эргээд танд ашиг тусаа өгөх болно гэдгийг мэднэ. Ариун Сүнс бол таны байнгын хамтрагч гэдгийг мэдэх болно. Мөн чанартаа, энэ нь хайрыг бүхий л илрэлээр нь мэдэх явдал мөн.

Эмма Адесаня, Ирланд



амилж, төгс биетэй болсон Их Эзэн тэнгэрээс бууж ирэн, Шинэ Дэлхийн хүмүүсийн дунд үйлчилсэн юм.

“Би бол дэлхийн гэрэл ба амь; мөн би Эцэгийн надад өгсөн гашуун аяганаас ууж, дэлхийнхний нүглүүдийг өөр дээрээ авснаар Эцэгийг алдаршуулсан билээ” (3 Нифай 11:11) хэмээн Тэрбээр тэдэнд хэлжээ.

Тэгээд Тэрбээр хүссэн хэнийг ч болов Өөр уруу нь хүрч ирэн хамгийн сэтгэл уярам нэгэн зүйлийг биеэр мэдрэх боломжоор хангасан билээ. Их Эзэн хавирган талынхаа сорви, гар хөлөн дэх хадаасны ормуудад гараа хүргэж үзэхийг хүмүүсээс хүссэн нь Тэр бол “Израилын Бурхан, мөн бүх дэлхийн Бурхан, мөн дэлхийнхний нүглүүдийн төлөө егүүтгэгдсэнийг” (3 Нифай 11:14) тэд тодорхой мэдээсэй гэснийх юм.

Есүс шавь нартаа баптисм хүртээх, Ариун Сүнсний бэлэг өгөх, ариун ёслолыг гүйцэтгэх эрх мэдлийг олгожээ. Арванхоёр шавиар удирдуулан Өөрийн Сүмийг

байгуулах хүчийг Тэрбээр тэдэнд өгчээ.

Тэрбээр Хуучин Дэлхийд шавь нартаа заасан зарим тулгуур сургаалуудыг тэдэнд зааж, өвчтэй хүмүүсийг эдгээсэн. Тэрбээр Эцэгт хандан өвдөг сөгдөн, ер бусын хүчирхэг хийгээд ариунаас нь болж тэмдэглэн үлдээж ч чадаагүй тийм үгсээр залбирсан ажээ. Түүнийг сонссон хүмүүсийн сэтгэл догдлон, баяр хөөрөөр бялхмаар тийм хүчтэй залбирал байжээ. Хүмүүсийг хайрлах хайр мөн түүнд итгэх тэдний итгэлийн улмаас Есүс Өөрөө сэтгэл алдран уйлсан юм. Тэрбээр олон зууны дараа Өөрийнхөө Хоёр дахь Ирэлт уруу хөтлөх Бурханы ажлын тухай бошиглосон.⁴

Дараа нь Тэр хүүхдүүдийг Өөр уруугаа авчрахыг хүмүүсээс хүсэв.

“Мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.

“Мөн тэр үүнийг хийгээд тэрээр дахин уйлав;

Түүнтэй илүү адилхан болох хуч нь сайн мэдээний ёслолуудыг хүлээн авснаар ирдгийг Аврагч Өөрөө заасан юм.

Тэрбээр хүүхдүүдээ Өөр уруугаа авчрахыг тэднээс хүсэв. “Мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.”

“Мөн тэр олон түмэнд хандан ярьж, Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.

“Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг үзэв, мөн тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; мөн тэд доош ирж, багачуудыг эргэн тойрон хүрээлж, . . . мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулав” (3 Нифай 17:21–24).

Мормоны Номонд илчлэгдсэн Бурханы цэвэр хайр хийгээд уг хайрын хүч ийм юм.

Энэхүү хожмын өдрүүдэд бид Их Эзэний Сүмийн гишүүд болж, Түүний сайн мэдээ болон Мормоны Номтой байгаа нь мөн Түүний зарлигуудыг сахьж, Бурханы хязгааргүй хайрын тухай мэддэг нь бидний хувьд онцгой боломж юм. Бид Түүний хайрыг хэрхэн өөрсдийн хайр болгохыг мэддэг. Бид Түүний жинхэнэ шавь нар болсноор Түүнийхтэй адил хайрлах хүчтэй болно. Бид Түүний зарлигуудыг сахиснаар Түүнтэй илүү адилхан болно. Бид аливаа

үндэстэн, ястан, хэлтний хүмүүст хүрч тэдэнд тусалснаар бидний хайр өргөжин тэлдэг.

Бид Түүний үлгэр жишээч амьдралын төлөө нэгэн үзүүрт сэтгэлийн талархлаа өргөдөг байвал дараах судрыг амьдралынхаа жишиг болгож чадна: “Та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө, та нар Бурханы хөвгүүд [мөн охид] болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун. Тэрбээр хүрч ирэхэд бид түүнтэй адил байх болно, учир нь бид түүнийг байгаагаар нь харах болно” (Моронай 7:48).⁵ ■

ЭШЛЭЛ

- 1 Нифай 17:35-44; Мозая 7:20; Алма 9:9-11; 3 Нифай 5:20-22-ыг үз.
- Мормоны Номын эхний хуудас ; 1 Нифай 13:35-41; 2 Нифай 33:4; Мозая 1:2-7; Мормон 8:13-41-ийг үз.
- Иохан 10:16; 3 Нифай 15:11-24-ийг үз.
- (3 Нифай 13:14-15 -ыг үз).
- 1 Иохан 3:1-3-тай харьцуул.

ТҮҮНИЙ ХАЙРЫН ХҮЧИЙГ ТАНИН МЭДЭХҮЙ

Би коллежийн шинэхэн оюутан байхдаа Сүмд элсээд амьдралынхаа хэв маягийг өөрчилж чадсандаа санаа сэтгэл өөдрөг байж, сайн мэдээ амьдралыг минь өөд татсаныг мэдэрч билээ. Гэвч миний өнгөрсөн үе амьдралдаа хийж болох хөгжил дэвшилд саад болж байсныг би удалгүй мэдэрсэн. Тийм буруу сонголтууд хийж байхад Тэнгэрлэг Эцэг Өөрийн хаант улсыг байгуулахад туслуулахаар намайг яаж ашиглах юм бэ?

Нэг өдөр би Мормоны Номын сүүлчийн хуудсыг нээж, Моронайн салах ёс гүйцэтгэсэн дараах үгсийг уншиж билээ: “Тийм ээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлаг бусаас өөрсдөө татгалзагтун, мөн хэрэв та нар бүх бурханлаг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно, мөн хэрэв Бурханы ач ивээлээр та нар Христээр төгс аваас та нар Бурханы хүчийг яавч үгүйсгэж чадахгүй” (Моронай 10:32). Би эдгээр үгсийг гайхан, ширтэн харж байлаа. Эдгээр үгс үнэн гэдгийг Сүнс надад хэлж байгааг би мэдэрсэн. Бурхан намайг юунд ч ашиглахад тохирохгүй гэж боддог байснаас би өөртөө нөлөөлөх Түүний хүчийг хязгаарлаж байснаа ухаарсан юм.



Тэр цагаас хойш би “Бурханы хүчийг үгүйсгэхгүй” байж, өнгөрсөн үеийнхээ алдааг хүлээн зөвшөөрч, ирээдүйгээ итгэлтэйгээр харж явахаар шийдсэн. Өнгөрсөн үе дээрээ биш харин ирээдүйдээ илүү их анхаарал төвлөрүүлж, Есүс Христийн ариусгагч ач ивээлд итгэснээр, намайг хайрладаг Аврагчийн хайрыг би улам ихээр мэдэрч, илүү аз жаргалтай болсон.

Кристи Петти, Вашингтон, АНУ




МОРМОНЫ НОМЫН ТҮҮХ

Мормоны Номонд ямар үйл явдлууд болдог вэ? Судрын энэхүү гайхамшигт номон дахь бошиглогчид болоод түүхүүдийн тухай илүү тодорхой мэдэхийн тулд эдгээр зургуудыг ашигла.



Мормоны Ном Лихай хэмээх бошиглогчийн тухай өгүүлснээр эхэлдэг. Тэрээр Иерусалим дахь ёс бус хүмүүст наманчлахыг анхааруулсан ч, тэд түүнийг сонссонгүй. Их Эзэн Лихайд гэр бүлээ, эхнэр Сариа, дөрвөн хүү—Лемен, Лемүел, Сам, Нифай нарыг авч аглаг буйд уруу яв гэжээ. (1 Нифай 1–2-ыг үз.)



Лихай хөвгүүдээ гуулин ялтсууд дээр бичсэн судруудыг авчруулахаар гэдрэг буцаав. Тэдгээр ялтсууд дээр тэдний өвөг дээдсийн түүх болон Их Эзэн тэдэнд бичихийг зарлигласан бусад зүйлс байв. Лихай, Нифай хоёр тэдгээр ялтсуудыг сайн хадгалж хамгаалж байжээ. Тэд бас гэр бүлдээ тохиолдсон зүйлсийн тухай металл ялтсууд дээр бичсэн байжээ. (1 Нифай 3–5-ыг үз.)



Их Эзэн Лихайд гэр бүлээ авч аглаг буйдыг туулан амлагдсан нутаг уруу удирдах Лиахона гэдэг луужин өгчээ. (1 Нифай 16-г үз.)



Их Эзэн Нифайд Лихайн гэр бүлийг амлагдсан нутаг уруу авч явах усан онгоц барь гэж хэллээ. Нифай Их Эзэн болон аавыгаа дуулгавартай дагасан бол, Лемен, Лемүел хоёр тэгсэнгүй. (1 Нифай 17-г үз.)

Лихай болон түүний гэр бүл өөрсдийн барьсан усан онгоцоор амлагдсан нутаг уруу далайгаар хөвлөө. (1 Нифай 18-ыг үз.)



5

Лемен, Лемүел хоёр Их Эзэнийг болон эцгээ цаашид ч дуулгавартай дагасангүй. Тэдний үр удмынхныг леменчүүд гэдэг болов. Нифай Их Эзэнийг болон эцгээ цаашид ч дуулгавартай дагасан юм. Түүний үр удмынхныг нифайчууд гэх болов. (2 Нифай 4–5-ыг үз.)



6

Лихай, Нифай хоёрыг нас барсны дараа Нифайн дүү Иаков болон бусад хүмүүс чухал сургаалууд, үйл явдлуудын тухай уг ялтсууд дээр бичих үүрэг хүлээсэн ажээ. (Иаков 1-ийг үз.)




7

Енос нүглийнхээ төлөө уучлагдахыг хүсч залбирснаар уучлагджээ. (Инос 1-ийг үз.)




8




9

Хаан Бенжамин сайн мэдээг ард түмэндээ заахаар цамхаг барив. (Мозая 2–6-г үз.)



10

Ноа гэгч ёс бус хаан бошиглогч Абинадайг цаазаар аваачив. Гэвч Абинадайн сургаалаар Ноагийн тахилчдын нэг Алма хөрвөгджээ. (Мозая 11–17-г үз.)



11

Алма Ноа хааны шүүхээс зугтааж, сайн мэдээг бусад хүмүүст заан, тэдэнд баптисм хүртээж байлаа. (Мозая 18-ыг үз.)



12

Алмагийн хүү Бага Алма дуулгавартай байсангүй. Тэр бас түүний найз нар болох Мозаягийн хөвгүүд ёс бус байлаа. Тиймээс нэгэн тэнгэр элч тэднийг наманчил гэжээ. Алма болон Мозаягийн хөвгүүд наманчилж, амьдралынхаа үлдсэн хугацааг сайн мэдээг номлож өнгөрүүлсэн. (Мозая 27–28-ыг үз.)

Мозаягийн хүү Аммон, хаан Лемонайн хонин сүргийг хамгаалж, түүний итгэлийг олсны дараа олон лемен үндэстэнг хөрвүүлжээ. (Алма 17–19-ийг үз.)



13

Ахмад Моронай эрх чөлөөний тунхгийг бичиж, ард түмнийхээ эрх чөлөөг хамгаалахаар тулалдав. (Алма 46, 48-ыг үз.)




14

Хиламан 2000 зөв шударга, залуу эрчүүдийн армийг удирдав. (Алма 53, 56–58-ыг үз.)



15

Лемен үндэстэн Самуел гэгч бошиглогч Есүс Христ удахгүй төрнө хэмээн бошиглов. (Хиламан 13–16-г үз.)



16



19

Мормон гэдэг 10 настай хөвгүүн хожим нь том болсон үедээ ялтсууд дээр цэдгийг бичихээр сонгогджээ. Тэр 24 настайдаа бүх цэдгүүдээс хамгийн чухал түүхүүдийг түүвэрлэн нэг иж бүрдэл металл ялтас болгон нэгтгэж эхэлжээ. (Мормон 1-ийг үз.)




20

Мормон нас барахаасаа өмнө ялтсуудыг хүү Моронайдаа өгчээ. Моронай цэргийн жанжин байв. Тэр бол леменчүүд, нифайчуудын хооронд болсон агуу тулалдаанаас амьд үлдсэн сүүлчийн нифай хүн байлаа. (Мормон 6, 8-ыг үз.)



21


Моронай нас барахаасаа өмнө уг ялтсуудыг Кумора гэдэг газарт булжээ. Моронай ялтсуудыг булснаас хойш 1400 орчим жилийн дараа Иосеф Смит хэмээх 14 настай хөвгүүн аль сүм зөв болохыг мэдэхээр залбирсан юм. Иосеф Смит–Түүх 1:5–16-г үз.




22

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф Смит дээр хүрч ирэн, үй олон сүмээс аль нь ч үнэн хийгээд бүрэн гүйцэд биш гэдгийг түүнд хэлжээ. Иосеф Есүс Христийн үнэн Сүмийг сэргээхэд тусалсан юм. Иосеф Смит–Түүх 1:17–20-ийг үз.

Алс холын Бетлехемд Есүс Христ төрөв. Тэр Өөрийн сайн мэдээг зааж, хүмүүсийг эдгээн, адисалж, Өөрийн Сүмийг байгуулав. Эцэст нь Тэрээр цовдлогдож, амилав. (3 Нифай 1, 8–10-ыг үз.)




17




23

Моронай Иосеф Смит дээр хүрч ирэн, газарт булсан ялтсуудын тухай түүнд хэлэв. Иосеф Смит насанд хүрсэн үедээ тэдгээр ялтсуудыг авч, орчуулсан юм. Иосеф Смит–Түүх 1:27–54-ийг үз.



24

Иосеф Смит 21 насандаа Кумора гүвээ уруу очиж, Моронайн булсан газраас ялтсуудыг авсан ажээ. Иосеф Смит–Түүх 1:59-ийг үз.



25

Иосеф Смит Бурханы хүчээр ялтсууд дээрх бичээсүүдийг орчуулав. Тэрбээр энэ орчуулгыг хэвлүүлсэн юм. Түүний орчуулгыг Мормоны Ном гэдэг. (Мормоны Номын эхний хуудас болон удиртгалыг үз.) ■


18

Тэрбээр Амилсныхаа дараа зөв шударга нифайчууд болон леменчүүд дээр хүрч иржээ. Тэрбээр Иерусалимын эргэн тойрон дахь нутагт үйлдсэний адилаар тэдэнд Өөрийн сайн мэдээг зааж, тэднийг эдгээн, адисалсан ажээ. (3 Нифай 11–28-ыг үз.)



Зүүн талд: АММОН ЛЕМОНАЙ ХААНЫ СҮГЧИЙГ ХАМГААЛЖ БАЙГАА НЬ, АРНОЛД ФРАЙБЕРГ © 1951 ИР; ГАРЧИРСЭН НЬ, УОЛТЕР РЕЙН, СҮМИЙН ТҮҮХИЙН МҮЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ; ХӨӨР МӨНГӨН ЗАЛУУ ДАЧИЙН УЛАГДАХААР ЯВСАН НЬ, АРНОЛД ФРАЙБЕРГ, СҮМИЙН ТҮҮХИЙН МҮЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ; ЛЕМЕН ХҮН САМИЛ БОШИЛГОЖ БАЙГАА НЬ, АРНОЛД ФРАЙБЕРГ © 1951 ИР; МОРОН ЯЛТСУУДЫГ ХУРААНГУЙЛЖ БАЙГАА НЬ, ТОМ ЛАВЕЛЛ © 1993 ИР; БИ БУР ГАНЦААРА УЛДСЭН, УОЛТЕР РЕЙН, СҮМИЙН ТҮҮХИЙН МҮЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ; МОРОНАЙ ЯЛТСУУДЫГ БУЛЖ БАЙГАА НЬ, ТОМ ЛАВЕЛЛ © 1993 ИР; ЗУРГАЛЗЛИЙН АЖИЛ ХҮСЭЛ И, УОЛТЕР РЕЙН; БАРУУН ТАЛД, ТЭР АМИЛСАН, ДЕЛ ПАРСОН, ХРИСТ БА МОРМОНЫ НОМЫН ХҮҮДЭД, ДЕЛ ПАРСОН © 1993; ТЭНГЭР ЭЛН МОРОНАЙ ИОСЕФ СМИГ ДЭЭР ХҮРЧИРСЭН НЬ, ТОМ ЛАВЕЛЛ © 2003 ИР; КУМОРА ГҮВЭЭ, ЖОН ИЖНООТОН; ИОСЕФ СМИГ МОРМОНЫ НОМЫГ ОРЧУУЛЖ БАЙГАА НЬ, ДЕЛ ПАРСОН © 1996 ИР

МОРМОНЫ НОМЫН ОН



1 ЖАРЕДЧУУД

Энэ бүлэг хүмүүс МЭӨ 2200 оны орчим Бабелын Цамхгийг орхиж, Америк тивд иржээ. Тэд МЭӨ 600 оны орчим Кориантумраас бусад нь бүгдээрээ дайнд алагдах хүртэл цэцэглэн хөгжиж байсан ажээ. (Ифер 1–15-ыг үз.)



2 НИФАЙЧУУД

Лихайн бүлэг МЭӨ 600 оны орчим Иерусалимаас гарч, Америк тивд иржээ. Түүний үр удмынхан аажимдаа хуваагдаж салсан ажээ. Лихайг нас барсны дараа зөв шударга хүмүүс түүний хүү Нифайг дагаж умард зүг нүүсэн аж. Тэд нифайчууд хэмээн нэрлэгдэх болов. (1 Нифай 1–22; 2 Нифай 1–5-ыг үз.)

3 ЛЕМЕНЧҮҮД

Лихайг нас барсны дараа ёс бус хүмүүс түүний хүү Лементэй хамт үлдсэн бөгөөд тэднийг леменчүүд гэх болов. (2 Нифай 5-ыг үз.)

4 МЮЛЕКЧҮҮД

Зедекиа хааны хүү Мюлек МЭӨ 587 оны орчим нэг бүлгийг удирдан Иерусалимаас гарч Америк тивд хүрч иржээ. Тэд Кориантумрыг олсон аж. (Омнаи 1:14–21-ийг үз.)

5 МОЗАЯ₁

МЭӨ225 оны орчмоос нифайчууд ёс бус болсон учраас Мозая₁ хэсэг зөв шударга нифайчуудыг Зарахемла уруу дагуулж очин, мюлекчүүдтэй нийлжээ. Тэд өөрсдийгөө нифайчууд гэдэг байв. Мозая₁ тэдний зөв шударга хаан болов. Хаан Бенжамин бол түүний хүү юм. (Омнаи 1:12–23-ыг үз.)

6 ЗЕНИФ

МЭӨ200-гаад оны үед нифай хүн Зениф Нифайн нутгийг буцааж авахын тулд нэг бүлгийг өмнөд уруу удирдан очжээ. Зенифийг бүлэгтэйгээ очиход леменчүүд тэднийг боолчлолд оруулав. Хожим нь хаан Мозая₂ дээрх бүлгийг олохоор Аммоныг явуулахад Аммон Лимхай хааныг хөрвүүлсэн ажээ. (Мозая 7; 9–22-ыг үз.)

ТООЛЛЫН ДАРААЛАЛ



7 АЛМА₁
Зенифийн хүмүүсийн дунд төрсөн Алма₁, Ноа хааны ёс бус тахилчдын нэг болов. Ноа хааныг наманчлалд дуудсаны дараа бошиглогч Абинадай алагдав. Гэвч Алма, Абинадайн сургаалд итгэдэг байсан бөгөөд итгэгчдийн нэг бүлгийн хамт зугтааж, эцэстээ нифайчуудтай нийлжээ. (Мозая 11; 17–18; 23–24-ийг үз.)

8 АЛМА₂ БА МОЗАЯГИЙН₂ ХӨВГҮҮД
Залуу эрчүүд болох Алма₂ болон Хаан Мозаягийн₂ хөвгүүд Сүмийг устгахаар эрэлхийлж эхлэв. Тэнгэр элч тэднийг зэмлэхэд тэд наманчлав. Алма₂ зөв шударга удирдагч болов. (Мозая 27–29 -ийг үз.) Мозаягийн хөвгүүд леменчүүдийн номлогч болов. Тэд их амжилт олсны дараа Алматай нэгдэж, баярлав. (Алма 17–26-г үз.)

9 ГАДИАНТОНЫ ДЭЭРЭМЧИД
Нийгэм ёс бус, сул дорой болсон үед энэ нууц алуурчдын бүлгийн нөлөө хамгийн хүчтэй, харин нийгэм зөв шударга байсан үед хамгийн сул болж байжээ. МЭ 350-иад оны үед тэд нийт ард түмний аюулгүй байдалд заналхийлж байв. (Хиламан 2; 6; 4 Нифай 1:42–46-г үз.)

10 ЕСҮС ХРИСТ
Аврагч Иерусалимд Амилсныхаа дараа Америк тивд очин, хүмүүст үйлчилж, Өөрийн сайн мэдээг зааж, Сүмээ зохион байгуулсан юм. Түүний айлчлалаас хойш хүмүүс 250 жил амар амгалан амьдарч байлаа. (3 Нифай 11–28-ыг үз.)


11 НИФАЙЧУУД УСТГАГДАВ
Ёс бус явдал аажмаар газар авч, дайн самуун гарч, улмаар нифайчууд устгагдав. Амьд үлдсэн цорын ганц хүн Моронай нифайчуудын цэдгийг хөтөлж, нас барахаасаа өмнө газарт булсан ажээ. (4 Нифай 1:24–28; Мормон 8:1–8; Моронай 10-ыг үз.)





МОРМОНЫНО

Эртний бошиглогчид, түүхчид, удирдагчид өөрсдийн гэрчлэл болон түүхийг алтан ялтсууд дээр сийлдэг байжээ. Хожим нь Иосеф Смит Бурханы бэлэг ба хүчээр анхны ялтсуудын хураангуйг орчуулсан юм.



МЫГ ХЭН БИЧСЭН БЭЭ?



1823 оны 9-р сарын 21-ний орой тэнгэр элч Моронай залуу Иосеф Смит дээр хүрч ирэн алтан ялтсуудыг өгч, эдгээрийг Мормоны Ном хэмээн орчуул гэж түүнд хэлжээ. Дөрвөн жилийн дараа Иосеф эдгээр ялтсуудыг орчуулахаар авсан ажээ (Иосеф Смит—Түүх 1:27-54-ийг үз).



1827 оны 9-р сарын 22-нд тэнгэр элч Моронай Бошиглогч Иосеф Смитэд өгсөн Алтан ялтсууд



Мормоны Ном

Мормоны ялтсууд
(Мормон, Моронай хоёрын бичиж,
хураангуйлсан цэдгүүд)

Лацдагдсан хэсэг
(орчуулагдаагүй)

Эхний хуудас
1 Нифай
2 Нифай
Иаков
Инос
Жером
Омнаи
Мормоны Үгс
Мозая
Алма
Хиламан
3 Нифай
4 Нифай
Мормон
Ифер
Моронай




Мормоны Номын эхний хуудас бол цуглуулга буюу ялтсуудын номын зүүн гар талын хамгийн сүүлчийн ялтсаас авсан үгчилсэн орчуулга” гэж Иосеф Смит тайлбарлажээ (*History of the Church*, 1:71).

Орчуулгын анхны гар бичмэл 1829 онд, хэвлэлийн эх бэлтгэл 1829-1830 онд дуусч, 1830 онд Мормоны Номыг анх 5000 хувь хэвлэжээ.

Доорх хүснэгтэн дэх мэдээллийг Мормоны Номын өмнөх үг болон эх сэдвээс түүвэрлэн авсан болно.



Зүүн талдас: ЖЕП КАРКИЙН ГЭРЭЛ ЗУРАГ; МОРМОН ЯЛТСУУДЫГ ХУРААНГУЙЛЖ БАЙГАА НЬ ТОМ ЛАВЕЛЛ; ТЭНГЭР ЭЛЧ МОРОНАЙ ИОСЕФ СМИТ ГЭЭЖ ХҮРЧ ИРСЭН НЬ КРЕДИТ ДАЙМОНДИЙН ГЭРЭЛ ЗУРАГ; МОРМОНАЙ АЛТАН ЯЛТСУУДЫГ ӨГЧ БАЙГАА НЬ ГАРЫ КАП; ХУУЛБАРЛАЖ БОЛОЛТ ҮЙ; ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЭМИЛИ ЛЕЙШМАН; ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖОН ЛУК



МОРМОНЫ НОМ: Библийн хамт гэрчилдэг

“Хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүр батлагдах болно” (2 Коринт 13:1) гэсэн Библийн хуулийн дагуу, Мормоны Ном, Библи хоёул Есүс Христийн тухай гэрчилж, Түүний сайн мэдээний зарчмуудыг заадаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон “судрын гэрчүүд бие биенээ баталдаг. Мормоны Ном нь “та нар [Библид] итгэж болно хэмээх зорилготойгоор бичигдсэн юм; мөн хэрэв та нар [Библид] итгэх аваас та нар түүнчлэн [Мормоны

Номонд] итгэх болно” [Мормон 7:9] гэж нэгэн бошиглогч эрт үед бичсэнээр энэ үзэл баримтлал тайлбарлагдана. Нэг номных нь эшлэлүүд нөгөөд нь бас байдаг. Хоёр ном хоёул Бурхан амьд бөгөөд Өөрийн бошиглогчдод өгдөг илчлэлтээр дамжуулан хүүхдүүдтэйгээ ярьдгийг нотолдог” хэмээн заасан.¹

Библид заагддаг тулгуур сургаалууд Мормоны Номонд нэмэлт гэрчлэл болж дурдагддагийг харуулсан жагсаалтыг доор харуулав.

Бидэнд зориулсан Бурханы төлөвлөгөө

Библи, Мормоны Ном хоёул Бурхан бол Тэнгэр дэх бидний Эцэг гэдгийг заадаг. Тэрбээр “авралын төлөвлөгөөг” (Алма 24:14) бэлтгэсэн учраас бид Есүс Христийн Цагаатгалаар дамжин энэ төлөвлөгөөгөөр аврагдаж чадна.

Тэнгэр дэх хайраар дүүрэн Эцэг

Библи: “Танай зарим яруу найрагчдын “Бид бас Түүний үр удам” гэж хэлсэнчлэн, бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог” (Үйлс 17:28; мөн Дуулал 82:6; Еврей 12:9-ийг үз).

Мормоны Ном: “[Бурхан] хүүхдүүддээ хайртайг би мэднэ” (1 Нифай 11:17; 1 Нифай 17:36-г үз).

Үхэл ба сүнсний ертөнц

Библи: “Тэгээд тоос нь урьд байсан газар шороондоо буцаж, сүнс нь үүнийг өгсөн Бурхандаа буцах ажгуу” (Номлогчийн Үгс 12:7; 1 Петр 3:19–20; 4:6-г үз).

Мормоны Ном: “Бүх хүмүүний сүнс сайн эсвэл муу байлаа ч өөрсдөд нь амьдралыг өгсөн Бурханд, гэртээ аваачигддаг” (Алма 40:11; шүлэг 12–14-ийг үз).

Амилуулалт, амилалт

Библи: “Арьс минь устгагдсан хойно ч би махан биеэрээ Бурханыг харах болой” (Иов 19:26; Езекиел 37:12; 1 Коринт 6:14; 15:54-ийг үз).

Мормоны Ном: “Махан бодь маань элэгдэж, мөн үхэх ёстойг та нар мэддэгийг би мэднэ; гэсэн хэдий ч өөрсдийнхөө биеэр Бурханыг бид харах болно” (2 Нифай 9:4; 2 Нифай 9:12; Алма 11:43–45; 40:23-ыг үз).

Зарлигууд удирдамжаар хангадаг

Бурхан бидэнд зарлигууд өгдөг бөгөөд бид тэдгээрийг дуулгавартай дагаснаар адислагдах болно гэдгийг Библи заадаг. Мормоны Номын бошиглогчид бас зарлигуудыг цэдэглэж, дагадаг байлаа.



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Өөрсдөдөө бүү итгэ, харин шилдэг номнууд болох Библи хийгээд Мормоны Номыг судалж, чадахынхаа хэрээр бүх мэдээллийг олж ав. Үүний дараа Бурхантай нэгдэн нийлж, аливаа ялзрал, бохирдлоос өөрсдийгөө хол байлга. Тэгвэл Бүхнээс Дээдийн ивээл адислалууд та нарт ирэх болно.”

Ерөнхийлөгч Жон Тейлор (1808–1887), *Teachings of Presidents of the Church: John Taylor* (2001), 148.

Дуулгавартай байснаас ирдэг адислалууд

Библи: “Бидний үргэлжийн сайн сайхны төлөө мөн биднийг өнөөдрийнх шиг амьд байлгахын тулд ЭЗЭН эдгээр бүх зарлигийг дагахыг, өөрсдийн Бурхан ЭЗЭНээс эмээхийг бидэнд тушаасан. . . . Бид эдгээр бүх тушаалыг дагахдаа хянуур байх аваас тэр нь бидний зөвт байдал болно” (Дэд Хууль 6:24–25; Сургаалт Үгс 4:4; Иохан 14:21-ийг үз).

Мормоны Ном: “Хэрэв та нар Түүний зарлигуудыг дагавал та нар уг нутагт дэгжих болно хэмээн тэрээр та нарт амласан бөлгөө мөн тэрээр хэлснээсээ хэзээ ч ухардаггүй; тиймийн тул, хэрэв та нар түүний зарлигуудыг дагавал тэр та нарыг адисалж мөн та нарыг дэгжээх бөлгөө” (Мозая 2:22; 2 Нифай 1:20-ийг үз).

Арван зарлиг

Библи: Их Эзэн Арван зарлигийг Мосед илчилсэн юм (Египетээс Гарсан нь 20:1–17-г үз).

Мормоны Ном: Абинадай Арван зарлигийг Ноа хааны тахилчдад заажээ (Мозая 12:33–36; 13:12–24-ийг үз).

Аравны нэг

Библи: “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир” (Малахи 3:10; Левит 27:30-ийг үз).

Мормоны Ном: “Мөн энэ нь Абрахам түүнд аравны нэгийг төлдөг асан Мелкизедек байв; тийм ээ, бүр бидний эцэг Абрахам өөрийн бүх эзэмшлийн аравны нэгийг төлдөг байсан билээ” (Алма 13:15; 3 Нифай 24:8–10-ыг үз).

Баптисм ба Ариун Сүнс

Библи: “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” (Иохан 3:5; Марк 16:16; Үйлс 2:36–38-ыг үз).

Мормоны Ном: Ариун Сүнсний хүлээн авалтаар та нар ариусагдаж болохын тулд, эцсийн өдөр та нар миний өмнө толбоггүйгээр зогсож болохын тулд наманчлагтун” (3 Нифай 27:20; 2 Нифай 9:23; 31:5–9-ийг үз).

Есүс Христийн үүрэг зорилго

Библи, Мормоны Ном нь Бурханы Хүү, Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай гэрчилдэг. Аврагч бидний гэм нүглийг Өөр дээрээ авч, үхлийг ялсныг хоёр ном хоёул заадаг.



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Мормоны Ном . . . Библи үнэн гэдгийг тунхагладаг мөн энэ нь түүнийг нотолдог бөгөөд энэ хоёр ном нэг нь нөгөөгөө үнэн гэдгийг баталдаг.”

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877), *Teachings of Presidents of the Church: Brigham Young* (1997), 121.

Бурханы Төрсөн Ганц Хүү

Библи: “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16; Матай 16:16; Иохан 6:69-ийг үз).

Мормоны Ном: “Есүс Христ, тийм ээ, Хүү, Эцэгийн Төрсөн Ганц, ач ивээл, нигүүлсэл, мөн үнэнээр дүүрэн тэрбээр ирэх болно гэдгийг би мэднэ” (Алма 5:48; 1 Нифай 11:16–21; Мозая 3:5–8).

Бидний нүглийг цагаатгасан тухай

Библи: “Учир нь энэ бол нүглүүдийн уучлалын тулд олны төлөө урсгах шинэ гэрээний Миний цус” (Матай 26:28; Еврей 9:28; 1 Петр 3:18-ыг үз).

Мормоны Ном: “Болгоогтун, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хэний ч төлөө хуулийн шаардлагуудыг хангаж, тэрээр нүглийн золиослол болгон өөрийгөө өргөх ажгуу” (2 Нифай 2:7; 1 Нифай 11:33; Алма 34:8–10; 3 Нифай 11:14-ийг үз).

Бидний уй гашууг өөртөө авсан тухай

Библи: “Үнэхээр тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав” (Исаиа 53:4; Еврей 2:18-ыг үз).

Мормоны Ном: “Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; . . . тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сүл байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд буюу” (Алма 7:11–12; Мозая 14:3–5-ыг үз).

Үхлийг ялсан тухай

Библи: “Харин чухамдаа Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдоос анхны үр жимс мөн” (1 Коринт 15:20; Иохан 14:19; Үйлс 26:23-ыг үз).

Мормоны Ном: “Есүс Христэд, тэрбээр Бурханы Хүү, мөн тэрбээр иудейчүүдээр хөнөөгдсөн, мөн Эцэгийн хүчээр тэрбээр дахин боссон, тэгснээр тэрбээр булшны дээгүүр ялалт олсонд итгэгтүн” (Мормон 7:5; Мозая 16:7–8; Хиламан 14:17-г үз).

Есүс Христийн эртний сүм

Их Эзэн Өөрийн Сүмийг Иерусалимд болон Америк тивд үндэслэн байгуулсан билээ. Тэрбээр бошиглогчид, төлөөлөгчдөөр (элч нараар) дамжуулан Өөрийн хүмүүсийг зохион байгуулж, удирдагийг Библи, Мормоны Ном гэрчилдэг.

Бошиглогчид (Эш үзүүлэгчид)

Библи: “Үнэхээр Эзэн Бурхан зарц нар, эш үзүүлэгчдэдээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй” (Амос 3:7; Иеремиа 1:7; 7:25-ыг үз).

Мормоны Ном: “Бүх зүйлүүд Сүнсээр бошиглогчдоод мэдүүлэгддэг бөлгөө” (1 Нифай 22:2; Иаков 4:4–6).

Арванхоёр (Төлөөлөгч)

Библи: “Тэр шавь нараа Өөр уруугаа дуудаад, тэднээс арванхоёрыг сонгон, элч нар гэж нэрлэжээ” (Лук 6:13; Ефес 2:19–20; 4:11–14-ийг үз).

Мормоны Ном: “Та нарт тохинуулж, мөн та нарын зарц байхаар та нарын дундаас миний сонгосон эдгээр арванхоёрын үгсэд анхаарлаа хандуулах аваас та нар адислагдах болно” (3 Нифай 12:1; 1 Нифай 11:29-ийг үз).

Санваарын эрх мэдэл

Библи: “Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон” (Иохан 15:16; Матай 16:19; Лук 9:1–2; Еврей 5:4ийг үз).

Мормоны Ном: “[Алма] Бурханы жаягийн дагуу гараа тавин сүмийн дээр тэргүүлэх мөн хянах санваартнууд хийгээд ахлагчдыг томилон” (Алма 6:1; 2 Нифай 6:2; Моронай 3-ыг үз).



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Библийн судруудыг дэлхийн зүсэн зүйлийн философитой хольж хутган, жинхэнэ утгыг нь алдагдуулан Библийн ач холбогдлыг олон хүн бууруулж байгаа өнөө үед, хүүхдүүдийнхээ сүнсний сайн сайхан байдлын төлөө үргэлж санаа

тавьдаг бидний мөнхийн Тэнгэрлэг Эцэг Мормоны Ном гэж нэрлэгддэг судрыг орлуулахаар номыг Их Эзэний чиглүүлснээр Библид бошиглогчдын бичиж, ярьсан үнэнүүдийг хамгаалахын тулд бидэнд өгсөн нь юутай аз завшаантай тохиол билээ. . . .

“ . . . Бид энэхүү хоёрдахь гэрчээр дамжуулан эртний бошиглогчдын, чухамдаа Эзэн болон Түүний шавь нар хүмүүсийн дунд амьдарч, тэдэнд заадаг байсан сургаалуудын утга учрыг илүү тодорхой мэдэж болно. Энэ нь үнэнийг чин шударгаар эрж хайдаг бүх хүмүүст сүнслэг удирдамж болох бөгөөд, ариун судрын энэ хоёр номыг бидний нэгэн адил нэг ном гэж үзэн, хамтад нь судалбал, эдгээр нь үнэхээр уялдаа холбоотойг ойлгох болно.”

Ерөнхийлөгч Харольд Б.Лий (1899–1973), *Ye Are the Light of the World* (1974), 89, 91.

Нэмэлт судлах зүйлс

Энэ хүснэгт бол бүх талыг хамарсан жагсаалт биш. Та хувиараа болон гэр бүлээрээ судар судлахдаа Topical Guide (Сэдэвчилсэн Удирдамж) буюу Судруудын Удирдамжийг ашиглан Мормоны Ном, Библи хоёрт заадаг илүү олон зарчмыг энэ жагсаалт дээр нэмж болно. Түүнчлэн scriptures.lds.org.хаягаар орж онлайнаар судалж болно. ■

ЭШЛЭЛ

1. Рассел М.Нелсон, “Scriptural Witnesses,” *Лиахона*, 2007 оны 11-р сар, 43.



Ахлагч
Д.Тодд Кристофферсон
Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын

МОРМОНЫ НОМЫГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) “Хожмын Үеийн Гэгээнтнүүд Мормоны Номыг насан туршдаа уншиж судлах ёстой гурван агуу учир шалтгаан байдаг”¹ хэмээн хорин таван жилийн тэртээ бичжээ. Энэхүү гурван шалтгаан нь:

- Нэгдүгээр, Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу—Есүс Христийг гэрчлэх бидний гэрчлэлийн болон сургаалын тулгуур чулуу мөн.
- Хоёрдугаарт, Мормоны Ном манай өнөө үед зориулан бичигдсэн юм.
- Гуравдугаарт, Мормоны Ном Бурханд илүү ойр дотно болоход бидэнд тусалдаг.

Мормоны Номыг уншиж судлах эдгээр шалтгаанууд нь энэхүү хосгүй өвөрмөц судрыг судлах зарим арга замыг бидэнд зөвлөмж болгодог билээ.

Манай шашны тулгуур чулуу

Мормоны Ном нь Христийг гэрчлэх бидний гэрчлэлийн болон Түүний сайн мэдээний бүрэн байдлын тулгуур чулуу учраас үүнд агуулагддаг Аврагчийн олон сургаал түүний тухай гэрчлэлүүдэд онцгой анхаарал тавих нь чухал юм. Зарим хүмүүс хямд үнэтэй, шинэ Мормоны Номыг олж аваад Аврагч, Түүний үйлчлэл, үүрэг зорилгын тухай бүх шүлгүүдийг тэмдэглэх замаар уг номыг судалдаг. Энэ нь Есүс бол Бурханы Хүү гэдгийг гэрчлэх гүнзгий гэрчлэл болон бидний төлөө

Түүний хийсэн буюу хийсээр байгаа зүйлсийн төлөө талархах гүн талархлыг бий болгодог билээ.

Манай өнөө үед зориулан бичигдсэн нь

Мормоны Номыг зохиогчид ирээдүй үеийнхэнд хандан, ялангуяа хожмын өдрүүд дэх энэ үеийнхний тухай бодон бичсэн юм. Мормон нифайчуудын цэдгийг хураангуйлахдаа, бүх үйл явдлын “зууны нэгийг нь ч” (3 Нифай 5:8; Мормоны Үгс 1:5-ыг үз) оруулж чадаагүйг хэлсэн билээ. Моронай, “Хэдийгээр та нар үгүй ч, та нар өмнө минь буй мэтээр би ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ” (Мормон 8:35). Энэ хоёр зохиогч бас бусад зохиогчид ч, сүнсний нөлөөгөөр ажиллан хожмын өдрүүд дэх бидэнд юу агуу ашиг тустай болохыг бичсэн.

Тиймээс бид, “Яагаад эдгээр үгсийг оруулсан юм бол? Энэ нь өнөөдөр надад хэрхэн холбогдох вэ?” гэсэн асуултуудыг дотроо бодох ёстой. Жишээ нь, бид Аврагчийн Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх загварыг Мормоны Номноос олж болохыг Ерөнхийлөгч Бенсон ажигласан байна. Христийн шавь нар дайн дажинтай үед хэрхэн амьдардаг байсныг, хавчлага, урвалтыг хэрхэн даван туулж, номлолын ажлыг яаж хийдэг байсныг, түүнчлэн материал баялгийг шүтэх үзэлд хэрхэн хариулдаг байсныг бид мэднэ.² Бид судар судлахдаа Нифайн нэгэн адил судруудыг өөрсөдтэйгөө



СУРСААР БАЙХЫН ТУЛД ҮРГЭЛЖ СУДАЛ

Би Мормоны Номыг анх уншихдаа гишүүн байгаагүй. Тэгэхэд би 16-тай байсан бөгөөд номыг долоо хоногийн дотор уншиж билээ. Номыг уншиж дуусахынхаа алдад хэрэв аль нэг сүм Христийнх байх юм бол Түүний нэрээр нэрлэгдэх ёстой гэсэн шүлгийг олж үзлээ (3 Нифай 27:8-ыг үз). Тэр агшинд хацрыг минь даган нулимс урсаж билээ. Мормоны Ном үнэн гэдгийг мэдээд би баптисм хийлгэхээр шийдсэн.

Баптисмынхаа дараа би Мормоны Номыг дахин уншлаа. Харин энэ удаад тодруулагч худалдаж аван, надад сүнслэг нөлөө үзүүлсэн шүлгүүд болон хэсгүүдийг тэмдэглэлээ. Түүнээс хойш судар уншихдаа би тэмдэглэгээ хийдэг болсноос гадна судрын зах дээр тэмдэглэсэн шүлгүүд дээр нэмэлт тайлбар бичдэг болов. Дараагийн удаа шүлгүүдэд холбогдох эшлэлүүдийг Мормоны Ном болон бусад жишиг бүтээлүүдээс нэмлээ.

Нэгэн жилийн эхээр би шинэ судрын ном худалдаж авлаа. Судрын энэхүү номыг номлолынхоо үеэр олон хичээлд бэлтгэхэд ашигладаг байсан учир олон өнгийн будгаар хийсэн тэмдэглэгээгээр дүүрсэн байсан юм. Энэ удаад миний судалгаа болон тэмдэглэгээ сэдвүүдээр хийлээ. Сэдэв бүрийг нэг өнгөөр жишээ нь, итгэлийг улбар шар, наманчлалыг ногооноор будаж тэмдэглэлээ.

Эдгээр олон янзын аргыг хэрэглэн Мормоны Номыг байнга судалснаар уг номыг зөвхөн унших нь хангалтгүй юм байна гэдгийг би ойлгосон. Бид энэ номыг байнга судалснаар алхам алхмаар мэдлэгтэй болдог. Бид энэ номыг олон удаа уншсан ч гэсэн, “Яагаад би үүнийг өмнө нь хараагүй юм бол?” гэж гайхахад хүргэх ямар нэг зүйл үргэлж гарч ирдгийг би бас мэддэг болсон. Ийм зүйл байнга тохиолддог.”

Судрууд, ялангуяа Мормоны Ном Есүс Христийн тухай, Тэнгэр дэх Эцэгийн тухай бидэнд заадаг. Судруудыг судлах нь намайг Тэдэнд улам ойртуулдаг.

Кристина Вергара Рамирез, Чили

“адилтгадаг” (1 Нифай 19:23-ыг үз) нь Мормоны Номноос олж мэдсэн зүйлээ амьдралд хэрхэн хэрэгжүүлэхийг мэдэх зорилготой юм.

Бурханд илүү ойртох нь

“Мормоны Ном бидэнд зөвхөн үнэнийг заадаг төдийгүй энэ ном үнэн гэдгийг батлан харуулдаг. Мормоны Ном зөвхөн Христийн тухай гэрчилдэг төдийгүй, энэхүү гэрчлэл үнэн гэдгийг батлан харуулдаг. Бас үүнээс ч илүү зүйл бий.

Энэ номыг нягт няхуураар судалж эхлэх мөчөөс та нарын амьдралд урсан орох хүч үүнд бий.”³

Чухамдаа Мормоны Номыг судлах нь



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Би диконы насанд хүрэхээсээ өмнө Мормоны Номыг уншиж эхэлсэн. Тэр үеэс хойш би энэ номыг үргэлж уншаар байгаа. Иймээс би үүнийг үнэн гэдгийг мэднэ. . . .

“ . . . Энэ Сүмийн аль ч гишүүн Мормоны Номыг олон дахин уншиж, тал бүрээс нь тунгаан бодож, энэ ном бол үнэхээр Бүхнийг Чадагчийн Сүнсний нөлөөгөөр бичигдсэн цэдэг бөгөөд үүний түүх нь үнэн гэдгийг гэрчлэх хүртлээ хэзээ ч санаа нь амардаггүй юм шиг надад санагддаг.”

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит (1876–1972), *Conference Report*, 1961 оны 10-р сар, 18.

Сүнснийг урьдаг бөгөөд Сүнс бол илчлэлт хүлээн авах арга хэрэгсэл мөн. Чухам иймээс бид энэ номыг уншиж судлахдаа залбирч, буурь суурьтайгаар тал бүрээс нь тунгаан бодохын сацуу тэмдэглэл хийх хэрэгтэй. Энэ нь бидний судалж байгаа болон бусад асуудлуудаар нэмэлт гэрэл, ойлголттой болох нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Зарим үед Мормоны Номын түүх болон захиасын утгыг ерөнхийд нь ойлгохын тулд харьцангуй богино хугацаанд бүхэлд нь унших нь ашиг тустай байдаг. Гэвч номноос өдөр бүр тогтоосон тооны шүлэг буюу хуудсуудыг уншихын оронд өдөр бүр уншиж судлахад тодорхой цагийг зориулах нь дээр юм.

Судлах гарын авлага, материалууд

Мормоны Номыг уншиж, судлахад туслах нэлээд олон гарын авлага, материалууд бидэнд байгаа нь сайхан хэрэг. Зарим хүмүүс *Topical Guide* (Сэдэвчилсэн Удирдамж), *Bible Dictionary* (Библийн Толь бичиг), англи хэлээр нийтлэгдсэн судруудын индекс, бусад хэлүүдээр хэвлэгдсэн Судруудын Удирдамжийг судруудынхаа хамт ашигладаг. Мөн хуудас болгондоо олон зүүвэр тайлбар, харьцуулах эшлэл бүхий Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хэвлэсэн судрууд бидэнд байдаг.

Хэвлэгдсэн бусад гарын авлага, судлах материалуудад Ням гарагийн хичээлийн гишүүний судлах удирдамж, Семинарын суралцагчийн судлах удирдамж, Институтийн суралцагчийн гарын авлага орно. Өнөө үед бидний хувьд шинэ зүйл болох 31-р хуудсанд дүрслэн харуулсан электрон хэрэгслүүдийн багтаамж улам бүр өсөн нэмэгдэж байна.

Хөрвүүлгийн зэмсэг

Мормоны Ном бол Их Эзэн манай эрин үед зориулан төлөвлөж, бий болгосон юутай ч зүйрлэшгүй эрдэнэсийн сан хөмрөг, хөрвүүлгийн зэмсэг юм. Үүнийг би Есүс Христийн тухай, Иосеф Смитийн бошиглогчийн дуудлагын тухай, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол “энэ дэлхий дээр нэгэнтээ дахин байгуулагдсан Их Эзэний хаант улс” мөн гэдэг миний гэрчлэлийн үндэс суурь гэдгийг хүлээн зөвшөөрч байна.⁴ Би өөрийн гэрчлэлийг “Чиний Их Эзэн мөн чиний Бурхан амьдын адил энэ нь үнэн бөлгөө” (С ба Г 17:6) гэсэн Есүс Христийн гэрчлэлтэй нэгтгэж байгаадаа баяртай байна. Мормоны Номыг насан туршдаа уншиж судлах үйлс тань таны хөрвөлтийг гүнзгийрүүлж, таныг мөнх амьдрал уруу шулуун замаар хөтлөх болтугай. ■

ЭШЛЭЛ

1. Эзра Тафт Бенсон, “Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу” *Ensign*, 1986 оны 11-р сар, 5–7. Энэхүү сонгодог үг энэ сэтгүүлийн 52-58-р хуудсуудад дахин хэвлэгдсэн ажээ.
2. Эзра Тафт Бенсон, *Ensign*, 1986 оны 11-р сар, 6–7-г үз.
3. Эзра Тафт Бенсон, *Ensign*, 1986 оны 11-р сар, 7.
4. Мормоны Номын удиртгал

ИНТЕРНЕТ БОЛОН ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ХЭРЭГСЛҮҮД ДЭХ СУДРУУД

Судруудыг компьютер болон харьцуулах эшлэлүүдээр хурдан судлах боломжтойгоос гадна онлайнаар (scriptures.lds.org) болон хөдөлгөөнт холбооны хэрэгслүүдээр (mobile.lds.org) хувиараа судлахад тань тусалж болох нэлээд хэдэн хэлбэрээр хангаад байна:



Миний судалгааны тэмдэглэл (notebook.lds.org)

Онлайн судалгааны энэ тэмдэглэлийн дэвтэр нь жишээлбэл, уламжлалт будаж тэмдэглэх, тэмдэглэл хөтлөх, эшлэлүүдийг харьцуулж судлах зэрэг олон аргыг санал болгохын сацуу дээрх электрон файлуудыг эргэн ашиглах боломжийг олгож хадгалдаг байна. Түүнээс гадна, та тэмдэглэлээ төрөлжүүлэх буюу “зүйлчилж,” агуулгаар нь ангилж болно. Та My Study Notebook-ийг өөрийн LDS account-д нэвтэрч орж ашиглах учраас таны тэмдэглэлийн дэвтэрт хийсэн нэмэлт өөрчлөлтүүд та хэчнээн электрон хэрэгслийг ашиглаж, эдгээрт нэвтэрч байгаагаас үл хамааран шинэчлэгдэх болно. Эдгээр арга хэрэгслүүд нь сайн мэдээг судлах болон заахад сэдэвчилсэн өвөрмөц архивыг бий болгоход танд тусална.



Судруудын формат ба хэл (scriptures.lds.org)

Судруудын электрон бичвэр болон аудио бичлэгүүдийг LDS.org вэб хуудаснаас олон хэлээр хүлээн авах боломжтой бөгөөд өөр бусад хэлээр удахгүй үзэх боломжтой болно.

Онлайнаар уншиж, сонсохоос гадна та аудио бичлэг, ePub болон PDF файлуудыг хуулж аван ашиглаж болно. Сүмийн хамгийн сүүлчийн үеийн онлайн дахь судрын сайтууд нь судрын хэсгүүд, хувийн тэмдэглэлүүдээ э-мэйл болон мэдээллийн бусад хэрэгслүүдээр дамжуулан бусадтай хуваалцах явдлыг хөнгөвчилж байна.

LDS.org-д судруудыг эдүгээ 21 хэлээр тавиад байгаа бөгөөд холбооны хөдөлгөөнт хэрэгслүүдийг платформоос хамааран ойролцоогоор 10 хэлээр ашиглаж байна.



ХҮГ Судрын эшлэлийн индекс (scriptures.byu.edu)

Бригам Янгийн Их Сургуулийн хоёр багшийн зохион бүтээсэн энэ судлах удирдамж нь өнөө үеийн бошиглогчид, төлөөлөгчдөөс хэн нь судрын шүлгүүдийг хэлсэн үгэндээ эш татсаныг харуулдаг. Жишээ нь, та ерөнхий чуулган дээр 1 Нифай 3:7-г хэн эш татсаныг мэдэхийг хүсч болно. Дэлгэцийн зүүн тал дээрх Book of Mormon link дээр эхлээд, дараа нь 1 Nephi 3 дарахад хариу нь гарч ирнэ.



Ерөнхий чуулганы сэдвүүдийн индекс (conference.lds.org)

Судрын судалгааг амьд бошиглогчдын үгстэй холбоход тань туслах өөр нэг удирдамж бол ерөнхий чуулган бүрийн сэдэвчилсэн жагсаалт conference.lds.org юм. Жишээ нь, хэрэв та судруудаас Цагаатгалын талаар судалж байгаа бол 2011 оны дөрөвдүгээр сарын чуулганаар л гэхэд таван ярианд уг сэдэв тусгагдсаныг олж мэдэх болно.



Лихайн зүүд

ТӨМӨР БАРИУЛАДС ЗУУРАН БАРЬ

Мормоны Номын зонхилох сэдэв бол хүн бүхнийг Христэд ирэхийг урьсан урилга бөгөөд энэ нь Лихайн үзэгдэл дэх үндсэн сэдэв юм.



**Ахлагч Давид
А.Беднар**

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын



Би Мормоны Номонд дуртай. *Эмма Марр Петерсен*ий бичсэн Хожмын Үеийн Залуу Гэгээнтнүүдэд зориулсан Мормоны Номын түүхүүдээс ээж надад уншиж өгдөг байсан нь хүүхэд ахуй үеийн минь сайн мэдээний дуртгал болон үлдсэн. Хүүхэд ахуй үеийн туршлага болон насан туршдаа хувиараа байнга судар судалж, залбирснаар Мормоны Ном бол Бурханы үг мөн гэдэг гэрчлэлийг Ариун Сүнс бодгальд минь дахин дахин шингээсэн юм.

Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ гэдгийг би гэрчилж байна. Бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг Бурханы хүчээр орчуулсныг би мэднэ. Мөн Мормоны Ном бол “энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүгээр үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болно” гэдгийг би гэрчилж байна.¹

Лихайн зүүдэн дэх хамгийн чухал бэлгэдлүүд

Ер нь судруудыг, энэ тохиолдолд Мормоны Номыг уншиж, судлан шинжилж, тунгаан бодохын ач холбогдлыг амьдралын модны тухай Лихайн зүүдний нэлээд хэсгээс тодорхой харагддаг (1 Нифай 8-ыг үз).

Лихайн зүүдний онцлог бол “Бурханы хайрыг” төлөөлсөн амьдралын мод юм (1 Нифай 11:21–22-ыг үз). “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16). Ийнхүү, Их Эзэн Есүс Христийн төрөлт, амьдрал, цагаатгагч золиослол нь хүүхдүүдээ хайрлах Бурханы хайрын агуу илрэл мөн. Нифайн гэрчилсэнчлэн энэ хайр бол “бүхнээс илүү, хамгийн ихээр хүслийг татагч” бөгөөд түүний үзэгдэлд тэнгэр элчийн хэлсэнчлэн, “сэтгэлийг үлэмж агуу баяраар дүүргэдэг” (1 Нифай 11:22–23; 1 Нифай 8:12, 15-ыг үз).



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Мормоны Ном бол үнэхээр Бурханы үг мөн гэдгийг, тэнгэр газрын хооронд харилцаа холбоо дахин нээгдсэнийг, Христэд үнэнээр итгэгч бүрийн хүлээн авч болох хэрэгтэй бүх мэдлэг болон адислалуудыг харуулагч Их Эзэний зөв зам дэлхийн хүмүүст илчлэгдсэнийг би та нарт гэрчилж байна.”

Ерөнхийлөгч Давид О. МакКей (1873–1970), “Marks Pointing to Authenticity of Book of Mormon,” *Instructor*, 1952 оны 10-р сар, 318.

1 Нифайн 11-р бүлэг нь Аврагчийн амьдрал, үйлчлэл, золиослол буюу “Бурханы хүлцлийн” (1 Нифай 11:16) бэлгэдэл болсон амьдралын модны тухай тодорхой дүрсэлсэн байдаг.

Уг модны жимс нь Цагаатгалын адислалуудын бэлгэдэл юм. Амьдралын модны жимснээс хүртэх нь Цагаатгал бидний амьдралд үр өгөөжөө бүрэн өгөхийн бэлгэдэл болсон ёслолууд болон гэрээнүүдийг хүлээн авахыг төлөөлдөг. Уг жимсийг “хүртсэн нэгнийг жаргалтай болгох дур булаам” (1 Нифай 8:10) хэмээн дүрсэлсэн бөгөөд энэхүү баяр баяслыг бусадтай хуваалцах хүслийг төрүүлдэг.

Мормоны Номын зонхилох сэдэв бол хүн бүхнийг Христэд ирэхийг урьсан урилга бөгөөд энэ нь Лихайн үзэгдэл дэх үндсэн сэдэв юм. Төмөр бариул амьдралын мод уруу хөтөлдөг нь онцгой сонирхолтой байдаг (1 Нифай 8:19-ийг үз). Төмөр бариул бол Бурханы үг.

Барих нь төмөр бариулаас зууран барьж явахын эсрэг юм

Эцэг Лихай зүүдэндээ дөрвөн бүлэг хүмүүсийг харжээ. Гурван бүлэг хүн амьдралын мод болон жимсэнд нь хүрэхийн тулд нарийн бөгөөд давчуу замаар урагшилж байлаа. Харин дөрөв дэх бүлэг уг модонд хүрэхийг хичээсэнгүй агуу хийгээд нүсэр барилгыг тэдний хүрэх ёстой эцсийн цэг гэж үзсэн ажээ (1 Нифай 8:31–33-ыг үз).

Урагш тэмүүлж, амьдралын мод уруу хөтөлсөн зам дээр гарсан эхний бүлэг хүмүүсийн тухай бид 1 Нифай 8:21–23-аас мэддэг. Гэвч тэр хүмүүс “чөтгөрийн уруу таталт” (1 Нифай 12:17) болох харанхуй манантай тулгарсан үед замаа алдаж, төөрөн тэнүүчилсэн билээ.

Эдгээр шүлгүүдэд төмөр бариулын тухай дурдаагүйг ажиглагтун. Бурханы үгийг үл тоомсорлож, түүнд хөнгөн хуумгай ханддаг хүмүүс Аврагч уруу хөтөлдөг бурханлаг луужин буюу зүг чиг заагч уруу нэвтэрч

ТЭДНИЙГ АНХААРСАН НЬ ҮГҮЙ

“Бид тэднийг анхаарсан нь үгүй болой” (1 Нифай 8:33) гэсэн хэсгээс би насан туршдаа сүнслэг хүч чадлыг олж байгаа билээ. 1 Нифайд зарим хүмүүс амьдралын модны зүг явах замдаа тэднийг шоолон тохуурхах хүмүүсийг анхаараагүй юм. Тэднийг хүмүүс хуруугаараа заан шоолж байсан ч тэд эргэлзэж тээнэгэлзээгүй, тэдний үгийг сонсоогүй. Үүн лүгээ адил өнөөдөр уруу татагч, янз бүрийн чанга дуу хоолой бидэнд сонсогддог. Заримдаа эдгээр дуу хоолойнуудад анхаарал тавихгүй байх нь маш хэцүү байдаг ч энэ нь боломжтой гэдгийг Лихай харуулсан.

Дэлхийн дуу хоолойнуудыг ариун сүмд орж, судруудаа уншиж, сүмд явж, бошиглогчийг дагаж байхдаа чимээгүй болгон өнгөрүүлж болдгийг би мэдсэн. Би эдгээр энгийн зүйлсийг хийснээр Ариун Сүнсний дуу хоолойг сонсох боломжтой байдаг. Энэ бол сонсвол зохих дуу хоолой. Ийнхүү Сүнсний дуу хоолойг анхааран сонссоноор би уруу таталтыг тэсэн гарах илүү их хүч чадлыг олдог.

Бид Лихайн үлгэр жишээг дагаж, “тэднийг . . . анхаарахгүй” байвал нарийн бөгөөд давчуу зам дээр байж, Бурханы хайрыг байнга хүртэж чадна.

Мелисса Хитон, Юта, АНУ



чаддаггүй. Энэ бүлгийнхэн Христэд итгэх итгэл болон сүнсний зохих хэмжээний итгэл үнэмшлийг харуулан замаа олж, урагш ахьсан ч, чөтгөрийн уруу таталтанд автагдаж, төөрсөн юм.

1 Нифай 8:24–28-аас бид амьдралын мод уруу хөтөлдөг нарийн бөгөөд давчуу замыг олсон хоёр дахь бүлэг хүмүүсийн тухай мэддэг. Энэ бүлэг “харанхуй манан дундуур зүтгэн урагшилж, ойртон бүр уг модны жимснээс тэд хүртэх хүртлээ төмөр бариулаас барьсаар явах ажээ” (шүлэг 24). Гэвч тансгаар хувцасласан агуу хийгээд нүсэр барилгын эзэд энэхүү хоёр дахь бүлгийн хүмүүсийг шоолон тохуурхахад “тэд ичингүйрхсэн болой” мөн “тэд хориглогдсон замаар будилан орж мөн төөрч байв” (шүлэг 28). Энэ бүлгийнхэн төмөр бариулаас “*барьсаар*” (1 Нифай 8:24; онцлон тэмдгэлт нэмэгдсэн) явсныг ажиглагтун.

Хоёр дахь бүлгийн хүмүүс итгэл, шийдвэр төгс байдалтайгаар урагшилж байсан нь бахархуштай юм. Тэдэнд бас төмөр бариулын давхар адислал ирснээс үүнээс барьсаар байжээ! Гэвч тэд хавчлага, бэрхшээлтэй тулгарсан үед хориглогдсон зам

уруу орж төөрсөн ажээ. Энэ бүлгийнхэнд итгэл, тууштай байдал, бүр Бурханы үг байсан ч эцэстээ төөрсөн нь магадгүй тэд судруудыг зөвхөн *хааяа нэг* уншдаг *буюу судалдаг* байсных биз ээ. Төмөр бариулаас барих гэдэг нь Бурханы үгийг нягт няхуураар байнга шимтэн судлахын оронд тогтмол биш, зөвхөн олдсон дээр нь “*оволзтол*” судлахын нэр шиг надад санагддаг.

Бид 30-р шүлгээс гурав дахь бүлгийн хүмүүс урагшлан, “уг модны жимснээс хүртэх хүртэл төмөр бариулаас үргэлж тууштай зуурсаар урагш зүтгэсэн” тухай уншдаг. Энэ шүлэг дэх түлхүүр нийлэмж үг бол төмөр бариулаас *үргэлж тууштай зуурсаар* гэдэг үгс юм.

Гурав дахь бүлгийнхэн бас итгэл бишрэл, үнэмшилтэйгээр урагшилж байсан ч замаас гарч будилан, хориглосон замаар орж төөрсөн талаар үзүүлэгдсэн нь үгүй. Гурав дахь бүлгийн хүмүүс судруудыг *байнга* уншиж, судалж эсвэл *тунгаан боддог* байсан бололтой. Гурав дахь бүлгийнхэн “өчүүхэн бөгөөд энгийн [зүйлд]” (Алма 37:6) няхуур нямбай, буурь суурьтай ханддаг байсан нь тэднийг мөхлөөс аварсан бололтой. Энэ

Хоёрдугаар бүлгийн хүмүүс итгэл, гуйвшгүй байдал, Бурханы үгийн хамт нарийн бөгөөд шулуун замаар тууштай явж, төмөр бариулнаас зуурч явсан хэдий ч эцэстээ төөрсөн нь тэд судрыг хааяа л нэг уншиж, судалдаг байсных биз ээ.



Төмөр бариулаас баттайгаар барих гэдэг нь байнга залбиралтайгаар, чин сэтгэлээсээ ариун судруудыг уншин удирдамж авч, амьдралын мод түүнчлэн Аврагч Есүс Христ уруу очно гэсэн үг юм.

бүлгийн хүмүүс “доош унаад мөн уг модны жимснээс хүртсэнээр” (1 Нифай 8:30; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) даруу байдлаас ирдэг сүнсний бэлгээр адислагдан, судруудыг итгэл бишрэлтэйгээр судалснаараа “Их Эзэний мэдлэг,” “үнэний мэдлэгтэй” (Алма 23:5, 6) болсон биз ээ. Энэ бүлгийн хүмүүс “Христийн үгнээс [байнга] зооглон” (2 Нифай 31:20) агуу хийгээд нүсэр барилган дахь хүмүүс тэднийг шоолон тохуурхсаныг үл хайхарснаар сүнсний тэжээл, хүч чадлыг олсон бололтой (1 Нифай 8:33-ыг үз). Бид бүгд энэ бүлэгтэй нэгдэн нийлэхийг хичээн чармайх ёстой.

Нифайн ах нар ийн асуусан байдаг, “Бидний эцгийн үзсэн уг модны зүт удирдсан тэр төмөр бариул ямар утгатай вэ?”

Мөн [Нифай] тэдэнд хандан энэ нь Бурханы үг байсныг хэлэв; мөн Бурханы үгийг анхааран сонсох, мөн үүнээс зууран барих хэн боловч тэд хэзээ ч эрсдэх нь үгүй; бас хортны уруу таталгууд хийгээд галт сумнууд тэднийг устгал уруу удирдахаар харалган болгож давамгайлах нь ч үгүй” (1 Нифай 15:23–24; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Тэгэхлээр, төмөр бариулаас барих,

зууран барих хоёрын ялгаа юунд байна вэ? Төмөр бариулаас зууран барих нь түүнээс огт салахгүй байж, ариун судруудыг илчлэгдсэн үнэний баттай эх сурвалж, амьдралын мод уруу чухамдаа Их Эзэн Есүс Христ уруу хөтлөх нарийн бөгөөд давчуу замаар хөтлөх аяны найдвартай удирдамж хэмээн үзэж, залбирч, чин сэтгэлээсээ, байнга ашиглах явдал гэж би зөвлөж байна.

“Мөнхүү улиран тохиох дор миний эцгийн үзсэн тэр төмөр бариул нь Бурханы үг байсныг би мэдэв; тэр нь амьдралын усан оргилуур уруу эсвээс амьдралын мод уруу удирдах ажгуу” (1 Нифай 11:25).

Мормоны Ном өнөө үед зориулагдсан юм

Мормоны Ном нь өнөө үе болон бидний нөхцөл байдалтай холбоотой үнэнүүдийг дэлгэн тавьсан юм. Мормоны Ном бидний сүнслэг болон бодит амьдралд холбоотой болохыг Моронай онцлон тэмдэглэж: “Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч, та нар миний өмнө буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын

үйлийг мэднэ” (Мормон 8:35) гэжээ. Мормоны Номын гол зохиогчид Бурханы зөн билгийн мэдлэгээр өнөө үе болон бидний нөхцөл байдлыг угтан харснаар хожмын өдрүүд дэх дэлхийн оршин суугчдад чухал ач холбогдолтой сэдвүүд болоод жишээнүүдийг уг номонд оруулсан юм.

Дараах асуултыг нягт няхуураар мөн залбиралтайгаар тунгаан бодохыг би та бүхнээс хүсч байна: **Бидний амьдарч буй өнөөгийн дэлхийд сүнслэг байдлын хувьд хүчтэй байх боломжийг олгодог амьдралын модны тухай Лихайн үзэгдэл болон төмөр бариулаас *байнга зууран барих* зарчмаас би ямар сургамж авч, юу сурч болох вэ?**

Энэ чухал асуултын хариуг олохын тулд хичээнгүйлэн хөдөлмөрлөж, сүнслийн удирдамжийг эрэлхийлснээр та төмөр бариулаас *байнга зууран барихын* чухлыг зүрх

сэтгэл, оюун ухаан аль алинд нь Ариун Сүнслийн хүчээр илүү бүрэн дүүрэн ойлгох болно. Мөн та эдгээр сургамжуудыг амьдралдаа болон гэр орондоо итгэл бишрэл, хичээл зүтгэлээр хэрэгжүүлбэл адислагдах болно.

“Найдварын төгс гэрэлтэйгээр мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэхэд” бидэнд туслах Лихайн үзэгдлийн олон сургамжийг харах мэлмий, сонсох чих бидэнд байх болтугай. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно” (2 Нифай 31:20). ■

ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 64.

ЭНЭ ЗАМЫГ БҮҮ ОРХИ!

Эгч минь Сүмийг танилцуулахад сүм надад таалагдаж, тэгээд би удалгүй баптисм хүртсэн юм.

Би уншиж сураагүй ч, Мормоны Номыг нээж, хуудсуудыг нь эргүүлэн гүйлгэж хардаг байв. Энэ номын үгсийг уншихсан гэж маш их хүсдэг байж билээ. Нэлээд хожууг хүртэл баптисм хүртээгүй нөхөр маань намайг зүгээр л ном хараад сууж байгааг ажиглаад цагаа дэмий үрж байна даа гэв.


Маш их хэцүү байсан ч, Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар болон хүүхдүүдийнхээ туслалцаатайгаар би уншиж сурахаар чармайж байлаа. Мормоны Номыг унших нь үргэлж миний зорилго байж билээ.

Нэг удаа бүр ч хэцүү санагдаж, санаа сэтгэлээр унасан үед: “Энэ замыг бүү орхи!” гэсэн үгс тодхон сонсогдож билээ. Хүн байна уу гээд хартал хэн ч байсангүй.

Би биеэ даагаад уншдаг болж байгаа тухайгаа нэг өдөр охиндоо хэллээ. Охин минь надад итгэсэнгүй уншиж чаддаг болсноо харуулаач гэв. Намайг уншиж эхлэхэд охин минь баярласан гэдэг нь.

Миний зорилго бол Мормоны Номыг эхнээс нь дуустал унших байв. Би удаан уншдаг ч ойлгодог байлаа. Хамгийн гол нь би энэ гайхамшигтай номоор дамжуулан Сүнслийг мэдэрдэг байлаа.

Эдите Фелициано де Пауло Сан Пауло, Бразил



Ахлагч
Нийл Л.Андерсен
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын



МОРМОНЫ НОМ

Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэх нь

*Мормоны Ном биднийг болон гэр бүлүүдийг маань
Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг баяртай хүлээн авахад
урьдаг бөгөөд энэ нь гэр бүлүүдийг амжилт олоход
туслах зарчмуудыг хуваалцдаг.*

Нэлээд олон эрин зууны бошиглогчдын сургаалуудыг өөртөө багтаан, санваарын түлхүүрүүд сэргээгдэн, Израилын угсааны агуу цугларалт тохиох ирээдүйн цаг үед зориулан бичигдсэн Мормоны Ном нь дэлхийг Аврагчийн Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэж байна. (2 Нифай 25; 27; 3 Нифай 21-ийг үз). Нифай энэхүү ариун номыг “газар шорооноос хашгирах нэгний дуу хоолой” (2 Нифай 33:13) хэмээн дүрсэлсэн юм. “Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн” (Мормон 8:35) хэмээн Моронай тунхаглажээ.

Мормоны Номыг өнөө үед бас үүнээс хойших ирээдүй үед зориулан бичсэн. Сэргээлтээс хойших эхний 100 жилд Мормоны Ном 15 хэлээр, ойролцоогоор нэг сая хувь хэвлэгдсэн нь асар их тоо юм. Дараагийн 50 жилд (1930–1980 он) 41 хэлээр 25 сая гаруй хувиар хэвлэгдсэн байна. 30 жилийн өмнөх тэр үеэс хойш Мормоны Ном 107 хэлээр

125 сая хувиар түүний дотор Мормоны Номноос сонгон авсан түүврүүд хэвлэгдэн гарчээ. Бурханы хаант улс үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүс бүрд хүрч тархахад Мормоны Номын нөлөө үргэлжлэн өссөөр байх болно.

Мормоны бичсэн эхний хуудас уг номын гол зорилгыг тодорхойлдог. Уг номын анхдагч зорилго нь Лихайн хүүхдүүдийн үр удамд тусгайлан ханддаг явдал мөн. Эцсийн зорилго нь “Есүс бол Христ, Мөнхийн Бурхан гэдэгт [бүх хүмүүсийг] итгүүлэх (Мормоны Номын эхний хуудас) явдал мөн.

Манай өнөө үед энэ ном чухал

Есүс Христийн бас нэгэн гэрээ өнөө үед яагаад туйлын чухал вэ? Их Эзэн яагаад Библийн хүчирхэг тунхагалуудыг бататгах бас нэгэн гэрчийг гаргаж ирэх хэрэгтэй болсон юм бол?

Бид өөр ямар ч үетэй адилгүй үед аж төрж байна. Бидний өмнө аж төрж байсан аль ч үеийнхэн огт төсөөлөх аргагүй



Өнөөгийн дэлхийд Христийг эсэргүүцэгч Корихорынх шиг бардам, ихэмсэг үгсийг сонсох дуртай хүмүүс олон байна. Гэвч бидний зүрх сэтгэлд бат бөх шингэсэн Есүс Христэд итгэх итгэл нь жинхэнэ хөрвөлтөд хүргэдэг.

шинжлэх ухааны ололт амжилт, анагаах ухаан, харилцаа холбоо, тээврийн салбарт гарч, хүмүүсийн амьдралд ая тух нэвтэрлээ. Мэдээлэл технологийн үер дэлхийд бууснаар, гэр бүлийн түүхийн болон сайн мэдээг хуваалцах ажлыг үлэмж өргөжүүлэхийн сацуу порнограф, хүчирхийллийг өөгшүүлсэн видео тоглоом, болон “хуйвалдагч хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа [бусад] хилэнц хийгээд бодлууд” (С ба Г 89:4) газар сайгүй дэлгэрч байна. Бид дэлхийн ихээхэн хэсэгт хүмүүс материаллаг баялгийн эрхшээлд хүчтэйгээр автагдаж байгаа үед аж төрж байна.

Хэрэв бид болгоомжтой байхгүй бол энэхүү нөхцөл байдал нь үе үеийнхэнд мөнхийн ач холбогдолтой бөгөөд үнэн зарчмуудаас биднийг уруу татан холдуулж мэднэ.

1970-аад оны эхээр намайг Европт залуухан номлогч байхад Есүс Христийн бурханлаг чанарыг олон хүн хүлээн авсан байдаг учраас бид заадаг зүйлийнхээ



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Тэнгэрийн доорх бүхий л хүмүүний бүх мэргэн ухаан Мормоны Ном шиг ийм номыг зохиож, дэлхийд толилуулж чадаагүй юм. Энэ номын зарчмууд бурханлаг бөгөөд тэдгээр нь Бурханаас ирсэн. Тэдгээр зарчмууд хууран мэхлэгчийн оюун ухаанаас эсвээс роман бичигчийн оюун ухаанаас хэзээ ч гарч чадахгүй. Яагаад?” Яагаад гэвэл энэ номонд агуулагддаг амлалтууд болон бошиглолууд бүх дэлхийн нүдэн дээр биелэгдэж байна.”

Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф (1807–1898),
Teachings of Presidents of the Church: Wilford Woodruff (2004), 119.

ихээхэн хэсгийг Урвалтын тухай тайлбарлахаас эхэлдэг байв. 20 жилийн дараа намайг номлолын ерөнхийлөгчөөр эргэж ирэхэд номлогчид ярилцлагаа өөр байрдаар эхэлдэг болсон байв. Учир нь Есүс Христ бол бидний нүглийн улмаас амь насаа өгч, гурав дахь өдрөө амилсан Бурханы Хүү гэдэгт итгэх итгэл ихээхэн алдагдсан байлаа.

Өнөөгийн дэлхийд Христийг эсэргүүцэгч Корихорынх шиг бардам, ихэмсэг үгсийг сонсох дуртай хүмүүс олон байна:

“Яагаад та нар ямар нэгэн Христийг хүлээнэв? Учир нь нэг ч хүн ирэх түүний тухай юуг ч мэдэж чадахгүй.

“Болгоогтун, та нарын бошиглоууд гэж нэрлэдэг эдгээр зүйлүүд . . . эцэг өвгөдийн чинь мунхаг уламжлалууд болой.

“. . . Та нар харахгүй байгаа тэр зүйлийг мэдэж чадахгүй. . . .

“. . . Хүн бүр өөрийн суу билгийн дагуу дэгжиж, мөн өөрийн хүчний дагуу ялан дийлдэг” (Алма 30:13–15, 17).

Бид аюулгүй байж, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэн, энэхүү итгэлийг хүүхдүүд, ач зээ нарынхаа зүрх сэтгэлд шингээхийн төлөө гэр бүлээ бэхжүүлэхэд бидэнд тусламж хэрэгтэй байдаг. Бидний зүрх сэтгэлд бат бөх шингэсэн Есүс Христэд итгэх итгэл нь жинхэнэ хөрвөлтөд хүргэх бөгөөд хөрвөлтийн үр дүнд наманчлал, жинхэнэ ёсоор шавь болох хийгээд гайхамшиг, сүнсний бэлгүүд болоод эцсийг хүртэл зөв шударга байх явдал ирдэг. Энэ бол Мормоны Номын бурханлаг зорилгын нэг чухал хэсэг мөн.

Би залуу номлогч байх үедээ шашны нэг хуврагтай их сонин яриа өрнүүлж билээ. Тэрбээр бидэнд ярихдаа, Мормоны Ном нь Түүнийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнөх үйл явдлуудын тухай, Есүс Христийн тухай Түүний нэрийг ашиглан хэтэрхий илэрхий өгүүлсэн болохоор би энэ номыг хүлээн зөвшөөрч чадахгүй юм гэж билээ. Тэрбээр энэхүү илэрхий байдал нь Аврагчийн мөн чанарыг бүдгээр өгүүлсэн Хуучин Гэрээний загварыг дагаагүй хэмээн үзсэн байна.

Миний бодоход Есүс Христийн тухай зоримгоор тунхагласанд Мормоны Номын хүч оршино. Мэдээжийн хэрэг бид энэ ном бол Бурханы үг мөн гэдэг сүнсний гэрчлэлтэй болох ёстой. Гэхдээ нэгэнт ийм гэрчлэлтэй болсон цагт Христийн зорилго, Түүний амьдрал, Амилалтын үнэн бодит байдал, Түүнийг дагаж, мөнх амьдралтай болж Түүнтэй хамт байхын тулд юу хийх ёстой нь бидний өмнө туйлын тодорхой болдог.

БҮГД МОРМОНЫ НОМНЫ УЧИР

Би баптисм хүртсэнээс хойш хагас жил бөнгөрсөн ч, Мормоны Номын тухай бат бөх гэрчлэлтэй болоогүй байлаа. Нэг өдөр судар уншихаас дургүй хүрээд байтал “Судар унших хүсэл байхгүй байвал энэ чинь Сатан чамайг судар уншихыг хүсэхгүй байгаа хэрэг” гэж Сайн мэдээний зарчмуудын багш хэлснийг саналаа. Энэхүү анхааруулгын ачаар би Мормоны Номоо нээж, “Бурхан маань биднийг өөрсдийн маань аймшигт, нүгэлт мөн бузартсан байдлаас шүүрч авахаар тийм нигүүлсэнгүй хэмээн хэн бодох билээ?” гэж уншлаа. (Алма 26:17). Би Христийн үнэн Сүмийн гишүүн болохоосоо өмнө ямар байдалтай байснаа санасан учир дээрх үгс бодгалийг минь баяр баяслаар дүүргэсэн билээ. Их Эзэний Сүнс Мормоны Ном үнэн гэдгийг зүрх сэтгэлд минь гэрчиллээ.

Би бүрэн цагийн номлогч болохыг хүсдэггүй байсан бол тэр өдрөөс хойш бүх зүйл өөрчлөгдсөн юм. Үнэнийг мэдэх нь дэлхийд хэрэгтэй гэдгийг би хүчтэйгээр мэдэрсэн болохоор өөрийгөө ээлтгэж эхлэв. Тэгээд удирдагчидтайгаа уулзаж, номлолд үйлчлэх хүслийнхээ тухай яриу. Сүмийн гишүүн биш бөгөөд өөр хотод амьдарч байсан аав, ээж хоёртоо энэ тухайгаа тайлбарлан хэллээ. Тэгээд байгаа бүхнээ зарж, номлолынхоо хувцас хунарыг худалдаж авлаа. Үүний үр дүнд би 2003–2005 онуудад номлолд үйлчлэв.

Өнөөдөр манай гэр бүл—эхнэр, охин бид гурав үүрд мөнхөд лацдан холбуулаад байна. Энэ адислал ч Мормоны Номын талаарх миний гэрчлэлийн ачаар ирсэн юм. Мормоны Ном үнэнийг би мэднэ, учир нь энэ ном Их Эзэн Есүс Христийн тухай гэрчилдэг. Би энэхүү ариун цэдгийг унших үедээ Бурханд илүү ойртдог.

Адилсон Люцерио дос Сантос, Парана, Бразил



Нифайн үзэгдэл



Лихайн гэрчлэл



Хаан Бенжаминь
номлол



Абинадайн гэрчлэл

Мормоны Номон дахь Есүс Христийн тухай агуу сургаалуудыг уншиж, тунгаан бодох нь уг сургаалууд үнэн гэдэг гэрчлэлийг бий болгодог.

Есүс Христийн тухай гэрчлэл

Мормоны Номон дахь Есүс Христийн тухай агуу сургаалуудыг Ариун Сүнсний тусламжтайгаар уншиж, тунгаан бодох нь уг сургаалууд үнэн гэдэг гэрчлэлийг бий болгодог. Христийн тухай хүчирхэг сургаалууд: “Бурханы хүлцлийг мэдэх үү та?” (1 Нифай 11:16) хэмээн тэнгэр элч асуусан амьдралын модны тухай Нифайн үзэгдэл; “Ариун Мессиа, түүнд мөн түүгээр гэтэлгэл ирнэ; учир нь тэрээр ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн буюу” (2 Нифай 2:6) гэсэн Лихайн гэрчлэл; Тэр бол “их хаалганы сахиул . . . мөн тэрээр нэгээхэн ч зарцыг тэнд үл ажиллуулдаг” (2 Нифай 9:41) гэсэн Иаковын нэмэлт тайлбарыг би Мормоны Номноос шимтэн унших дуртай.

Шавь байх шинж чанарын тухай “Түүгээр хүмүүний аврал ирж болох тэр нэгээхэн ч нэр өгөгдөхгүй бас нэгээхэн ч өөр зам мөн нэгээхэн ч арга үгүй бөгөөд зөвхөн Төгс Хүчит Их Эзэн Христийн нэрээр мөн энэ нэр дээр буюу” (Мозая 3:17) хэмээн бидэнд заасан Хаан Бенжаминь сургаалыг бид гуйвалтгүй дагадаг билээ.

Итгэдэг зүйлсийнхээ төлөө амь насаа өгөхөд хүрсэн Абинадайн тухай бид ийн уншдаг:

“Гэвч амилуулалт буй, тиймийн тул, булшинд ялалт гэж үгүй, мөн үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм.

Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал болой; тийм ээ, хэзээ ч харанхуйлагдахгүй төгсгөлгүй тэрхүү гэрэл (Мозая 16:8–9).

Цагаатгал, шударга ёс, амьдрал дахь нигүүлслийн тухай Алма дараах нэн чухал сургаалуудыг авчирсан юм: “Нигүүлслийн төлөвлөгөө нь цагаатгал хийгдэхгүйгээр

улиран тохиогдох боломжгүй; тиймийн тул Бурхан нь төгс, шударга Бурхан мөн түүнчлэн нигүүлсэнгүй Бурхан байж болохын тулд нигүүлслийн төлөвлөгөө гүйцэлдүүлэхээр, шударга ёсны шаардлагыг хангахаар Бурхан өөрөө дэлхийн нүглийн төлөө цагаатгалыг нөхөн төлдөг” (Алма 42:15).

Мөн бид Аврагч Лихайн хүүхдүүд дээр хүрч ирсэн гайхамшигтай айлчлалын тухай уншдаг. Бид бас түүний хайр, өрөвч нинжин сэтгэл, сургаалууд, Түүний өөрийнх нь гэрчлэлийг мэдэрдэг:

“Энэ бол та нарт миний өгсөн тэр сайн мэдээ—Эцэг минь намайг илгээсний учир би Эцэгийнхээ тааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ. . . .

“Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд би загалмай дээр өргөгдсөний дараа би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн миний өмнө зогсож, тэд өөрсдийн үйлүүдээр сайн эсвэл хилэнцэт байх эсэхээрээ шүүгдэхээр Эцэгээр өргөгдөхийн тулд Эцэг минь намайг илгээсэн бөлгөө (3 Нифай 27:13–14).

Эцэст нь Мормон, Моронай хоёрын “Та нар . . . өөрсдийн бүх нүглүүд мөн алдсуудаас наманчилж, Есүс Христэд, тэрбээр Бурханы Хүү гэдэгт итгэхээ мэдэгтүн” (Мормон 7:5) гэсэн сүүлчийн уриалга байдаг. “Тийм ээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлаг бусаас өөрсдөө татгалзагтун; мөн хэрэв та нар бүх бурханлаг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч оюун, мөн чадлаар хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно” (Моронай 10:32).



Есүс Христ хүрч ирсэн нь



Мормон, Моронай на-
рын сүүлчийн уриалга

Гэр бүлийнхээ хүрээнд

Есүс Христ бол үнэхээр амлагдсан Мессиа—бүх хүмүүсийн амилуулалтыг тохиолгон, наманчилж, Түүнийг дагасан хүмүүсийг сүнслэг байдлын хувьд ариусгахаар дэлхийд илгээгдсэн Бурханы тослогдсон Хүү болох тухай энэхүү сүнслийн хүчирхэг, итгэл үнэмшил бүхий гэрчлэл нь гэр бүлийн түүхэнд төвлөрдөг.

Мормоны Ном дэлхийн зүйлсийг орхин Их Эзэний зөвлөгөөг дагах тухай эцэг-бошиглогч нь өгсөн илчлэлтэд анхаарлаа төвлөрүүлж байгаа эцэг эх, хөвгүүд охид бүхий гэр бүлийн тухай өгүүлснээр эхэлдэг. Энэ ном Есүс Христийн амлалт болон найдварыг хүүхдүүдийнхээ зүрх сэтгэлд шингээхийг хичээж байгаа эцэг эхчүүдийн тухай шастираар дүүрэн юм. Нэг үйл явдлаар би эцгүүдээс хөвгүүдээ өгсөн нийт бичгийн машинаар цохисон 52 хуудас зөвлөгөөг энэ номноос түүвэрлэн авч билээ. Эцэг эхчүүд нь, бүр хүүхэд ахуй үеэсээ дуулгавартай байсан хүүхдүүд тэрчлэн зарим тохиолдолд гэр бүлийнхээ дотор замаа олох шаардлагатай хүүхдүүд аль алинд нь Христэд итгэх итгэлийг болон Бурханы зарлигуудад дуулгавартай байхыг хэрхэн заадгийг бид Мормоны Номноос хардаг. Энэ бол өнөө үеийнхэн, бидний үр хүүхэд, гэр бүлүүдэд зориулсан сургамж юм.

Эмэгтэйчүүд, охидын онцгой үүргийн тухай ямар нэг хэмжээгээр дурдаагүй нь эртний судруудад нийтлэг тохиолддог зүйл юм. Гэвч тойруу утгыг нь сайтар бодвол тэдний мөнхийн хийгээд өнө удаан үргэлжлэх нөлөөг харж болно. Эмэгтэйчүүд, эхчүүдийн мэдрэмжийг “Бурханы өмнө үлэмж энхрий болоод ариун” (Иаков 2:7) хэмээн, түүнчлэн Хиламан залуучуудаас бүрдсэн армийнхаа хүч чадал сайн сайхан чанарт эхчүүд нь нөлөөлснийг дараах байдлаар дүрсэлсэн зэрэг эмэгтэйчүүд, эхчүүдийн тухай өгүүлсэн цөөн боловч өгүүлбэр байдгийг бид эрхэмлэн үнэлдэг билээ.

“Тэд зарлигийн үг бүрийг яг таг гүйцэтгэхдээ дуулгавартай мөн шаргуу байв; тийм ээ, мөн бүр итгэл

ХОЁР НОМ, НЭГЭН МӨНХИЙН ГЭР БҮЛ

Миний нөхөр гэр өөдөө ирж яваад гудамжнаас нэг цунх олсон юм. Гайхалтай нь цунхэн дотор нэг Мормоны Ном байжээ. Нөгөөх номыг гэртээ авчраад надад үзүүлэв. Тэрээр уг номыг хэсэг сонирхон уншиж байсан ч эцэстээ уншихаа больж хойш тавьсан.

Түүнээс хойш удалгүй нөхөр минь нас барав. Би тайтгарлыг эрж хайхын хамт үхлийн дараа амьдрал цааш үргэлжилдэг эсэхийг мэдэхийн тулд нэг сүмээс нөгөөд шилжин явсаар байлаа. Надад хариулт нь олдоогүй олон асуулт гарч ирэн эргэлздэг болов.

Тэгээд нэг удаа ажил уруугаа явж байтал явган хүний зам дээр нэг ном байхыг хараад Мормоны Ном болохыг танилаа. Энэ ном хайрт ханийг минь санагдуулсан учир би түүнийг гэр уруугаа авч явлаа. Би олсон номынхоо тухай нэг хүнд дурстал тэрээр намайг энэ номыг унш гэж зөвлөлөө.

Өдөр хоног өнгөрсөөр байв. Нэг орой би Хожмын Үеийн Гэгээнтэн эгчийндээ очлоо. Тэднийд бүрэн цагийн номлогчид ирчихсэн, “Би Бурханы хүүхэд” дууллыг дуулж байлаа. Номлогчид миний асуултуудад хариулж чадна гэдгийг би тэр даруй мэдсэн.

Номлогчийн ярилцлагуудыг авч, гэрчлэлтэй болсны дараа би баптисм хүртлээ. Өнөөдөр би Иосеф Смит Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёртой уулзсан гэдгийг эргэлзээгүйгээр гэрчилж чадна.

Нөхөр бид хоёр Мормоны Номыг олсон нь зүгээр нэг санамсаргүй тохиолдол байгаагүй гэдэгт би итгэдэг. Миний нөхөр амьд сэрүүн үедээ баптисм хийлгэж чадаагүй ч, би нөхөртэйгөө бас хоёр сайхан хүүхэдтэйгээ ариун сүмийн ёслолууд хийлгэснээр гэр бүлээрээ үүрд мөнх хамт байх болно гэдгийг мэдсэндээ баяртай байдаг. Мормоны Ном биднийг хамт байлгаж, бидний бодгальд амар амгаланг авчирсан билээ.

Мария Маш, Гватемала

НИФАЙН ХЭЭГДЭГ, КЛАРК КЕЛПИ ПРАЙЗ, МАХОНАГИЙН ТОДОРХОЙ ЗУЙЛС, АРНОЛД ФРАЙБЕРГ © 1951 ИРИ, ХААН БЕНЖАМИНЫ ХЭЛСЭН ҮГ, ЖЕДЕИ ВИНБОРТ, ХУУЛБАРЛАХ БОЛОХТҮЙ, АБИНАДАЙ НОВА ХААНЫ ӨМНӨ АРНОЛД ФРАЙБЕРГ © 1951, ТА НАР НАМАЙГ ҮГ ЭЛЖ САНАХАЙН ТУЛД, ГАРИ КАПП © 1998, ХУУЛБАРЛАХ БОЛОХТҮЙ, МОРИОН НЭГЭН ЦАГТ АГУУ БАЙСАН ҮНДСЭЭГЭНГЭЭ САЛАХ ЕС ГҮЙЦЭГЭЖ БАЙГАА НЬ, АРНОЛД ФРАЙБЕРГ © 1951 ИРИ

*Мормоны
Номын
шастууд
Есүс Христийн
амлалт болон
найдварыг
хүүхдүүдийнхээ
зүрх сэтгэлд
шингээхийг
хичээж байгаа
эцэг эхчүүдийн
тухай шастуу-
раар дүүрэн юм.*



бишрэлийнх нь дагуу энэ нь тэдэнд хийгдсэн бөлгөө, мөн эхчүүд нь тэдэнд заасан хэмээн тэдний надад хэлсэн үгсийг би санаж байна. . . .

Эдүгээ энэ нь миний тухайлан ярьсан тэдний итгэл байв; тэд залуу мөн тэдний оюун нь өөрчлөгдөшгүй, мөн тэд Бурханд найдлагаа үргэлж тавьдаг бөлгөө. . . .

“ . . . Бурхан тэднийг чөлөөлнө гэдэгт тэд эхчүүдээрээ сургагдсан байлаа.

“Мөн тэд эхчүүдийнхээ үгсийг надад давтаж хэлсэн нь: Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна” (Алма 57:21, 27; 56:47–48).

Мормоны Номын сургаалуудыг гэр бүлтэйгээ адилтган үзэхэд өөртөө туслахын тулд доорх асуултуудыг тунгаан бодохыг би та бүхнээс хүсч байна:

- Хүүхдүүд эцэг эхийнхээ итгэлээс зарчимч болон зөв шударга байдлыг олж хардаг байх хэрэгтэйг Мормоны Номын ямар хэсгүүд бидэнд заадаг вэ?
- Бид хүүхдүүдтэйгээ хуваалцахыг хүсч болох ямар зөвлөгөөг Мормоны Номонд эцгүүд хөвгүүддээ өгсөн байдаг вэ?
- Дуулгаваргүй хүүхдүүдтэй ажиллах талаар бид юу мэддэг билээ?
- Мормоны Номон дахь эцэг эхчүүд гүнзгий итгэл бишрэлээ хүүхдүүдтэйгээ хэрхэн хуваалцаж байна вэ?
- Итгэл бишрэл нэг үеийнхнээс нөгөө үеийнхэнд дамжин шилждэг талаар бид юу мэдэв?

Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээс өөр бусадтай хуваалцах илүү чухал зүйл гэж үгүй. Энэ нь энэ амьдралд тохиолддог сорилт бэрхшээлүүд болон хэцүү байдлаас ирдэг аз жаргал, ирэх ертөнц дэх мөнх амьдралын тухай ойлгуулдаг.

Энэхүү амин чухал итгэлээс биднийг болон гэр бүлүүдийг маань холдуулж мэдэх дэлхийн олон нөлөө байдаг. Мормоны Ном биднийг болон гэр бүлүүдийг маань Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг баяртайгаар хүлээн авахад урьдаг бөгөөд энэ нь гэр бүл өнгөтэй өөдтэй, амжилт бүтээлтэй байхад тусалдаг.

Мормоны Ном үнэн бөгөөд энэ номыг тэнгэр элч Моронай Их Эзэн Есүс Христийн удирдлага дор Бошиглогч Иосеф Смитэд өгснийг би гэрчилж байна. Энэ ном өнөө үе, бидний үр хүүхэд, ач зээ нарт зориулагдсан юм. Бид энэ номыг итгэл бишрэлтэйгээр өдөр бүр уншихад Их Эзэний Сүнс бидэнд дээр байж гэр бүлүүдийг маань үүрд адислах болно гэдгийг би амлаж байна. ■

ЭРТНИЙ ҮЙЛ ЯВДЛУУД ӨНӨӨ ҮЕД ХОЛБОГДОХУЙ

Би аливаа асуултын хариуг Мормоны Номноос үргэлж олж чаддаг. Энэ номыг уншиж судалснаас би олон зүйлийг сурч мөн надад олон сайн өөрчлөлт гарч байгааг мэдэрсэн.

Зургаан хүүхэд маань өсч том болсон тул одоо юу хийхээ саяхан эргэцүүлэн бодлоо. Тэнгэрлэг Эцэг надаар юу хийлгэхийг хүсдэгийг тунгаан бодлоо.

Нэг удаа тогтмол хийдэг судрынхаа уншлагаар Мормоны Номон дахь дайны түүхүүдийн нэгийг эхнээс нь дуустал уншив. Бусад зүйлсийн дотор гэр бүлүүдийг хамгаалах үйлсэд Моронай уриалан дуудсанд сэтгэл минь нэн их хөдөлж билээ (Алма 46:12-ыг үз). Нифайчууд гэр бүлээ хамгаалахад шийдвэр төгс байлаа. Би тэр түүхийг уншаад асуудал нь өөр ч гэсэн гэр бүлийнхээ төлөө тэмцэх тэрхүү зорилгыг амьдралдаа тавьж ажиллахаар шийдэж билээ. Энэ тохиолдол хувийн хийгээд эрхэм байлаа.

Мормоны Ном өнөө үед зориулагдан бичигдсэнийг би мэднэ. Би амьдралдаа удирдамж авахын төлөө энэ номыг сонгосондоо баяртай байдаг. Энэ ном үнэхээр төмөр бариул мөн (1 Нифай 8-ыг үз).

Ён Жунг, Солонгос



Итгэл • Гэр бүл • Халамж

Хэрэв бид эргэлзэхгүй аваас

Бид ер бусын эрэлхэг зоригтой, хүч чадалтай, үлгэр жишээч залуу эрчүүдийн тухай Мормоны Номноос уншдаг. “Тийм ээ, тэд үнэн мөн чанд байдлын эрс байв. Учир нь тэд Бурханы зарлигуудыг дагахыг мөн түүний өмнө зөв шударгаар алхахыг заалгасан байв.” (Алма 53:21). Эдгээр итгэлтэй залуу эрчүүд эхчүүдээ өөрсдөө үлгэр жишээ үзүүлэгчид, багш нар хэмээн үзэж хүндэтгэдэг байв.

Хиламаны дайчдын эхчүүд нь өнөө үетэй адилгүй үед амьдарч байсан юм. Тэдний нөхцөл байдал хүнд хэцүү, аюултай байсан бөгөөд залуучуудыг бие махбодын болон сүнсний эрх чөлөөгөө хамгаалахад уриалан дуудаж байлаа. Өнөөдөр бид “махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэрлэг газар дахь бузар муугийн сүнслэг хүчний эсрэг” (Ефес 6:12) тэмцэж байгаа дэлхийд аж төрж байна.

“Хэрэв тэд эргэлзэхгүй аваас, Бурхан тэднийг чөлөөлнө” (Алма 56:47) гэдэг үнэнийг Хиламаны дайчид мэдэж байсан бөгөөд энэхүү үнэнийг хүүхдүүдэд заадаг үлгэр жишээч, бат бөх итгэлтэй эцэг эхчүүд тэр үед маш их хэрэгтэй байлаа. Энэхүү үнэнийг зааж, энэ талаар үлгэр жишээ үзүүлэх нь өнөөдөр сонор сэрэмжийг шаардаж байна. Гэвч бид айх хэрэггүй. Бид хэн бэ гэдгээ бас Бурхан хэн бэ гэдгийг мэдэж, мөн Түүнтэй гэрээ хийсэн учир эдгээр дайчдын эхчүүд лүгээ адил бусдад агуу сайн нөлөө үзүүлэх болно.

Хиламаны 2060 дайчдын хүн нэг бүрд эхчүүд нь нөлөө үзүүлсэн нь лавтай. Гэвч эдгээр эхчүүд зөвхөн өөрсдөө ажиллаагүй нь тодорхой. Эдгээр эхчүүд бусад зөвт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй хамтран гэрээний хүчийг заахын тулд итгэл, үлгэр жишээгээ нэгтгэн ажилласан нь лавтай. Тэр үеийн залуу хүмүүс дайтахгүй байхаар хийсэн эцэг эхийнхээ гэрээг ойлгодог байжээ. Энэ нь боломжгүй мэт санагдсан үед ч хайр энэрлээр дүүрэн Тэнгэрлэг Эцэг эдгээр эцэг эхчүүдэд гэрээг сахих болон тэдний эрх чөлөөг хадгалан үлдээх арга замыг нээж өгсөн юм (Алма 56:5–9-ыг үз). Хүүхэд залуучууд түүний дотор бидний өөрсдийн үр хүүхэд, манай тойрог, салбарууд, орчин тойрны болон нийгэм хамт олны доторх залуу хүмүүс гэрээг ойлгож, үүнийг сахих явдлыг дэмждэг байхын тулд бид гэрээнүүддээ

Энэ материалыг судалж, гэрээр нь очигч заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Би юу хийж чадах вэ?

1. Өсвөр үеийнхэнд нөлөөлөх хүчээ ойлгож, үүнийг үйл ажиллагаандаа хэрэглэхэд нь би эгч нартаа хэрхэн тусалж болох вэ?

2. Өнөө үед тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдэд хариулахын тулд би Мормоны Номноос сүнсний ямар удирдамжийг олж болох вэ?

хүндэтгэлтэй ханддаг байх ёстой.

Биднийг гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандсан үед Тэнгэрлэг Эцэг замыг бэлтгэх болно. Бид гэрээнүүддээ чанд сахьж амьдрах ёстой. Жишээ нь, бид тогтмол залбирч, судруудыг судлан, ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичигтэй байж, даруухнаар хувцаслан, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахьж болно. Ингэсэн тохиолдолд, “Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна” (Алма 56:48) гэж бидний хүүхдүүд хэлэх болно, бас үүнийг мэдэх болно.

Өөрсдийнх нь хүч чадал Их Эзэний Цагаатгалаас ирдгийг хүлээн зөвшөөрдөг Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүд сорилт бэрхшээл, гутрал цөхрөл тохиолдсон үед ч бууж өгдөггүй. Бид гэрээгээ сахигчдын хувьд нэгэн өдөр өсвөр үеийнхнийхээ тухай “Би хэзээ ч тийм агуу зоригийг үзээгүй, үгүй, бүхний дунд ч үзээгүй билээ” (Алма 56:45) хэмээн хэлэхийн төлөө хүүхэд залуучуудыг өргөн, халамжлан хүмүүжүүлж, хамгаалахын төлөө хүч чармайлтаа дайчлан ажилладаг. ■

Жюли Б.Бек, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч.

Нэмэлт мэдээллийг
www.reliefsociety.org
.lds.org-аас үзнэ үү.

Судруудаас

Алма 53; 56–58



ХОЁР МЯНГАН ЗОРИГТ ДАЙЧИД

Урам зоригтойгоор ♩ = 96-100

Үгийг Бонни Харт Мюррэй
Аяыг Женис Кэпп Перри

1. Хоёр мян - ган зо - ригт дай - чид, хү - чит за - луу эр - чүүд Хо -
2. Эр'л - хэг зориг-оор - оо нэгд - сэн ах дүү энэ баат-руу - дад Ээж -
3. Ха - тан зо - риг-той баат-рууд ах Хи - ла - ман - тай хамт А -
4. Хоёр мян - ган зо - ригт дай - чид, зорил - гоо - соо ух - рал - гүй Бурх -

тол ол - ны - хоо тө - лөө дайт - хад бэ - лэн бол - сон юм. Бур -
үүд нь Бур - ханд ит - гэж найд - хыг заа - даг бай - сан юм. Үйлс
гуу ит - гэл зо - риг - той - гоор бат зог - соц-гоож бай - сан. Дайт -
ны хү - чээр байл - дан бүгд - ээ - рээ амьд ирц - гээ - сэн юм. Ит -

хан би - дэн - тэй хамт байна; бид ү - гийг нь дага - на. Бүгд
бод - лоо цэг - нэж бай - вал Бур - хан хам - гаал - на гэж Ээж -
хыг хү - сээ - гүй бо - ловч эрх чө - лөөг тэд сон - гож Хайрт
гэл нь тэ - дэнд хүч өгч, чад - лыг нь нэмж бай - сан. Бур -

а - миа алд - хаас айх - гүй зо - риг - той - гоор зогс - сон юм.
үүд нь тэ - дэнд заас - наар тэд Бур - ханд ит - гэх бол - жээ.
гэр бүл, Бурх - ны - хаа тө - лөө амь өр - сөн байлд - сан юм.
хан тэ - дэн - тэй хамт байл - даж тэд а - дис - лагд - сан юм.

© 2009, Бонни Харт Мюррэй ба Женис Кэпп Перри. Бүх эрх хамгаалагдсан.

Алма 53; 56-57

Энэ дууг хувиараа, арилжааны бус зорилгоор, сүм дээр болон гэр оронд ашиглахын тулд хуулбарлаж болно.
Энэ тэмдэглэл хуулбар бүр дээр байх ёстой.

Манай өнөө үед зориулсан сургаалууд



Их Эзэн бидний төлөө санаа тавьдаг

“Мормоны Номон дахь Иферийн номонд байдаг Их Эзэний дараах үгсийг надад сануулсан юм. Их Эзэний хэлсэн байдаг, “Би та нарыг далайн давалгаа, мөн урагш түрэх салхи, мөн ирэх үерийн эсрэг эс бэлтгэх аваас та нар энэхүү агуу

гүнийг гаталж эс чадна” [Ифер 2:25]. Ах эгч нар минь, Тэр биднийг бэлтгэсэн. Хэрэв бид Түүний үгсэд анхаарал тавьж, зарлигуудаар амьдарвал, юу ч хийж болдог бөгөөд ёс бус өнөө үед, устгах аюул бүхий далайн давалгаа, хүчит салхи, үертэй зүйрлүүлж болох үед бид эсэн мэнд үлдэх болно. Тэр бидний төлөө үргэлж санаа тавьдаг. Тэр бидэнд хайртай бас биднийг зөв зүйл хийхэд адислах болно.”

Ерөнхийлөгч Томас С. Монсон, “Closing Remarks,” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 109.



Есүс бол Христ

“Мормоны Ном нь Есүс бол Христ болох тухай бидэнд байгаа бичгээр илэрхийлэгдсэн, хамгийн хүчирхэг гэрчлэл мөн. Нифайн хэлсэн зүйл Ариун Сүнснийг хүлээн авахын үндэс байсан уу? Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл. Мормоны Номыг нэг л уншчих юм бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл бий болох уу? Хэрэв та Нифайг анхааралтай уншвал үүнд найдахгүй.

Энэ бол “Түүнийг хичээнгүйлэн эрэлхийлдэг бүх хүмүүст . . . зориулагдсан бэлэг мөн” хэмээн Тэрбээр хэлсэн. Хичээнгүйлэн гэдэг нь тогтмол гэсэн утгатай нь мэдээж юм. Энэ нь тунгаан бодож, залбирах гэсэн утгатай. Түүнчлэн залбирал нь үнэнийг мэдэхийн төлөө чин сэтгэлээсээ гуйх гэсэн утгатай нь мэдээж хэрэг. Үүнээс илүү нягт нямбай хандах чухал үйлс гэж үгүй биз ээ. Мөн ямар ч зүйлд ийнхүү байнгын хүч чармайлт гаргахгүй бол та бид амжилт олохгүй ээ.”

Ерөнхийлөгч Хенри nb} Б.Айринг, Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, “Going Home,” *Brigham Young University 1986–1987 Devotional and Fireside Speeches* (1987), 77–78.



Сайн мэдээг тунхаглахуй

“Сайн мэдээний захиасын гол бүрэлдэхүүн хэсгүүд бүх ариун судруудаад байдаг ч, тэдгээр нь Мормоны Ном болон Бошиглогч Иосеф Смитэд өгсөн илчлэлтүүдэд хамгийн тод томруун харагддаг. Түүний сургаал болон сайн мэдээгээр дамжуулан “мөнх амьдралтай болно” (С ба Г 14:7) гэдгийг Есүс Өөрөө энд тод томруунаар мэдэгдсэн юм.”

Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, “Have We Not Reason to Rejoice?” *Лиахона*, 2007 оны 11-р сар, 19.

Мормоны Ном өнөө үед бидэнд заавар өгөхийн тулд хадгалагдаж ирсэн “тодорхой болоод эрхэм үнэт зүйлсийг” (1 Нифай 13:40; 19:3-ыг үз) агуулдгийг бид эртний бошиглогчдоос мэддэг билээ. Эдгээр үнэнүүд Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг илүү тодруулж, илүү сайн ойлгуулдаг бөгөөд Мормоны Ном амьдралын сорилт бэрхшээл дундуур итгэл найдвар, хүч чадалтайгаар сэлэхэд нь суралцагчдад тусалдаг билээ. Дараах эшлэлүүдэд орчин үеийн бошиглогчид, төлөөлөгчид эдгээр чухал сургаалуудын тухай гэрчилсэн юм.



Бага насны хүүхдүүдийн баптисм

“Бага насны хүүхдүүд эхийн хэвлийд нүгэл дотор бүрэлдэж, мөнх бус амьдралд төрөлхийн гэм буруутай ирдэг гэдэгт [зарим хүмүүс итгэдэг]. Ийм сургаал буруу юм!

“Хэрэв би үнэнийг мэдсэн аваас, бага насны хүүхдүүдийн тань баптисмын талаар та нарын дунд арцалдаан байгаа юм” (Моронай 8:5) гэж Моронай бичжээ.

“Тэрбээр тэдний дундах санал зөрөлдөөнийг ‘арцалдаан’ гэж нэрлэн ийн бичжээ: . . .

“Өөрийн Гэтэлгэгч, өөрийн Их Эзэн, өөрийн Бурханы үгийг сонс.

Болгоогтун, би дэлхийд зөв шударгыг үйлдэгчдийг бус, нүгэлтнүүдийг нанманчлалд дуудахаар ирсэн билээ; эрүүлд эмчийн хэрэгцээ үгүй, харин өвчтэй тэдэнд; иймийн тул, бага насны хүүхдүүд эрүүл, учир нь тэд нүгэл үйлдэх чадваргүй юм, иймийн тул Адамын зүхэл, тэр нь тэдний дээр хүчгүй байхаар, тэднээс надаар зайлуулагдсан болой; . . .

“Мөн энэ байдлаар Бурханы үгийг Ариун Сүнс надад мэдүүлсэн буюу; иймийн тул, хайрт хүү минь, та нар бага насны хүүхдүүдэд баптисм хүртээх нь Бурханы өмнөх сүрхий элэглэл болохыг би мэднэ” (Моронай 8:7–9). . . .

“Түүний захидлыг бүхэлд нь унш. Энэ бол зөв сургаал.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер, “Reverence Invites Revelation,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 17.



Мормоны Номын сэрэмжлүүлгүүд

“Дайны шалтгаан, үр дагавар болон ямар нөхцөлд дайныг зөвтгөдөг тухай сургаж нь Мормоны Номноос бидний сурч мэдсэн зүйлс дотор багтдаг. Энэ номонд ард түмнийг хүч түрэмгийлэн захирахын төлөөх нууц хуйвалдааны гэм нүгэл болон аюулын тухай өгүүлсэн байдаг. Энэ нь бас Сатан үнэн бодитойн тухай өгүүлж, түүний ашигладаг зарим аргуудыг харуулсан юм. Энэ ном эд баялгийг зохих ёсоор ашиглахыг бидэнд зөвлөсөн. Энэ ном сайн мэдээний энгийн бөгөөд

эрхэм үнэт зүйлсийн тухай, Есүс Христийн үнэн бодит байдал ба бүх хүн төрөлхтний төлөөх Түүний цагаатгагч золиослолын тухай өгүүлдэг. Энэ нь эцсийн өдрүүд дэх Израилын угсааны цугларалтын тухай бидэнд мэдээлдэг. Мөн номлолын ажлын зорилго хийгээд зарчмуудын тухай бидэнд өгүүлдэг. Энэ нь бардам зан, хайхрамжгүй байдал, аливаа зүйлийг хойш нь тавих, буруу уламжлалын аюул, хоёр нүүр гаргах болон ариун бус явдлаас биднийг сэрэмжлүүлдэг.

“Ингэхлээр Мормоны Номыг судалж, үүний зарчмуудыг мэдэж, амьдралдаа хэрэгжүүлэх нь бидний үүрэг юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л. Том Перри, “Blessings Resulting from Reading the Book of Mormon,” *Лиакхона*, 2005 оны 11-р сар, 8.

ХОЁР САВАА НЭГ БОЛСОН НЬ

Би бараг л төрсөн цагаасаа хойш Библиэтэй байсан ч Мормоны Номтой болох хүртлээ сайн мэдээний бүх зарчмуудыг мэддэггүй байжээ. Есүс Христийн бүрэн сайн мэдээг зөвхөн энэхүү хоёр дахь “саваа”-наас мэдэж болно гэдгийг би олж нээсэн юм (Езекиел 37:15–17-г үз). Энэ хоёр саваа нэгдсэн үед амьдралыг өөрчлөгч туршлага буюу би хэн бэ гэдгийг түүнчлэн Бурханы мөнхийн гэр бүлийн хэсэг болох хэтийн төлөвөө гүнзгий ойлгоход надад туслах болно. “Чиний гарт тэдгээр нь нэг болно” гэсний дагуу энэ хоёр савааг нэгтгэх бошиглол, итгэлтэй хоёр эмэгтэй номлогч миний төлөө санаа тавьж, хоёр дахь савааг надад орхиж явснаас боломжтой болсон юм.

Урьд нь би лааны гэрлээр явж байсан бол одоо сөөм дэлэм газар ч гэсэн сайн мэдээний бүрэн адислалуудаар гэрэлтүүлэгдэж байна. Амьдрал шинэчлэгдэж, ачаа хөнгөрснийг мэдэрдэг боллоо.

Ари Сала, Британийн Колумб, Канад

ГЭР БҮЛ ҮҮРД ОРШИНО

Би 1995 онд баптисм хүртсэнээсээ хойш Мормоны Номыг байнга уншаар байна. Гэвч би гэрлэх хүртлээ Лихайн хөвгүүд Иерусалимаас явсан болон Иерусалимд буцаж ирсэн тухай хэсгийг өөрийн гэр бүлийн хувьд чухал учир холбогдолтойг ойлгоогүй байсан.

Их Эзэн Лихайг мөнхийн гэр бүлтэй болохыг хүссэн

юм шиг санагддаг. Тэрбээр Лихайд бүх юмаа орхиод харин *одоогийн*хоо гэр бүлийг амлагдсан нутаг уруу авч яв гэж эхлээд хэлжээ. Тэднийг цөлд ирээд байтал гэр бүлийнхээ гишүүдийн *өнгөрсөн үеийн* цэдгийг авчруулахаар хөвгүүдээ буцааж явуул гэж Их Эзэн Лихайд хэлжээ. Үүний дараа Тэр Ишмэил болон түүний охидыг авчруулахаар тэднийг буцаасан юм. Энэ бол тэдний *ирээдүйн*

Мормоны Номын тухай Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын бусад гишүүдийн гэрчлэлийг энэ дугаарын хуудас 10, 28, 32, 38, 80-аас үзэж болно.



Бүх зүйл сэргээгдэх болно

“Амиалалтын үнэн бодитой хийгээд ертөнц дахины мөн чанарыг Мормоны Номонд яруу тодоор дүрсэлсэн байдаг. Бошиглогч Амюлек ийн заажээ:

“Христийн үхэл нь энэ зуурдын үхлийн хүлээсийг тайлнаар, бүгд зуурдын үхлээс босгогдох болно.

“Сүнс мөн бие төгс хэлбэрээрээ дахин нэгдэх болно; бид одоо энэ цагт байгаа шигээ үе болон мөч аль аль нь зохих байдалдаа сэргээгдэх болно; . . .

“Эдүгээ, энэ сэргээлт нь бүгдэд,

настай мөн залуу аль алинд нь, боол мөн чөлөөт аль алинд нь эрэгтэй эмэгтэй аль алинд нь, ёс бусыг үйлдэгчид хийгээд зөв шударгыг үйлдэгчид аль алинд нь ирэх болно; мөн бүр тэдний толгойн үсний нэг ширхэг нь ч гээгдэхгүй болой; харин бүх зүйл төгс хэлбэрээрээ сэргээгдэх болно” (Алма 11:42–44).

“Амилуулалтаар ‘бүх зүйл өөрсдийн зохих мөн төгс хэлбэртээ сэргээгдэх болно’ (Алма 40:23) гэдгийг Алма мөн заасан юм. . . .

“Энэ амьдралд бүрэн бүтэн байгаагүй бүх хүмүүс . . . ‘зохих мөн төгс хэлбэртээ’ амилуулагдах болно гэдгийг мэдэх нь ямар их тайтгарал авчрах бол.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс, “Resurrection,” *Лиакхона*, 2000 оны 7-р сар, 17.



Нууц хуйвалдааны аюул

“Гэмт хэрэг үйлддэг нууц хуйвалдаан нь хувь хүмүүс болон гэр бүлүүдэд төдийгүй соёл иргэншилд бүхэлд нь ноцтой аюул учруулдгийг Мормоны Номонд заасан байдаг. Өнөө үеийн нууц хуйвалдаануудад бүлэглэсэн гэмт этгээдүүд, мансууруулах бодисын наймаа эрхлэгчид, зохион байгуулалттай гэмт хэргийн гэр бүлүүд орно. Өнөө үеийн

нууц хуйвалдаанууд нь Мормоны Номон дахь Гадиантоны дээрэмчидтэй нэн төстэй байдлаар ажилладаг. . . . Тэдний зорилго бол улс орныхоо хуулиудын эсрэг мөн Бурханыхаа хуулиудын эсрэг тэд алж, мөн тонож, мөн хулгайлж, мөн садар самуун, мөн бүхий л ёс бусыг үйлдэх” [Хиламан 6:23] явдал мөн.

“Хэрэв бид анхааралтай байхгүй бол өнөө үеийн нууц хуйвалдаанууд хүчээ авч, нөлөө нь Мормоны Номын үеийнх шиг түргэн өсөх болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М. Рассел Баллард, “Standing for Truth and Right,” *Ensign*, 1997 оны 11-р сар, 38.

гэр бүлийг бэлтгэсэн хэрэг байлаа.

Бидний мөнхийн гэр бүлийн одоо, өнгөрсөн, ирээдүйг холбосон гинжин холбоосыг Лихайн адил эрхэмлэн бий болгох нь миний нэн чухал үүрэг хариуцлага мөн. Дээрх үйл явдлууд Лихайг амьдралын модны тухай үзэгдэлд бэлтгэж, мөнхийн гэр бүлийн хүрээнд Бурханы хайр бий болон төлөвших ёстойг ойлгоход тусалсан биз ээ.

Салот Малани Мейвиривири, Хавай, АНУ



Амьдралын сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэх нь

“Мормоны Ном буруу уламжлалын нөлөөг хэрхэн залруулах болон хэрхэн сэтгэл дүүрэн амьдрахыг харуулсан бурханлаг захиасуудыг агуулдаг. Энэ ном өнөө үед бидэнд тулгарч байгаа асуудал, сорилт бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэхийг заадаг. . . . [Их Эзэн] амьдрал дахь ноцтой алдаануудыг залруулах арга замаар хангасан ч, хэрэв номыг нээж харахгүй энэ удирдамж тэндээ үлдэх юм бол үнэ цэнээ алдах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “True Friends That Lift,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 76.



Бидний гэрээний сануулагч

“Бидний баптисм бол ‘ямар ч цагт, мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы [мөн Түүний хаант улсын] гэрчлэгч болж, бүр үхэлд хүртлээ зогсоход бэлний учир мөнх амьдралыг авч болохын тулд Бурханаар гэтэлгэгдэж, мөн та нар анхны амилуулалтын тэдний дунд тоологдож [болно]’ (Мозая 18:9; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) гэдгийг Мормоны Ном бидэнд сануулдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д. Хейлс, “The Covenant of Baptism: To Be in the Kingdom and of the Kingdom,” *Лиэхона*, 2001 оны 1-р сар, 7.



Дуулгавартай байдлын адислалууд

“Хэрэв хүмүүс зарлигуудыг сахих юм бол уг нутагт цэцэглэн хөгжих болно гэдгийг Мормоны Номонд олон хэсэгт хүмүүст амласан байдаг [1 Нифай 2:20; 2 Нифай 4:4-ийг үз]. Энэ амлалт нь хэрэв тэд Бурханы зарлигуудыг сахихгүй бол Түүний оршихуйгаас таслагдах болно гэсэн сэрэмжлүүлэгтэй ихэвчлэн хосолсон байдаг [Алма 36:30-ийг үз].

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Квинтин Л. Кук, “Hope Ya Know, We Had a Hard Time,” *Лиэхона*, 2008 оны 11-р сар, 104.

ГЭРЛЭЭР УРАГШЛАХУЙ

Усан онгоцонд нь гэрэл байхгүйн улмаас Жаредын ахын санаа зовдгийг бид Иферийн 2-р бүлгээс уншдаг. Тэрээр энэ тухай Их Эзэнээс асуухад Их Эзэн: “Та нар гэрэлтэй байхын тулд намайг та нар юу бэлтгээсэй хэмээн хүсч байна вэ?” гэсэн асуултаар хариулдаг. (шүлэг 25)

Жаредын ах Их Эзэний асуултанд хэрхэн хариулсныг би олон удаа бодсон. Эхлээд тэр ууланд очиж, “16 жижиг чулууг хайлуулан гаргаж авав” (Ифер 3:1). Тэр эдгээр чулуунуудыг уулын орой дээр аваачиж, залбиран, Их Эзэний өмнө өөрийгөө даруусгажээ. Тэрбээр нигүүлслийг гуйж, залбиралд нь хариулах хүч Их Эзэнд бий гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Тиймээс тэр итгэлээ харуулан, “Та хүмүүсийн ойлголтонд өчүүхэн мэт харагддаг агуу хүчийг үзүүлж чадахыг бид мэднэ” (Ифер 3:5) гэж хэлжээ. Чулуунууд усан онгоцыг гэрэлтүүлэхийн тулд тэдгээрт гараа хүргэнэ үү гэж Жаредын ах Их Эзэнээс гуйдаг.

Судрын энэ хэсэг миний залбирдаг арга барилыг өөрчилсөн юм. Өмнө нь би “Аав аа, Та надаар юу хийлгэх вэ?” гэж ихэвчлэн асуудаг байлаа. Олон нөхцөл байдал, тохиолдолд би ямар нэг юмны тухай бодоод, боломж бололцоондоо дүн шинжилгээ хийж, үүнийхээ үндсэн дээр төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөө сайн болж уу? гэдгийг Тэнгэрлэг Эцэгээс асуугаад, өөрөө тохиолгон авчирч чадахгүй гайхамшгийг Түүнээс гуйн залбирдаг.

Елена Гомез де Сантюрион, Уругвай



Ерөнхийлөгч
Эзра Тафт Бенсон
(1899–1994)



МОРМОНЫ НОМ манай шашны тулгуур чулуу

Эзра Тафт Бенсон 1985 оны 11-р сарын 10-нд Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч болжээ.

Тэрбээр Мормоны Номын хүчний тухай бат бөх гэрчлэлээрээ болон өдөр тутам судар судлах, номлолын ажил болон сайн мэдээг заахад энэ ном туйлын чухал болох тухай захиасаараа нэрд гарсан юм. 1986 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр түүний үг хэлсний 25 жилийн ой энэ жил тохиож байна.

Хайрт ах, эгч нар аа, өнөөдөр би орчин үед дэлхийд өгөгдсөн хамгийн гайхамшигтай нэгэн бэлгийн тухай ярихыг хүсч байна. Миний бодож байгаа энэ бэлэг бол аж үйлдвэр, технологийн хувьсгалын үр дүнд бий болсон аль ч зохион бүтээлтээс хамгийн чухал нь юм. Энэ бол хүн төрөлхтний хувьд орчин үеийн анагаах ухаанд бидний харсан олон гайхамшигт амжилтаас ч илүү агуу үнэ цэнэтэй бэлэг мөн. Энэ нь хүн төрөлхтний хувьд нисэх хүчний хөгжил эсвэл сансрын нислэгээс ч илүү үнэ цэнэтэй юм. 156 жилийн өмнө хүн төрөлхтөнд өгөгдсөн агуу бэлэг—Мормоны Номын тухай би ярьж байна.



Энэ бэлэг Их Эзэний гараар мянга гаруй жилийн хугацаанд бэлтгэгдсэн бөгөөд өнөө үеийнхэнд зориулан цэврээр нь хадгалахын тулд Тэрбээр үүнийг нуусан ажээ. Өнөө үед зориулсан судрын энэ номын ач холбогдлыг Их Эзэний Өөрийнх нь хэлсэн үгсээс илүү томруунаар гэрчлэх юу ч байхгүй биз ээ.

(1) Тэрбээр энэ ном үнэн гэдгийг (С ба Г 17:6), (2) энэ ном үнэн хийгээд Түүний үгсийг агуулдгийг (С ба Г 19:26), (3) энэ нь дээрээс ирсэн хүчээр орчуулагдсаныг (С ба Г 20:8), (4) энэ ном Есүс Христийн

сайн мэдээний бүрэн байдлыг агуулдгийг (С ба Г 20:9; 42:12), (5) энэ нь сүнсний нөлөөгөөр өгөгдөж, тэнгэр элчүүдийн үйлчлэлээр батлагдсаныг (С ба Г 20:10), (6) ариун судрууд үнэн гэдгийг энэ ном нотолсныг (С ба Г 20:11), түүнчлэн (7) энэ номыг итгэлээр хүлээн авсан хүмүүс мөнх амьдарна гэдгийг (С ба Г 20:14) Өөрийн амаар гэрчилсэн.

Мормоны Номын ач холбогдлын хоёр дахь хүчирхэг гэрчлэл бол Сэргээлт эхлэх цаг хугацааны голчид энэ номыг гаргаж ирэхээр байрлуулсан явдал юм. Уг ном ирэхээс өмнө тохиосон цорын ганц зүйл бол Анхны Үзэгдэл мөн. Энэхүү гайхамшигтай явдлын үеэр Бошиглогч Иосеф Смит Бурханы жинхэнэ мөн чанарыг тэрчлэн түүгээр хийлгэх ажил Бурханд байгааг мэдсэн юм. Мормоны Ном гарч ирсэн нь дагах ёстой дараагийн зүйл байлаа.

Энэ ном гарч ирсэн цаг үеийн тухай бодоод үз л дээ. Мормоны Ном санваарыг сэргээхээс өмнө гарч ирсэн. Энэ ном Сүм зохион байгуулагдахаас хэдхэн хоногийн өмнө хэвлэгдсэн. Алдар суугийн гурван зэрэглэл, селестиел гэрлэлт эсвэл нас барагчдын өмнөөс хийх ажил зэрэг агуу сургаалуудыг илчлэхээс өмнө Мормоны Номыг



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“[Мормоны Ном] бол Бурханы үг. Энэ бол Христийн тухай хоёр дахь хүчирхэг гэрчлэл мөн. Иймээс, Гэтэлгэгчийг хайрладаг үнэн итгэгч бүхэн Түүний бурханлаг чанарын нэмэлт нотолгоог баяртай хүлээн авах нь мэдээж юм.

“Энэхүү сүнслэг номонд эрх мэдэлгүй орчуулагчид хөндлөнгөөс оролцоогүй эсвээс шашны номлогчид өөрсдийн санааг хавчуулаагүй бөгөөд түүхчид хийгээд товчлон хураангуйлагчдаас дэлхийд цэврээрээ ирсэн юм. Энэ ном уншигчдаа сорьж туршдаггүй.”

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985), *The Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Эдвард Л.Кимбалл (1982), 133.

уншуулахаар Гэгээнтнүүдэд өгсөн ажээ. Энэ ном санваартны чуулгууд болон Сүм зохион байгуулагдахаас өмнө гарч ирсэн юм. Энэ бүхэн ариун судрын эл номыг Их Эзэн хэрхэн үзэж байсан талаар ямар нэг зүйлийг бидэнд хэлэхгүй байна гэж үү?

Их Эзэн энэ номын талаар ямар бодолтой байсныг ойлгох юм бол Тэрээр бас үүнийг бид хэрхэн хүлээн авах тухай үнэ цэнэтэй анхааруулга өгсөнд гайхах юун. Мормоны Номыг итгэлээр хүлээн авч, зөв шударга амьдарсан хүмүүс мөнх амьдралын титмийг хүлээн авах болно гэдгийг (С ба Г 20:14-ийг үз) харуулсны эцэст Их Эзэн дараах анхааруулгыг өгсөн билээ: “Тэвч итгэлгүй байдалд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн үүнийг эсэргүүцэх тэдэнд энэ нь өөрсдөд нь зэмлэл болж хувирах болно” (С ба Г 20:15).

1829 онд Их Эзэн Гэгээнтнүүдэд ариун нандин зүйлст хөнгөн хуумгай хандахгүй байхыг анхааруулжээ (С ба Г 6:12-ыг үз). Мормоны Ном үнэхээр ариун зүйл хэдий ч олон хүн үүнд хөнгөн хуумгай хандаж байна. Өөрөөр хэлбэл, энэ номыг өчүүхэн ач холбогдолтой зүйл гэж үзэн, үл тоомсорлож байна.

1832 онд анхны хэдэн номлогч хөдөлмөрийн талбараасаа эргэж ирэхэд Их Эзэн тэднийг Мормоны Номонд хөнгөн хуумгай хандсаных нь төлөө зэмлэсэн байдаг. Уг хандлагынхаа улмаас тэдний оюун санаа харанхуйлагдсаныг Тэрбээр хэлжээ. Энэхүү ариун номонд хөнгөмсгөөр хандсан нь зөвхөн тэднийг гэрлээ алдахад төдийгүй, харин Сүмийг бүхэлд нь, бүр Сионы бүх хүүхдүүдийг буруушаахад хүргэжээ. Иймээс Их Эзэн, “Мөн тэд наманчилж, тэрхүү шинэ гэрээ бүр Мормоны Номыг санах хүртэл энэхүү буруушаалт дор үлдэх болно” (С ба Г 84:54–57) гэжээ.

Бид зуун тавь гаруй жил Мормоны Номтой байгаа нь өнөөдөр бидний хувьд ялихгүй ач холбогдолтой зүйл гэж үү? Бид энэ шинэ гэрээ, Мормоны Номыг санадаг бил үү? Бидэнд Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ хоёроос бүрдсэн Библи байдаг. *Testament* (гэрээс, гэрээслэл) гэдэг англи үг нь *covenant*

(гэрээ) гэдэг грек үгний орчуулга юм. Энэ нь Их Эзэн Мормоны Номыг “шинэ гэрээ” гэж нэрлэсний утга учир уу? Энэ ном үнэхээр Есүсийн бас нэгэн гэрээ буюу гэрч мөн. Энэ бол бид саяхан Мормоны Номын нэрэнд “Есүс Христийн бас нэгэн гэрээ” гэдэг үгсийг нэмсний учир шалтгаануудын нэг юм.

Эхэн үеийн Гэгээнтнүүд Мормоны Номонд хөнгөмсгөөр хандсаныхаа төлөө зэмлүүлж байсан юм чинь бид мөн адил байснаараа тэднээс багагүй зэмлэл дор байгаа биш үү? Энэ ном мөнхийн ач холбогдолтой гэдэг гэрчлэлийг Их Эзэн Өөрөө хэлсэн. Бидний цөөхөн хүн ариун зүйлсэд хөнгөмсгөөр хандсаны улмаас Сүмийг бүхэлд нь буруушаан зэмлэхэд хүргэж болох уу? Хэрэв бид шинэ гэрээг умартсан хэмээн дүрслэгдсэн хүмүүсийн дунд байвал бид Түүний өмнө зогсож, Түүний сорьсон харцгай тулгарах Шүүлтийн үеэр юу гэж хэлэх бол?

Хожмын Үеийн Гэгээнтнүүд Мормоны Номыг насан туршдаа уншиж судлах ёстой гурван агуу учир шалтгаан байдаг.

Нэгдүгээрт Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу. Энэ бол Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн үг юм. “Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу” мөн гэдгийг тэрбээр гэрчилсэн.¹ Тулгуур чулуу бол нуман хаалганы төв дэх гол чулуу юм. Тулгуур чулуу нь бусад бүх чулууг тогтоон барьж байдаг бөгөөд энэ чулууг авбал нуман хаалга нурна.

Мормоны Ном манай шашны тулгуур чулуу болохыг батлах гурван зүйл байдаг. Энэ бол Христийн тухай гэрчлэх бидний гэрчлэл дэх тулгуур чулуу. Энэ бол бидний сургаалын тулгуур чулуу. Энэ бол гэрчлэлийн тулгуур чулуу.

“Мормоны Ном нь бидний хийж байгаа бүх зүйлийн булангийн чулуу болох Тэр, Есүс Христийн тухай бидний гэрчлэл дэх тулгуур чулуу мөн. Энэ ном Түүний үнэн бодитойн тухай хүчтэй, тод томруун гэрчлэлийг авчирдаг. Үг хэллэгт нь хөндлөнгөөс оролцсон олон үеийн бичээчид,



орчуулагчид, шашны ёс бус зүтгэлтнүүдийн гараар дамжсан Библиетэй адилгүй нь Мормоны Ном сүнслэгээр нөлөөлөгдсөн орчуулгын ганцхан үе шатаар дамжин зохиогчоос уншигчид ирсэн. Тиймээс Эзэний тухай энэ номын гэрчлэл тод томруун, хоёрдмол санаагүй, агуу хүчтэй юм. Бүр үүнээс ч илүү зүйл бий. Христийн ертөнцийн ихээхэн хэсэг нь өнөөдөр Аврагчийн бурханлаг мөн чанарыг үгүйсгэж байна. Тэд Түүний гайхамшигт төрөлт, Түүний төгс амьдрал, алдар суут Амилалтын үнэн бодитойд эргэлзэж байна. Мормоны Ном тэдгээр бүх үнэнүүдийн тухай энгийнээр, эргэлзэхийн аргагүйгээр заадаг. Энэ ном бас Цагаатгалын сургаалын хамгийн бүрэн гүйцэд тайлбарыг өгдөг. Бурханлагаар нөлөөлөгдсөн энэ ном нь Есүс бол Христ гэдгийг дэлхий дахинд гэрчлэх үнэхээр тулгуур чулуу мөн.²

Мормоны Ном бас Амилалтын тухай сургаалын тулгуур чулуу мөн. Мормоны Ном “Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг” (С ба Г 20:9) агуулдгийг Их Эзэн Өөрөө нотолсныг өмнө дурдсан билээ. Энэ нь урьд өмнө илчлэгдсэн сургаал бүрийг агуулдаг гэсэн хэрэг биш юм. Энэ нь


Бид өөрсдийн авралд шаардлагатай сургаалуудыг Мормоны Номноос бүрнээр нь олдог. Тэдгээр сургаалуудыг бүр хүүхдүүд ч гэсэн аврал, өргөмжлөлд хүрэх арга замуудыг ойлгож чадахаар энгийн байдлаар заасан байдаг.

бидний авралд шаардлагатай тэдгээр сургаалуудын бүрэн байдлыг бид Мормоны Номноос олж болно гэсэн үг юм. Тэдгээр сургаалуудыг бүр хүүхдүүд ч гэсэн аврал, өргөмжлөлд хүрэх арга замуудыг ойлгож чадахаар энгийн байдлаар заасан байдаг. Мормоны Ном авралын сургаалуудын талаарх бидний ойлголтыг өргөжүүлэн тэлэх маш их зүйлийг санал болгодог. Мормоны Номгүйгээр бусад судруудад заадаг зүйлийн ихээхэн хэсэг нь ийм энгийн, үнэ цэнэтэй байж чадахгүй биз ээ.

Эцэст нь, Мормоны Ном бол гэрчлэлийн тулгуур чулуу мөн. Хэрэв тулгуур чулууг авбал нуман хаалга нурж унадаг шиг Мормоны Ном үнэн учраас Сүм оршин тогтнож байгаа, эс бөгөөс Сүм оршин тогтнож чадахгүй. Сүмийн дайснууд үүнийг маш сайн ойлгодог. Чухам иймээс тэд Мормоны Номыг гутаахыг урт удаан хугацаагаар махран зүтгэсээр байгаа нь хэрэв энэ номыг гутааж чадвал Бошиглогч Иосеф Смитийг гутааж чадна хэмээн санаархаж байгаа юм. Санваарын түлхүүрүүд, илчлэлт, сэргээгдсэн Сүмийн талаар бид ийнхүү нотолж байна. Үүнээс үүдэлтэйгээр, хэрэв Мормоны Ном үнэн юм бол, мөн эдүгээ сая сая хүн энэ ном үнэн гэдэг Сүнсний гэрчлэлтэйгээ гэрчилж байгаа тохиолдолд хүн Сэргээлтийн тухай үзэл баримтлал болон үүнтэй холбоотой бүхнийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Тийм ээ, эрхэм хүндэт ах, эгч нар аа, Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу, бидний гэрчлэлийн тулгуур чулуу, сургаалын тулгуур чулуу, бидний Их Эзэн бөгөөд Аврагчийн талаарх гэрчлэлийн тулгуур чулуу мөн.

Бид юуны учир Мормоны Номыг судалж суралцах ажлынхаа төвд тавих ёстойн *хоёр дахь* агуу шалтгаан бол энэ ном өнөө үед зориулагдан бичигдсэн явдал мөн. Эртний нифайчууд, леменчүүд аль алинд нь энэ ном байгаагүй. Энэ номыг бидэнд зориулан бичсэн юм. Мормон нифайчуудын соёл иргэншлийн төгсгөл хавьд бичиж байв. Бүх зүйлийг эхлэлээс хардаг Бурханы сүнслэг нөлөөн дор тэрбээр хэдэн зууны цэдгийг товчлон, бидэнд хамгийн чухал үй олон



БОШИГЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Мормоны Ном бол өөр ямар ч номонд байдаггүй мэдээллийг агуулсан ариун цэдэг юм. Их Эзэн өөрийн бүх хүүхдүүдийг Селестиел хаант улс дахь байранд нь бэлтгэхийн тулд илчилсэн үүрдийн Сайн мэдээний үнэнүүдийг тэдэнтэй хуваалцахыг бидэнд зарлиг болгосон билээ. . . .

[Мормоны Номыг] залбирч унших хүн бүр, энэ номон дахь амлалт нь Бурханых уу, эсвэл Иосеф Смит ч юм уу өөр хэн нэгэн хүнийх үү гэдгийг мэдэх хүсэлтэй хүн бүр амлалт нь бидний Тэнгэрлэг Эцэгийнх, Бурханых гэдгийг баттай мэдэх болно гэдгийг мэдсэнээр зүрх сэтгэл минь баяр баяслаар дүүрдэг билээ.”

Ерөнхийлөгч Жорж Альберт Смит (1870–1951), *Conference Report*, 1936 оны 4-р сар, 13–14, 15.

түүх, хэлсэн үгс, үйл явдлуудаас сонгон авч товч хураангуйг хийсэн ажээ.

Мормоны Номын гол зохиогч бүр ирээдүй үеийнхэнд зориулан бичсэнээ гэрчилсэн байдаг. “Миний бичсэн эдгээр зүйлүүд хадгалагдан бас хамгаалагдан мөн миний үр удамд үеэс үед гардуулагдах болно хэмээн Их Эзэн Бурхан надад амласан юм” (2 Нифай 25:21) гэж Нифай хэлжээ. Түүнийг залгамжилсан дүү Иаков нь дээрхтэй адил төстэй үгсийг бичсэн байдаг: “Учир нь [Нифай] түүний хүмүүсийн түүх түүний бусад ялтсууд дээр сийлэгдсэн байвал зохихыг мөн би эдгээр ялтсуудыг хадгалан үлдээж мөн тэднийг үр удамдаа үеэс үед гардуулан өгвөл зохихыг хэлсэн бөлгөө” (Иаков 1:3). Инос, Жером хоёр мөн өөрийн хүмүүст бус харин ирээдүй үеийнхэнд зориулан бичсэнээ дурдсан байдаг (Инос 1:15–16; Жером 1:2-ыг үз).

“Тийм ээ, би та нарт, Израилын угсааны үлдэгдэл та нарт ярьж байна” (Мормон 7:1) хэмээн Мормон өөрөө хэлсэн билээ. Тэрчлэн сүнсээр нөлөөлөгдсөн сүүлчийн зохиогч Моронай үнэхээр өнөө үеийг харсан юм. Тэрээр хэлэхдээ, “Болгоогтун, та нарын дунд эдгээр зүйлс гарч ирэх тэр өдөр, удахгүй ирэх ёстой түүний талаар Их Эзэн надад агуу хийгээд аймшигт зүйлийг үзүүлсэн болой.

“Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ” (Мормон 8:34–35) гэжээ.

Хэрэв тэд өнөө үеийг харж, бидэнд агуу үнэ цэнэтэй зүйлсийг сонгосон юм бол бид Мормоны Номыг судлах ёстой биш гэж үү? Их Эзэн юуны учир үүнийг цэдэгтээ оруулахад Мормонд (эсвэл Моронайд болон Алмад) сүнслэгээр нөлөөлсөн юм бол? Энэ эрин үед амьдрахад надад туслах зүйлээс би ямар сургамж авч болох вэ?” гэж бид өөрсдөөсөө байнга асуух ёстой.

Энэ асуултанд хариулах олон жишээг ар араас нь гаргаж болно. Жишээ нь, бид Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэх загварыг Мормоны Номноос олж болно. Энэ номын

ихэнх хэсэг нь Христийг Америк тивд хүрч ирэхээс өмнөх хэдхэн арван жил дээр анхаарал төвлөрүүлсэн байдаг. Бид энэ үеийг анхааралтай судалснаар зарим хүмүүс яагаад Түүнийг ирэхийн өмнө тохиосон аймшигт шүүлтээр устгагдаж, мөн юу бусад хүмүүсийг эсэн мэнд Өгөөмөр нутаг дахь ариун сүмд үлдээн Түүний гар, хөлийн шархны сорвиудад гараа хүргэж үзэхэд хүргэснийг мэдэж болно.

Христийн шавь нар дайны үед хэрхэн амьдардгийг бид Мормоны Номноос мэддэг. Бодит үнэнээр нь үлэмж тодорхой дүрсэлсэн нууц хуйвалдаануудын нүгэл хилэнцийг бид Мормоны Номноос хардаг. Хавчлага, урвалтад хэрхэн хандвал зохих сургамжийг бид Мормоны Номноос олдог. Номлолын ажлыг хэрхэн хийх талаар бид их зүйлийг энэ номноос мэдэж болно. Материалаг баялгийг шүтэх болон зүрх сэтгэлээ дэлхийн зүйлсэд зориулахын аюулыг бид өөр хаанаас ч илүүтээр Мормоны Номноос хардаг. Энэ ном бидэнд зориулагдсан бөгөөд бид үүнээс агуу хүч, тайтгарал, хамгаалалтыг олж чадна гэдэгт эргэлзэх хүн бий гэж үү?

Мормоны Ном Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд яагаад ийм их үнэ цэнэтэй байдгийн *гурав дахь* шалтгааныг Бошиглогч Иосеф Смит өмнө эш татсан үгэндээ тодорхойлсон юм. Энэхүү үнэт номын талаар Иосеф Смит, “Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүтэйгээр, түүний зааврыг мөрдсөнөөр л хүмүүн Бурханд илүү ойртох болой” гэжээ. Энэ бол Мормоны Номыг судлах гурав дахь шалтгаан мөн. Энэ ном Бурхантай ойр байхад бидэнд тусалдаг. Бурханд илүү ойртох, өдөр тутмын амьдралдаа Түүнтэй илүү адилхан болох, Түүнийг байнга дэргэдээ байгаа юм шигээр мэдрэхээс илүү эрхэм нандин ямар нэг зүйл бидний зүрх сэтгэлд байдаггүй гэж үү? Хэрэв тийм аваас, энэ хэрэгт Мормоны Ном өөр ямар ч номноос илүүтээр бидэнд туслах болно.



Мормоны Ном бидэнд зөвхөн үнэнийг заадаг төдийгүй энэ ном үнэн гэдгийг батлан харуулдаг. Мормоны Ном зөвхөн Христийн тухай гэрчилдэг төдийгүй, бас энэхүү гэрчлэл үнэн гэдгийг батлан харуулдаг. . . . Бас үүнээс ч илүү зүйл бий. Энэ номыг нягт няхуураар судалж эхлэх мөчөөс та нарын амьдралд урсан орох хүч үүнд бий. Та нар уруу таталтыг эсэргүүцэн зогсох агуу хүчийг олно. Та нар хууран мэхлэлтээс зайлсхийх хүчийг олох болно. Та нар нарийн бөгөөд давчуу зам дээр үлдэх хүчийг олно. Судруудыг “амьдралын үгс” (С ба Г 84:85) гэж нэрлэдэг. Мормоны Ном үнэн гэдгээс илүү үнэн гэж хаа ч үгүй. Та нар эдгээр үгсийн төлөө өлсөж цангасан үед амьдрал улам элбэг хангалуун болохыг мэдэх болно.

Бидний хайрт ах, Ерөнхийлөгч Марион Г.Ромни . . . Мормоны Номыг уншиж, судалсан хүмүүсийн амьдралд ирэх адислалуудыг гэрчилсэн юм. Тэр ийн хэлжээ:

“Хэрэв манай эцэг эхчүүд гэр орондоо өөрсдөө болон хүүхдүүдтэйгээ хамт Мормоны Номыг тогтмол, залбирч унших юм бол энэхүү агуу номын сүнс бидний гэр оронд болон тэнд амьдардаг бүх хүмүүсийн зүрх сэтгэлд нэвтрэн орох болно.

Энэ ном бидэнд зориулагдсан бөгөөд бид үүнээс агуу хүч, тайтгарал, хамгаалалтыг олж чадна гэдэгт эргэлзэх хүн бий гэж үү?

Хүндэтгэлийн сүнс өсч, харилцан хүндэтгэл, бие биенээ дээдлэн хүндлэх нь нэмэгдэх болно. Зөрчил сөргөлдөөний сүнс арилах болно. Эцэг эхчүүд агуу хайр, мэргэн ухаанаар хүүхдүүдээ зөвлөгөө өгөх болно. Хүүхдүүд эцэг эхийнхээ зөвлөгөөнд илүү анхааралтай хандаж, дуулгавартай болно. Зөвт байдал өсөн нэмэгдэнэ. Итгэл, найдвар, энэрэл болох Христийн цэвэр хайр бидний гэр орон, амьдралд бялхаж, амар амгалан, баяр баясгалан, аз жаргалыг авчрах болно.”³

Эдгээр амлалтууд—гэр орон дахь өсөн нэмэгдсэн хайр, эе зүй, эцэг эх хүүхдүүд бие биеэ дээдлэн хүндлэх явдал, сүнслэг болон зөв шударга байдлын өргөжилт—бол хоосон амлалт биш харин Бурханд илүү ойртоход Мормоны Ном бидэнд туслах болно гэж Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн тэр зүйл юм.

Ах, эгч нар аа, та бүхэн хувиараа болон Сүм нийтээрээ Мормоны Номын ач холбогдолд агуу хүндэтгэлтэйгээр хандахыг би бүх зүрх сэтгэлээсээ хичээнгүйлэн хүсч байна.

Би 10 гаруй жилийн өмнө Мормоны Номын талаар дараах үгийг хэлж билээ:

Бид энэ номонд хэрхэн хандах нь мөнхийн үр дагавартай юу? Тийм ээ, нэг бол бидэнд адислал болж нөгөө бол зүхэл болно.

“Хожмын Үеийн Гэгээнтэн бүр энэ номыг насан туршдаа судлах ёстой. Эс бөгөөс тэрбээр сүнслэг байдал, оюун санааны эв нэгдлийг бүх амьдралд нь хангаж өгч чадах сүнсийг үл тоомсорлон үүнд хайхрамжгүй хандах болно. Мормоны Номоор дамжуулан Христийн хадан дээр итгэлээ төлөвшүүлж, төмөр бариулаас зууран барьж байгаа хөрвөгч, ингээгүй хүн хоёр ялгаатай.”⁴

Эдгээр үгсийг би өнөөдөр та нарт дахин батлан хэлж байна. Их Эзэнээс бидэнд өгсөн энэхүү гайхамшигтай, агуу бэлэгт хөнгөмсгөөр хандсанаар зүхлийг болон түүний гай гамшиг, шүүлтийг өөрсөд дээрээ дуудахгүй байцгаая. Харин энэхүү бэлгийг зүрх сэтгэлдээ эрхэмлэн нандигнан хадгалж, үүнээс ирэх адислалуудыг хүртэцгээе.

Сургаал ба Гэрээ, 84-р хэсгийн шүлэг



*Энэ номыг
нягт няхуу-
раар судалж
эхлэх мөчөөс
та нарын
амьдралд урсан
орох хүч үүнд
бий.*

54–58-д бид:

“Мөн итгэлгүйн улмаас, мөн та нар өөрсдийнхөө хүлээн авсан зүйлүүдэд хөнгөмсгөөр хандсаны улмаас та нарын оюун өнгөрсөн үед харанхуйлагдсан байлаа—

“Энэхүү хоосон болон итгэлгүй байдал нь бүхэл сүмийг буруушаалт дор авчирсан буюу.

“Мөн энэхүү буруушаалт Сионы хүүхдүүд, бүр бүгд дээр байна.

“Мөн тэд наманчилж, мөн тэрхүү шинэ гэрээ, бүр Мормоны Номыг мөн тэдэнд миний өгсөн урьдын зарлигуудыг зөвхөн хэлэхээр төдийгүй, харин миний бичсэний дагуу үйлдэхээр дурсан санах хүртэл тэд энэхүү буруушаалт дор үлдэх болно.

“Тэд Эцэгийнхээ хаант улсад тохирох үр жимсийг урагш авчирч болохын тулд буюу; эс бөгөөс Сионы хүүхдүүд дээр цутгагдах цээрлүүлэлт хийгээд шүүлт хэвээр үлдэх болно” хэмээн уншдаг.

Өнгөрсөн ерөнхий чуулганаас хойш би Мормоны Номыг уншиж судлах даалгавар авсан дэлхий дахины залуу болон ахмад настай Гэгээнтнүүдээс олон захидал хүлээж авлаа.

Энэ номыг уншиж судлахад шийдвэр төгс байсны ачаар тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдөж, Их Эзэнд хэрхэн улам ойртсон тухай тэдний бичсэн үгсэд миний сэтгэл ихэд догдлон хөдөллөө. Мормоны Ном бол үнэхээр “манай шашны тулгуур чулуу” бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүн “бусад ямар ч номноос илүүгээр үүний зааврыг мөрдсөнөөр Бурханд илүү ойртох болой” гэсэн Бошиглогч Иосеф Смитийн үгсийг сэтгэлд хоногшим эдгээр сайхан гэрчлэлүүд бодгальд минь дахин баталлаа.

Мормоны Ном бидний амьдралын тулгуур чулуу болохын төлөө би залбирч байна. ■

Зөв бичгийн болон том үсгээр бичих дүрмийг стандартын дагуу болгов.

ЭШЛЭЛ

1. Мормоны Номын удиртгал.
2. Мормоны Номын эхний хуудсыг үзнэ үү.
3. Марион Г.Ромни, “The Book of Mormon,” *Ensign*, 1980 оны 5-р сар, 67.
4. Эзра Тафт Бенсон, “The Book of Mormon Is the Word of God,” *Ensign*, 1975 оны тавдугаар сар, 65.

25 ЖИЛД

Б и хэдийгээр 1965 оноос хойш Сүмийн гишүүн байгаа ч 1986 онд болсон ганцхан үйл явдал сэргээгдсэн сайн мэдээний тухай миний гэрчлэлийг өөр юунаас ч илүүгээр бэхжүүлсэн юм.

Тэр жилийн 10-р сард би ерөнхий чуулганы шууд нэвтрүүлгийг үзэхээр Английн Корнволлд цуглааны байр уруугаа очлоо. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонгийн хэлсэн “Мормоны Ном—манай шашны тулгуур чулуу” гэсэн онцгой сайхан үгийг сонссоны дараа би Мормоны Номыг унших хүч чармайлтаа эрс сайжруулж болохоо мэдсэн.

Тэр орой би гэртээ ирээд өвдөг сөгдөн, Мормоны Номонд дахиад хэзээ ч хөнгөмсгөөр хандахгүй гэсэн гэрээг Их Эзэнтэй хийж билээ. Эдүгээ 25 жилийн дараа Мормоны Номыг уншаагүй ганц ч өдөр байхгүй гэдгээ би хэлж чадна.

Ийм шийдвэр гаргаснаас миний хүлээж авсан адислал тоо томшгүй олон билээ. Та нар өөр хаанаас ч, тэрч байтугай судрын бусад номнуудаас ч олж чадахгүй онцгой сүнс Мормоны Номонд байдаг. Амьдралын бүхий л сорилт бэрхшээлүүдэд, ялангуяа гэргий минь 2007 оны 2-р сард 50 ч хүрэлгүй талийгаач болсон үед би Ариун Сүнс надтай хамт байсныг мэдэрч тайтгарсан билээ.

Алистейр Жозеф Уэльс, Шотланд

Ариун ажил

Давид А.Фейц

Нэг орой би номлолын хамтрагчтайгаа Лондонгийн нэгэн их сургуульд сурч байсан гадаадын оюутан залуугийн хаалгыг тогшлоо. Тэр биднийг гэртээ орохыг урихад бид хоёр бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогчид гэдгээ хэллээ. Тэр залуу сайн мэдээний Сэргээлтийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байгаа бололтой, тиймээс бид Бошиглогч Иосеф Смитийн тухай гэрчилж, бидний Тэнгэрлэг Эцэгээс илгээсэн нэгэн ариун номыг Мормоны Ном гэдгийг түүнд ярилаа. Энэ ном Есүс Христийн тухай гэрчилдэг учраас ариун ном гэдгийг бид онцлон тэмдэглэв.

Энэ ном үнэн гэдгийг тэр өөрөө мэдэж болно гэдгийг бид тайлбарлаад нэг хувийг түүнд өгье гэв. Намайг Мормоны Номыг түүнд өгөх гэтэл тэр сандлаасаа босч нэг ч үг хэлэлгүй өрөөнөөс гарч явлаа. Би Мормоны Номыг гартаа барьсан хэвээр хамтрагч бид хоёр яахаа мэдэхгүй, чимээгүйхэн бие бие уруугаа харлаа. Би номыг ширээн дээр тавив.

Бид нөгөө залуу найзыгаа гал тогооны өрөөнд гараа угаагаад шинэхэн алчуураар арчиж байхыг харлаа. Тэр өрөөнд буцаж орж ирээд, ширээн дээрээс Мормоны Номыг авч “Манай ард түмэн ямар нэг ариун зүйлд хүрэхээсээ өмнө заавал гараа угаадаг юм” гэж энгийнээр хэллээ. Тэр залуу эр анх удаа Мормоны Номыг нээж, цэвэрхэн гараараа ариун хуудсуудыг нь эргүүлж эхлэхийг хараад хацрыг минь даган нулимс урсаж билээ.

Судрууд ариун бөгөөд хүмүүсийг аврахын тулд хадгалагдаж ирснийг Алма

*Бидний
заасан юм
бүхнийг тэр
хүлээн ав-
даг байлаа.
Тэгэхлээр
Мормоны
Номыг
түүнд өгвөл
тэр яагаад
авахгүй
байх билээ?*

заасан юм. Тэрбээр хүү Хиламандаа, “Ариун нандин агаад, түүний нандигнан хадгалсаар ирсэн, мөн түүнчлэн тэрээр ирээдүй үеийнхэнд өөрийнхөө хүчийг үзүүлж болохын тулд, тэрээр өөрийн мэргэн зорилгын тулд хадгалж мөн хамгаалсаар байх эдгээр зүйлийг Бурхан чамд даатгасныг санагтун” (Алма 37:14).

Намайг Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг заалгахаар номлолд илгээсэн атал цэвэрхэн гартай энэ залуугаар би заалгасан хүн дээ. Олон соёл заншид, түүний доктор манай ард түмний заншид судруудыг уншихын өмнө гараа угаах шаардлагагүй ч түүний энэхүү үйлдэл Мормоны Номын ариун чанарт хүндэтгэлтэйгээр хандахын тод томруун сануулагч болж билээ. ■





**Ахлагч
Уолтер Ф.Гонзалез**

Далын
Ерөнхийлөгчийн
Зөвлөлийн

ХЭРЭВ ТА
ҮНЭХЭЭР
МЭДЭХИЙГ
ХҮСВЭЛ

Би Мормоны Номын төлөө үүрд талархаж явах болно. Энэ ном миний амьдралыг эгнэгт өөрчилсөн юм. Мөн энэ нь таны амьдралыг өөрчилж чадна гэдгийг би мэднэ.

МЭДЭХ БОЛНО

Би Сүмийн гишүүн болохдоо 18 настай байсан. Миний хөрвөлтөнд Мормоны Ном гол үүрэг гүйцэтгэсэн юм. Тэр үед би эргэн тойрныхоо ертөнцийг ойлгох шинэ санаануудыг хайж байлаа. Миний сурч байсан коллежийн профессорууд заах аргадаа материалист үзлийг маш их баримталдаг байсныг би санадаг. Бурхан байдаггүй гэдэг үзэл санааг би баримтлах болов.

Зургаан жилийн өмнө хоёр номлогч манайд орхиж явсан цэнхэр хавтастай номыг би нэг өдөр ажиглалаа. Энэ бол Мормоны Ном байв. Тэд энэ номын хамт Иосеф Смитийн тухай нэг товхимол бас Бурханд хандан хэрхэн залбирах тухай зааврыг орхисон юм.

Тэгээд Мормоны Номыг уншиж эхлэв. Би 1 Нифайгаас хэдхэн шүлгийг уншаад л энэ ном бусдаас өөр болохыг мэдэрч билээ. Мэдрэмж, оюун санаа хоёр минь зөрчилдөж эхлэв. Иймээс би Бурханд хандан залбирч асуухаар шийдлээ.

Би ийнхүү амьдралдаа анх удаа өвдөг сөгдөн залбирч билээ. Залбирсны дараа болсон явдал миний амьдралд хамгийн нандин туршлага болсон юм. Сэтгэл догдуулсан баяр баяслын мэдрэмж төрж, Мормоны Ном бол зүгээр нэг номноос

илүү эрхэм зүйл гэдгийг би зүрх сэтгэлдээ мэдэрч байлаа. Энэ бол бурханлаг гарал үүсэлтэй ном байв. Энэ бол яах аргагүй Бурханы үг. Надад төрсөн тэрхүү мэдрэмж бол энэ ном үнэн гэдгийг гэрчилсэн Сүнс байсныг би хожим нь ойлгож билээ.

Зарим хүмүүст адил төстэй туршлага тохиож болох ч Мормоны Ном үнэн гэдгийг хүмүүс өөр өөр арга замаар мэдэж болно.

Харин та хэрхэн мэдэж болох вэ?

1. *Зарим хүмүүс сонсоод мэдэж болно.* Энэ номын заадаг зүйлсийг зүгээр л сонсоноор зарим хүмүүс уг ном үнэн гэдгийг мэддэг. Та тэдний нэг байж болно. Мозагийн хөвгүүдийг Есүс Христийн сайн мэдээг заахыг сонсоод “Их Эзэнд хөрвөсөн” мянга мянган хүний тухай Мормоны Ном өгүүлдэг (Алма 23:5–6-г үз). Номлогчид өнөөдөр Мормоны Номонд байдаг сайн мэдээг зааж байна. Зарим хүмүүс Мормоны Ном бол Бурханы үг гэдгийг бусад хүмүүс энэ номын сургаалуудыг хуваалцахыг сонсоод мэдэж болно.


2. *Зарим хүмүүс үүнийг уншаад мэдэж болно.* Зарим хүмүүс үнэнийг мэдэх чинхүү хүсэлтэйгээр Мормоны Номыг уншсанаар үүнийг мэддэг. Та тэдний нэг байж болно.



Эхнэрийн минь хувьд ийм байсан юм. Мормоны Номыг эхнээс нь дуустал унших зааврыг чин сэтгэлээсээ хүлээн авахдаа тэр 12 настай охин байлаа. Тэрээр уншиж дуусмагцаа энэ ном үнэн гэдгийг мэдсэн. Уншиж байх үед нь нэн хүчтэй мэдрэмж төрснөөс тэрээр Аврагчийг үүрд дагахаар шийдсэн гэнэ. Тэр минь мэдэрсэн зүйлдээ үнэнч үлдсэн билээ.

3. Зарим хүмүүс үйлдэл хийж байж мэддэг. Зарим хүмүүс энэ номын заадаг зүйлсийг хийснээр энэ нь үнэн гэдгийг мэддэг. Та тэдний нэг байж болно. Зарим хүмүүс үйлдлээрээ дамжуулан гэрчлэлтэй болдог (Иохан 7:17-г үз). Мормоны Номын бошиглогч Нифай энэ зарчмыг сайн ойлгодог байлаа. Тэрбээр “гэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчид итгэхийг илүү бүрэн дүүрнээр ятгахын” . . . тулд, “энэ нь бидэнд эрдэм болон тус байж болохын тулд *би бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгасан билээ*” гэж бичсэн юм (1 Нифай 19:23; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн). Та Мормоны Номын сургаалуудыг амьдралдаа адилтгах буюу хэрэгжүүлснээр бас энэ номын бурханлаг гарал үүсэлд итгэх болно.

4. Зарим хүмүүс Бурханаас асууснаар мэдэх болно. Зарим хүмүүс Мормоны Номноос уншаад энэ ном үнэн эсэхийг Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч асууснаар мэддэг. Та тэдний нэг байж болох юм. Энэ бол энэ ном үнэнийг мэдсэн миний туршлага. Мормоны Номын өөр нэг бошиглогч Моронай үнэнийг чин сэтгэлээсээ эрж хайгч бүгдэд хандан: “Болгоогтун, та нар эдгээр зүйлийг уншихдаа . . . та нар Бурхан Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулъя, би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно” (Моронай 10:3–4) хэмээн тод томруунаар амласан юм. Хэрэв та нар Мормоны Номыг уншиж, үүний талаар залбиран, Моронайн зааврыг дагавал энэ ном үнэн гэдгийг мэдэх болно гэдгийг би гэрчилж байна.



МОРОНАЙН АМЛАЛТ

Хэрэв бид Мормоны Номыг уншиж, захиасыг нь зүрх сэтгэлдээ тунгаан бодож, Энэ ном үнэн үү гэдгийг Бурханаас залбирч асуувал Бурхан Ариун Сүнсний хүчээр дамжуулан бидэнд хариулах болно гэдгийг Мормоны Номын төгсгөлд Моронай хэмээх бошиглогч амласан билээ (Моронай 10:3–5-ыг үз).

Хувийн илчлэлт нь хувийнх юм. Хувийн илчлэлт нь Их Эзэний тааллын дагуу өөр өөр байдлаар, өөр өөр цагт ирдэг. Дараах зарчмуудыг ойлгох нь үнэнийг өөрөө мэдэхэд тань тусалж болно.

1. Энэ тухай эргэцүүлж бодоорой

Моронай биднийг залбирахаас өмнө тунгаан бодохыг урьсан юм. Тунгаан бодох гэдэг нь юмыг гүнзгий бодох гэсэн утгатай. Мормоны Номыг уншихад надад ямар мэдрэмж төрөв? Яагаад ийм мэдрэмж төрөв? Би юу мэдэв? Энэ нь сайн зүйл үү? гэж өөрөөсөө асуу.

Их Эзэн энэ зарчмыг Оливер Каудерид ийн заасан: “Чи надаас асуухаас өөрөөр санаа тавиагүй байна. Гэвч болгоогтун, би чамд хэлнэ, чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой (С ба Г 9:7–8; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

2. Хичээнгүйлэн залбир

Бодол санаагаа Ариун Сүнсний нам гүмхэн хариултуудад төвлөрүүлэх нь оюун ухааны хүч чармайлтыг шаарддаг. Чухам иймээс Инос Мормоны Номонд өөрийн залбирлын тухай “Бурханы өмнө өөртэйгөө тэмцэлдэх” (Инос 1:2) хэмээн өгүүлсэн байж болох юм.

Та судар уншиж, тунгаан бодох эсвэл залбирах үедээ анхаарлыг чинь аль болох бага сарниулах цаг, газрыг олох хэрэгтэй. Анхаарлаа төвлөрүүлэхэд чинь туслах газрыг ол. Чангаар залбирах нь бодол санаагаа төвлөрүүлэхэд тань тусална.

3. Зөв асуулт асуу

Их Эзэн Оливерт зөвхөн гуйх төдийгүй бас зөв гэж үзсэн асуултаа асууж бай хэмээн хэлсэн билээ. Бид бүгд, ялангуяа Тэнгэрлэг Эцгээсээ хариу хүлээн авч туршлагажаагүй үедээ тийм эсвэл үгүй гэсэн энгийн асуултын хариуг ойлгох нь хялбар байдаг.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “Сайн залбирлын түлхүүр нь зөв асуултууд асууж сурах явдал мөн” гэж заажээ.¹

4. Ямар санаа бодолтойгоор хийнэ вэ?

Моронайн амлалтын түлхүүрүүдийн нэг нь бид “үнэн санаа бодолтойгоор” асуух явдал мөн. 14-тэй хөвгүүн Иосеф Смит залбирахаар ой руу очиж, “зөвхөн сонсох төдийгүй харин дуулгавартай дагах үнэн санаа бодолтойгоор залбирсан юм. “. . . Түүний итгэлтэйн улмаас олон хоног, сар, жилийн дараа түүний олон залбирал гэрэл ба үнэний үер лүгээ адил элбэг дэлбэгээр хариулагдсан билээ” гэж Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б. Айринг хэлжээ.²

5. Үүнийг бүү алд

Илчлэлт болгон онцгой сонин байдаггүй. Зарим хүмүүс зүүдэлж, үзэгдэл үзэх буюу тэдэн дээр айлчлан ирдэг. Гэвч бидний ихэнхэд нь анхааруулга, амар амгалангийн мэдрэмж зэрэг ямар нэг нам гүмхэн, тов тодорхой зүйл мэдрэгддэг.

Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл (1895–1985) “хүн ямар нэг онцгой сонин зүйлийг хүсэн хүлээвэл илчлэлт байнга ирдгийг мэдэхгүй өнгөрөөж болно” хэмээн заажээ.³

Эшлэл

1. Ричард Г. Скотт, “Using the Supernal Gift of Prayer,” *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 8.
2. Хенри Б. Айринг, “Prayer,” *Лиакхона*, 2002 оны 1-р сар, 18.
3. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 241.



БОШИГ-ЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Мормоны Ном бол Бурханы үг. Энэхүү

гайхамшигтай цэдгийг уншихыг бид та бүхнээс хүсч байна. Энэ бол өнөө үеийн хамгийн гайхамшигтай ном мөн. Энэ номыг залбирч, анхааралтай уншигтун, тэгвэл Бурхан танд Моронайн амласанчлан энэ ном үнэн гэдэг гэрчлэлийг өгөх болно” (Моронай 10:4-ийг үз).

Ерөнхийлөгч Ховард В. Хантер (1907–1995), *The Teachings of Howard W. Hunter*, хянан тохиолдуулсан Клайд Ж. Виллямс (1997), 54.



БОШИГ-ЛОГЧ ИЙН ГЭРЧИЛЖЭЭ

“Би [Сэргээлт, түүний дотор Мор-

моны Ном] үнэн болох тухай хамгийн хүчтэй илчлэлтийг Их Эзэнээс хүлээн авсан хүн. Энэхүү илэрхийлэл цагаас цагт надад хүчтэй мэдрэгдэж, дурдатгалд минь ямар ч нөхцөл байдал бий боллоо гэсэн ой дуртгалд минь энэхүү төгс мэдлэг үргэлж байх болно.”

Ерөнхийлөгч Лорензо Снөү (1814–1901), *Conference Report*, 1900 оны 10-р сар, 61.

Та үүнийг мэдэх болно гэдгийг Бурхан амласан юм

Хэрэв та Мормоны Ном үнэн гэдгийг үнэхээр мэдэхийг хүсвэл үүнийгээ мэдэх болно. Бурхан үнэнийг чин сэтгэлээсээ эрж хайгчдад энэ мэдлэгийг өгөхөөр амласан бөгөөд Тэр бол “үнэний Бурхан, мөн худал хэлж эс чадна” (Ифер 3:12).

Мормоны Номын өөр нэг бошиглогч Алма хүүдээ Бурхан дараах амлалтыг заасан юм; Тэрбээр “өөрт буй мэргэн зорилгын улмаас, өөрийн хүчийг ирээдүй үеийнхэнд үзүүлж болохын тулд [энэ номыг] хадгалан үлдээнэ. Мөн эдүгээ болгоогтун, бүр леменчүүдээс олон мянгыг нь . . . үнэний мэдлэгт сэргээхэд тэрбээр нэгэн зорилгоо гүйцэлдүүлсэн билээ; мөн тэрээр тэднээр өөрийн хүчийг үзүүлж, мөн түүнчлэн тэрээр тэднээр өөрийн хүчийг ирээдүй үеийнхэнд ч бас үзүүлэх болно; тиймийн тул [энэ ном] хадгалагдан үлдэх болно (Алма 37:18–19).

Ийм итгүүлэгч хүч өнөөдөр ч судрын

энэ номонд байгаа бөгөөд үүнийг мэдэхийг чин сэтгэлээсээ эрж хайгч хэнд ч болов Их Эзэн үүнийг харуулах болно. Би Сүмийн тухай анх мэдсэн тэр өдрүүдээ эргэн санаж үүнийг бат ноттойгоор хэлж чадна. Мормоны Ном итгүүлэгч хүчтэй учраас энэ ном Бурханы үг бөгөөд Есүс бол Ариун Мессиа, Христ гэдгийг заадгийг би өнөөдөр гэрчилж байна. Энэ ном бол Түүний сайн мэдээний Сэргээлт тохиосны болон Иосеф Смит бол Бурханы бошиглогч мөн гэдгийн бодитой нотолгоо мөн.

Хэрэв та үнэнийг чин сэтгэлээсээ эрж хайгчдын нэг бол үнэнийг мэдэх болно гэдгийг Их Эзэн амласан. Та энэ номын сургаалуудыг сонссоноор, энэ номыг уншсанаар, энэ номын заадаг зүйлсийг хийснээр, үүний үнэнийг мэдэхийн төлөө залбирснаар эсвэл эдгээр үйл ажиллагаануудыг хослон хэрэглэснээр үнэнийг мэдэж болно. Ингэснээр та үнэнийг мэдэх болно. ■

БИ ХЭРХЭН МЭДСЭН БЭ?

Намайг есөн настайдаа баптисм хүртэхэд манай Гэрийнхэн Сүмд идэвхгүй болсон байлаа. Гэвч 13-тай байхад минь номлогчид намайг сүмд очихыг урьсанд би очсон. Бас семинарт явсан. Семинарт тэр жил Сургаал ба Гэрээг үзэж байлаа. Би энэ судрыг ойлгохгүй юм шиг санагдаж билээ. Иосеф Смит болон Мормоны Ном надад бүр ч хэцүү байлаа. Би Бурханыг олохсон гэж хүсэвч, Түүнийг хэрхэн, хаанаас олохоо мэдэхгүй байв.

Цаг хугацаа өнгөрөх тусам би номлогчидтой ярилцсан тухайгаа улам их боддог боллоо. Бас семинарын тухай боддог байлаа. Христийн бусад сүмүүдийн гишүүдтэй ярилцсан тухайгаа бодлоо. Юу зөв болохыг мэдэхийн төлөө үе үе залбирдаг байсан ч, чин сэтгэлийн асуултын оронд өнгөрсөн үеийн бодол санаа зонхилдог байв. Тэгээд нэг үдэш би “үнэн санаа бодолтойгоор” залбирахаар шийдлээ.

Би Түүнийг мэдэхийг бас Түүний үнэн Сүмийн гишүүн байхыг хүсч байгаагаа Тэнгэрлэг Эцэгт

хэллээ. “Хэрэв Та Иосеф Смит үнэхээр бошиглогч мөн үү гэдгийг мөн Мормоны Ном үнэн үү гэдгийг надад мэдүүлэх юм бол би Таны надаар хийлгэх юуг ч болов хийх болно. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм үнэн Сүм юм бол би энэ сүмийг дагаж, хэзээ ч үүнийг орхихгүй” хэмээн би амлалаа.

Тэгээд ямар нэгэн онцгой сонин зүйл мэдэгдсэнгүй, харин амар амгаланг мэдэрч унтахаар хэвтлээ. Хэдэн цагийн дараа би “Иосеф Смит бол үнэн бошиглогч, Мормоны Ном үнэн” гэсэн тод томруун бодолтойгоор сэрлээ. Уг бодолтой хамт үгээр илэрхийлэх аргагүй амар амгалангийн мэдрэмж ирэв. Дахиад таг унтсан ч дараа нь мөн л нөгөөх бодол, мэдрэмжтэйгээр сэргэж билээ.

Тэр үеэс хойш би Иосеф Смит бол үнэн бошиглогч гэдэгт огт эргэлздэггүй болсон. Энэ бол Аврагчийн ажил гэдгийг мөн Тэнгэрлэг Эцэг бидний чин сэтгэлийн гуйлтуудад хариулдгийг би мэднэ.


Родольфо Армандо Перез Бонилла, Эл Сальвадор

ГАЗАР ШОРООНООС ГАРЧИРСЭН ДУУХООЛЛОЙ

Мормоны Ном өнөө үед үнэнийг дэлхий дахинд өгүүлж байна.

Энэ ном таны амьдралд гэрэл ба үнэнийг авчраг.

(Моронай 10:27-г үз.)



МИНИЙ ДОТОР ШАТАЖ БУИ ГАЛ

*Эдуардо уншиж сурсан
өдрөө Мормоны Ном болон
үүний хүчний тухай гэрч-
лэлтэй болсон ажээ.*

Майкл Р. Моррис

Сүмийн сэтгүүлүүд

‘Бид хүний дайтай амьдрахыг хүсвэл уншиж сурах ёстой’ гэж өвөө минь хэлдэг байж билээ. Өвөөгийн минь зөв байжээ” хэмээн Эдуардо Контрерас дурсав.

Гэвч Эдуардогийн уншиж сурах зам урт байжээ. Аргентины Кордоба хотод бэлэвсэн ээжийнхээ өсгөн хүмүүжүүлсэн таван хүүхдийн нэг нь болох тэрээр найман настайдаа сургуулиа орхин гэр бүлээ тэжээхийн тулд ажил хийхээс аргагүй болсон гэнэ.

“Би маш ядуу байлаа” гэж тэр хэллээ. Эдуардо хоногийн хоолоо залгуулахын тулд гутал тосолж, тоосго цохин, төмс хурааж, сонин заран, олдсон ямар ч ажлыг гололгүй хийж явсаар залуу эр болсон хойноо хотын захиргаанд бүрэн цагийн ажилтай болсон гэнэ.

Олон жил өнгөрч, Эдуардо гэрлэн, гал голомтоо бадраасан ажээ. Өнгөрсөн жилүүдийн дотор таван хүүхдийнх нь олонх нь гэр орноо орхин өрх тусгаарласан ч тэр өдий хүртэл уншиж сурсангүй, боломж ч бага байлаа. Нэг өдөр тэндхийн хэдэн хөвгүүд гэрийнх нь өмнө Хожмын Үеийн Гэгээнтэн хоёр номлогчийг шоолон тохуурхахад Эдуардо тэднийг хөөж явуулсан өдөр энэ байдал өөрчлөгдсөн ажээ. Тэр номлогчдыг гэртээ орохыг уриад, тэр даруй эхнэр Мариягийнхаа хамт ярилцлага авч эхэлжээ.



Дээрх зураг дээр эхнэр Мариятайгаа хамт байгаа Эдуардо Контрерасын хувьд Мормоны Ном бичиг үсэгт тайлагдахын үүдийг нээж өгчээ. “Би энэ номыг уншихаар нээх бүрдээ Сүнсийг мэдэрдэг” гэж тэр хэллээ.

“Номлогчид испаниар маш бага ярьдаг байсан учир тэдний яриаг ойлгох гэж их зүдэрдэг байлаа. Гэтэл тэд Ариун ой дахь Аврагч болон Бошиглогч Иосеф Смитийн зурагтай товхимлыг надад үзүүлэв. Бидэнд тэдний үзүүлсэн тэр зураг бас заасан зүйл үнэхээр сайхан байлаа” гэж тэр дурсан ярилаа.

Удалгүй нөгөөх хоёр номлогч солигдож, өөр номлогчид, түүний дотор төрөлх испани хэлээрээ ярьдаг нэг номлогч ирсэн гэнэ. Хэдэн жилийн өмнө өөдсийн чинээ охиноо алдсан Эдуардо, Мария хоёр *гэр бүлүүд мөнхөд хамт гэдэг тухай Сүмийн кино үзээд сэтгэл нь нэн их догдолжээ*: Тэр хоёр отгон хүү Освальдогийнхоо хамт удалгүй баптисм хүртжээ.

Эдуардо 1987 онд баптисм хүртсэнээр Мормоны Номыг уншиж, гэрчлэлээ бэхжүүлэх хүсэлтэй болсон гэнэ. “Би яаж уншиж сурах вэ?” хэмээн тэр эхнэрээсээ асуужээ. Эхлээд үсэгнүүдийг харж байгаад дотроо холбож үг болгоод тэр үгээ чангаар дуудаж, дараа нь чанга уншихыг хичээ гэж Мария түүнд хэлжээ. Дадлага хийх тусам тэр өөртөө итгэлтэй болж, эцэстээ уншиж сурсан гэнэ.

Тэр үед 45 настай байсан Эдуарда олон үсгийг дуудаж мэддэг байсан ч, бараг 40 жилийн тэртээ сургуулиа хаяснаас хойш уншихыг оролдоогүй гэнэ.



СҮНСЛЭГ НӨЛӨӨ БА ХҮЧНИЙ ЭХ БУЛАГ

Та Мормоны Номыг юу гэж үздэг вэ? Энэ ном амьдралд чинь сүнслэг нөлөө болон хүчний эх булаг байдаг уу? Цаашдаа ийм байх уу?

“Хэрэв та цэвэр үнэний энэхүү оргилуураас хараахан хүртээгүй бол одоохон хүртэхийг би бүх зүрх сэтгэлээрээ дэмжиж байна. Мормоны Номыг байнга судлах явдлыг хийхээр төлөвлөж байгаа юмсынхаа тоонд оруулахгүй байж болох ч гэсэн үүнийг уншиж судлахаа хэзээ ч бүү орхи. Өнөөдрөөс л эхэл.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “The Power of the Book of Mormon in My Life,” *Ensign*, 1984 оны 10-р сар, 11.

Би дотроо шатаж буй галыг мэдэрсэн

Эдуардо чин сэтгэлээсээ залбираад, зуны халуун өдөр гэрийнхээ арын хашаан дахь сүүдэртэй газарт суулаа. “Энд би анхны оролдлогоо хийсэн юм” гэж тэр хэллээ.

Дараа нь юу болсныг би огт төсөөлөөгүй шүү гэж Мария хэллээ. Тэр гал тогооны өрөөнд ажиллаж байхдаа Эдуардо үсэг, үгсийг чанга дуудахыг хичээж байгааг сонсдог байжээ. “Түүнийг гэнэт түргэн түргэн яриад эхлэхийг би сонссон шүү. Сайн сонсвол Эдуардо түгдрэлгүй уншиж байх нь тэр. Бүтэн хагас цагаас багагүй хугацаанд тэр уншсан даа!” гэж тэр ярилаа.

Эдуардо уншиж байгаагаа ч мэдэхгүй болтлоо тийм их мэрийсэн ажээ. Гэвч тэр уншиж дуусаад “Миний дотор гал шатаж байгааг би мэдэрсэн” гэж билээ. Эдуарда цочиж, гайхсандаа эхнэрээ дуудаж, “Мами, би ер нь юу болоод байна аа?” гэж асуусан гэнэ.

“Наадах чинь Их Эзэний Сүнс. “Чи түгдрэлгүй уншиж байна шүү дээ!” гэж Мария хариуллаа.

Мария тэр явдлаа дурсан яриад, “Бид үүнийг хэзээ ч үгүйсгэж чадахгүй” гэлээ.

“Би уншиж сурсан тэр өдрөө Мормоны Ном болон үүний хүчний тухай гэрчлэлтэй болсон юм” гэж Эдуардо нэмж хэллээ.

Тэр үеэс хойш Эдуардо Мормоны Номыг ажилд явахаасаа өмнө уншихын тулд өглөөний 4:00 цагт босдог болжээ. Тэгээд тэр эхлээд Сургаал ба Гэрээг дараа нь Библийг уншжээ. 1987 оноос өмнө хэдхэн номтой байсан номын сан эдүгээ Контрерасын гэрийг чимж байна.

Эдуардо, Мария хоёрын сайн мэдээний мэдлэг, гэрчлэл нь өсөн нэмэгдсэн байлаа. 2001 онд хүү Освальдо нь автын ослоор нас барсны дараа Аргентины Буэнос Айресын ариун сүм дэх залбирлын үеэр тэдний сүнслэг туршлага—гэрчлэл хоёр дахин өсчээ. Тэд энд Освальдотойгоо лацдан холбуулсан нь уй гашууг нь нимгэлсэн ажээ.

“Зарим эцэг эх уурлаж бухимддаг, харин бид “Танай хүү сайн байгаа шүү” гэж хүмүүс хэлэхэд сайхан мэдэмж төрдөг. Мэдээжийн хэрэг бид уйлсан. Сайн хүү

байсан даа. Бид хүүгээ их санадаг. Гэвч бид ариун сүмд лацдан холбуулсан. Хүү минь хаана байгааг бид мэднэ” гэж Эдуардо ярилаа.

Уншиж сурснаас ирсэн гэрэл

Тойргийнх нь гишүүд заасны ачаар Эдуардо бас бичиж сурчээ. “Өмнө нь би бүр нэрээ ч бичиж чаддаггүй байлаа” гэж тэр хэллээ.

Эдуардо бичиг үсэгтэй болсны ачаар өвөг эцгийнх нь үгс үнэнийг ойлгосон ажээ.

“Бид өдөр бүр бага багаар өсч хөгжиж байхын төлөө энэ дэлхий дээр байгаа юм шүү дээ.” Тэрбээр уншиж, бичиж сурснаар, эрдэм мэдлэг эзэмшиж, хөгжин, Бурхан биднийг ямар хүмүүс болоосой гэж хүсдэг шиг тийм хүмүүс болоход хэзээ ч оройтдоггүй гэдгийг хүүхдүүд, ач зээ нартаа харуулаа гэж тэр ярьж байна. “Би уншиж сурсан учраас өдөр бүр ямар нэг шинэ зүйл сурдаг” гэж тэр хэлэв.

Өнөөдөр Контрерас ах унших гэсэн юуг ч болов, түүний дотор бичиг мэддэггүй жаал хүү байхдаа зардаг байсан сониноо уншиж чаддаг болжээ. Судрууд, ялангуяа Мормоны Ном түүний дуртай номнууд юм. Тэр энэ номыг найман удаа эхнээс нь дуустал уншсан гэнэ.

“Надад Мормоны Ном үүд хаалгыг нээсэн юм” гэж тэр ярилаа. Бичиг үсэгтэй болж сайн мэдээг уншсан нь түүний амьдралыг өөрчилсөнд тэр баярлан талархаж явдаг ажээ. “Мормоны Ном миний хувьд бүх юм болдог. Энэ бол миний хувьд юм бүхэн гэсэн үг. Би энэ номыг уншихаар нээх бүрдээ Сүнсийг мэдэрдэг.” ■

ХАРИУЛТЫГ БИ ХААНААС ОЛЖ БОЛОХ ВЭ?

Намайг 21-тэй байхад Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогчид манай дүүрэгт англи хэлний хичээл заадаг байлаа. Би эхний үед англи хэлний хичээлд суудаг байсан ч удалгүй хичээлийн дараа тэдгээр ахлагчдын хуваалцадаг байсан сүнслэг бодлыг сонсохоор үлдэж, тэднээс асуултауд асуудаг болов.

Би хэдийгээр улс орныхоо зонхилох шашныг шүтэн биширч өссөн ч шүтлэг бишрэлийн олон асуултанд хариу олж чадаагүй байлаа. Тэдний Сүмийн номлогчид болон гишүүд өнгөрсөн үед хэн ч надад сэтгэл ханамжийг авчраагүй асуултуудад хариулсан юм.

Би нэг удаа англи хэлний хичээлийн дараа Мормоны Номноосоо нэгийг өгч болох уу гэж номлогчдоос зориглон асуулаа. Гэвч гэртээ ирээд номоо уншилгүй тавиур дээр тавьлаа.

Гэвч ном тавиур дээр удаан байсангүй. Судруудад асуудлуудын шийдэл байдаг гэдгийг би англи хэлний хичээлд суудаг байсан Сүмийн гишүүдээс сонссон юм. Тиймээс надад хувийн сорилт бэрхшээл буюу асуудал тулгарсан үед би Мормоны Номоо тавиур дээрээс авч уншдаг байлаа. Миний мэдэх ёстой зүйлийг нэн тодорхой хэлж өгсөн хариултаудыг би судруудаас үнэхээр олсон.

Тэр үед би Сүмгүйгээр амьдарч чадахгүй юм байна гэдгийг мэдэрч эхэлсэн. Сүм бол миний байхыг хүсдэг газар байлаа. Сүм бол миний харьяалагдаж байгаагаа мэдэрч чаддаг газар байлаа.

Гэсэн хэдий ч Бурханаас асууж, бодол санаагаа бататгахыг хүсэх



Нэг орой би гэрийнхээ үлдсэн хэсгээс арай тусгаарлагдсан гал тогооны өрөөнд сэмхэн орж, энэ Сүм үнэн үү гэдгийг Тэнгэрлэг Эцэгээс асуулаа.

болов. Нэг асуудал бий болсон нь би байрныхаа эзэн, настай эмэгтэйтэй хамт нэг өрөө байранд амьдардаг байсан учир нууцгайхан залбирах газар надад байдаггүй байв. Гэвч нэг орой би гэрийнхээ үлдсэн хэсгээс арай тусгаарлагдсан гал тогооны өрөөнд сэмхэн орж, энэ Сүм үнэн үү гэдгийг Тэнгэрлэг Эцэгээс асуулаа. Хариуд нь би мэдэх ёстой зүйлээ мэдсэн гэсэн хүчтэй мэдэрэмж надад төрлөө.

Түүнээс хойш удалгүй би баптисм хүртсэн бөгөөд Сүмийн

гишүүн байгаа энэ үе амьдралын минь хамгийн аз жаргалтай үе юм. Өмнө нь надад асуултууд л байдаг байсан ч эдүгээ би хариултаудаа аваад байна. Урьд нь надад хоосон мэдрэмж төрдөг байсан бол одоо тийм биш боллоо.

Тэнгэрлэг Эцэг бидний асуултуудыг хариултгүй үлдээдэгүйд би баяртай байдаг. Тэрбээр залбирал, судруудаар аль алинаар нь дамжуулан бидэнтэй ярьдгийг би мэднэ. ■

Ольга Овчаренко, Свердловск муж, Орос

МИНИЙ ДОТОР ГАЛ ШАТАХ ШИГ БОЛСНЫГ БИ МЭДЭРСЭН

Би хүүхэд ахуйдаа өсч торнисон АНУ-ын Мичиган дахь гэрийнхээ дэргэдэх сүмийн Ням гарагийн хичээлд явдаг байлаа. Намайг Есүс Христийг хайрлах хайраар дүүргэсэн нэгэн гайхамшигтай багш надад байлаа.

Тэрээр долоо хоног бүр Аврагчийн мөнх бус үйлчлэлийн үйл явдлуудыг, түүний дотор Түүний заасан зарчмууд болон үйлдсэн гайхамшгуудыг дүрсэлсэн картуудыг тараадаг байлаа. Би долоо хоног бүр картуудыг бяцхан номонд оруулж, Библи дэх түүхүүдийг дахин уншдаг байв. Тэгээд нас ахих тусам Шинэ Гэрээн дэх Сайн мэдээнүүдийг үргэлжлүүлэн судалдаг байлаа.

Олон жилийн дараа 1968 оны зунжин Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогчид манай гэр бүлийн нэг гишүүний гэрт очжээ. Тэр Сүмийн тухай мэдэхийг урьсан ахлагч нарын урилгыг хүлээн авсангүй харин тэднийг манайх уруу явуулсан байлаа.

Номлогчид бидний анхны уулзалтаар Есүс Христийн үндэслэсэн Сүмд “урвалт” тохиосныг надад заав (2 Тесалоник 2:3-ыг үз). Тэдний заасан зүйл миний хувийн судалгаатай тохирсон учир тэд над дээр дахиад ирж болох уу гэж асуухад нь би зөвшөөрлөө.

Тэдний дараагийн ирэлтээр би олон асуултын жагсаалт гаргачихаад байв. Хожмын Үеийн Гэгээнтнүүд усанд бүрэн дүрэлтээр баптисм хүртдэг үү? Тэд санваарын эрх мэдэлд итгэдэг байсан уу? Тэд өвчтөнүүдийг эдгээж болно гэдэгт итгэдэг байсан уу? Тэдний хариултууд Шинэ Гэрээнээс миний судалсан зүйлтэй тохирч байв. Тэд явахынхаа өмнөхөн энэ ном Есүс Христийн тухай гэрчилдэг юм гэж

хэлээд надад нэг ном өгөв.

Би номыг зурагтан дээр тавиад унтахаар хэвтлээ. Гэвч би шөнө дунд нэгэн хүчтэй мэдрэмжээр сэрлээ. Энэ мэдрэмж бол Ариун Сүнс байсныг хожим нь мэдэж билээ. Нөгөөх номоо уншмаар санагдаад болсонгүй, тэгээд дахин унтахаар хэвтэхээсээ өмнө бүтэн цаг хагас уншлаа. Тэгээд удалгүй дахин сэрэхэд нөгөөх мэдрэмж дахин төрөхөд би цааш нь хэсэг уншлаа.

Энэ явдал дараагийн хоёр шөнө давтагдав. Мормоны Ном Есүс Христийн тухай гэрчилдгийг ойлгосон учраас би уншиж байгаа зүйлдээ дуртай байлаа.

Би Бурханаас удирдамж хүсэхээр шийдлээ. Би бүр жаахан охин байснаасаа хойш удаа залбирахаар өвдөг сөгдлөө. Миний дотор гал шатах лугаа адил болж байгаа тэр зүйлийн талаар яах тухайгаа мэдэхэд тусална уу гэж Тэнгэрлэг Эцэгээс гуйлаа. Залбирлаа дуусгаад би 3 Нифай 9 дэх леменчүүдийн хөрвүүлгийн тухай шастирыг дахин уншихад өдөөгдлөө. Тэд “галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртсэн бөгөөд үүнийг тэд мэдээгүй билээ” (шүлэг 20) хэмээн би уншлаа.

“Тэд үүнийг мэдээгүй билээ” гэсэн өгүүлбэр чухамдаа надад зориулагдсан байлаа. “Есүс Христ үнэхээр дэлхий дээр байна!” гэсэн бодол надад төрлөө. Би уншиж, мэдсэн зүйлийнхээ тухай номлогчидтой ярилцахыг тэсгэлгүй их хүсч байлаа. Гэвч тэд миний асуултуудад баптисм хүртэх урилгаар хариулахад нь би чадахгүй гэж хэллээ. Миний нөхөр үүнийг ойлгохгүй байх.

Гэвч би тэр шүлгийн тухай үргэлжлүүлэн бодоод энэ шүлэг “харууссан зүрх, гэмшсэн

сэтгэлээ” золиослохыг маш тодорхой санал болгосныг ойлгосон юм.” Тэгээд залбирч, туслаач хэмээн Тэнгэр дэх Эцэгээсээ гуйлаа. Тэрбээр миний гуилтыг ёсоор болгосон юм. Манай нөхөр номлогчийн ярилцлагуудыг авсны дараа намайг баптисм хийлгэхийг зөвшөөрлөө.

Би залуу ээж байхдаа Мормоны Номыг уншсанаас үнэ цэнэтэй, сэтгэлд хоногшим туршлагатай болсныхоо төлөө хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгтээ хэчнээн их талархалтай байдаг билээ. Энэ ном намайг Есүс Христийн сайн мэдээ уруу хөтөлсөн юм. Үүний үр дүнд 1968 онд хэдэн шөнө дараалан миний мэдэрсэн Ариун Сүнсний нөлөө эдүгээ надад байнгын бэлэг болж, Сүмийн гишүүн болсноос хойших 40 гаруй жилийн турш намайг удирдаж байгаа билээ. ■

Клаудия Виллямс, Флорида, АНУ

Би тэр номыг зурагтан дээр тавиад унтахаар хэвтлээ. Гэвч шөнө дунд би дахин уншихыг хүсч байгаагаа мэдрэв.



МОРМОНЫ НОМ НАДАД ХАНДАН ЯРЬСАН ЮМ

Манай отгон охин Аманда хоёр настай байхдаа цусны цагаан бөөмийн өвчин туссан нь оношлогдов. Түүний өвчин хүнд байсан болохоор химийн эмчилгээний дараа хавдар нь багасахгүй байлаа. Түүнд чөмөгний яс шилжүүлэн суулгах шаардлагатай байв.

Миний нөхөр, хоёр хүүтэйгээ хамт Ютад гэртээ байх үед би Амандатай хамт өөр муж улсад есдүгээр сараас дараа оны нэгдүгээр сарын эхний хагас хүртэл байлаа. Бид Христийн Мэндэлсний Баярыг хамтдаа тэмдэглэж чадалгүй эмнэлгийн ээлжит хяналтын эцэст гэртээ эргэж ирсэн билээ.

Гэртээ эргэж ирсний дараа анх удаа хяналтын үзлэг хийлгэхээр эмнэлэг уруу очиход эмч нар Амандагийн цусанд цагаан бөөмийн хавдрын эс илрүүлээ. Чөмөгний яс шилжүүлэн суулгасан нь амжилтгүй болжээ. Энэ таагүй мэдээг сонсоод миний зүрх зогсчих шиг болов. Манай гэр бүлд сэтгэл санааны түгшүүр, ажил хөдөлмөр,

бие биенээсээ хол амьдарч байснаас гадна хүнд цаг үе ч тохиолдож байлаа. Гэтэл одоо охиноо алдах болчихоод байдаг.

Тэр нэгэн үдээс хойш би хоёр хүү дээрээ эргэж ирлээ. Би нөхрөө ажлаас ирэхийг хүлээж байх хооронд хүүхдүүдтэйгээ хамт Мормоны Номоо гаргаж ирэн уншиж эхэллээ. Бид 2 Нифай 9-ийг уншиж байлаа. Биднийг уншиж байх үед дараах үгс надад хандан ярих шиг болов:

“Их Эзэн Бурхан хүүхдүүд дээр тань цутгах адислалуудын учир тэргүүнээ ямагт дээр өргөж, мөн та нар баясаж болно хэмээн би та нарт эдгээр зүйлсийг ярьж байна.

“Та нарын олон тань ирэх зүйлүүдийн талаар мэдэхийн тулд ихийг судалсныг би мэднэ; иймийн тул махан бодь маань элэгдэж мөн үхэх ёстойг та нар мэддэгийг би мэднэ; гэсэн хэдий ч өөрсдийнхөө биеэр Бурханыг бид харах болно. . . .

“Агуу их Бүтээгчийн нигүүлсэнгүй төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн тулд үхэл бүх хүмүүний дээр улиран ирсэнчлэн амилуулалтын хүч байх ёстой. . . .

“Энэхүү аймшигт мангасын атганаас зугтах бидний замыг бэлтгэх, Ай Бурханы маань сайн сайхан хэчнээн агуу билээ; тийм ээ, тэр мангасын буюу. . . .

“Мөн хэрэв тэд түүний дууг анхааран сонсвоос бүх хүмүүнийг аварч болохын тулд тэрээр дэлхийд ирнэ; учир нь болгоогтун, тэрээр бүх хүмүүний шаналлыг тэвчинэ, тийм ээ, амьдрагч бүхний шаналлыг, Адамын гэр бүлд багтах эр, эм, мөн хүүхэд аль алиных нь болой.

Бүх хүмүүний дээр амилуулалт тохиож болохын тулд агуу их хийгээд шүүлтийн өдөр бүтд түүний өмнө зогсож болохын тулд тэрээр үүнийг тэвчих бөлгөө” (2 Нифай 9:3–4, 6, 10, 21–22).

Намайг эдгээр үгсийг уншихад Ариун Сүнс өрөөг дүүргэсэн байлаа. Тэнгэрлэг Эцэг минь тэр өдөр миний хүлээн авсан мэдээг мэдэж байсныг би мэдэрч билээ. 2000 гаруй жилийн өмнө бичигдсэн бошиглогч Иаковын үгс тэр өдөр надад зориулан бичигдэж, Аврагчаас надад шууд ирсэн юм шиг санагдаж билээ. Охины хорвоог орхих нь гарцаагүй болсныг мэдсэний дараа надад тохиолдсон уй гашууг Тэрбээр мэдэж байжээ. Иймээс Тэрбээр замыг бэлтгэсэн бөгөөд тэр өдөр Амилуулалтын хүчээр дамжуулан “өөрсдийнхөө биеэр бид Бурханыг харах болно” гэсэн амлалтаараа манай гэр бүлийг тайтгаруулсан юм.

Аманда дахиад бараг жил амьда явсан. Харин Мормоны Номын үгс хэрэгтэй цагт надад хандан ярьж, Их Эзэн надад найдвар, тайтгарал, Түүний төлөвлөгөөг ойлгох ойлголтыг өгснийг би хэзээ ч мартахагүй. ■
Гина Бейрд, Юта, АНУ

Намайг уншиж байх үед Ариун Сүнс өрөөг дүүргэв. Тэнгэрлэг Эцэг минь тэр өдөр миний хүлээн авсан мэдээг мэдэж байсныг би мэдэрч билээ.



БИ МОРОНАЙН АМЛАЛТЫГ ТУРШИЖ ҮЗСЭН

Хэдэн жилийн өмнө би нэг найзындаа байж байгаад өөрсдийгөө Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид гэж танилцуулсан, сайхан хувцасласан хоёр залуутай танилцсан юм. Тэд Аврагчид аль хэдийнээс итгэдэг байсан хүмүүсийг хөрвүүлэхээр Италид алс холоос ирсэн нь хачирхалтай санагдаж билээ.

Хожим би тэднийг гэртээ ирээч гэсэн юм. “Хэрэв та нар хүсвэл соёл заншлаа харилцан солилцохын тулд надтай очиж уулзаж болно. Харин шүтлэг бишрэлээ өөрчлөхийг хүсэхгүй байна” гэж би хэлэв.

Маргааш орой нь биднийг уулзахад номлогчид надад Мормоны Номын тухай яриу. Би энэ номын тухай өмнө нь огт сонсож байгаагүй нь надад хачирхалтай санагдлаа. Би тэднийг гэртээ дахин ирэхийг урьсан ч, тэднийг хоёр дахь удаагаар ирсний дараа миний эхнэр Анна Мария тэднийг солиотой хүмүүс гэж үзэн, ярилцлагаа зогсоож манайхаас тэднийг тэр даруй яв гэх нь тэр. Тэдгээр номлогчид надад ч гэсэн нэг л өөр юм шиг санагдсан ч, тэдэнтэй дахин уулзвал юу гэж ярих бол хэмээн миний сониуч зан хөдөллөө.

Нэг орой Анна Мария гэртээ ирээд үүрд мөнхийн гэрлэлтийн тухай бид ярилцаж байсныг сонссон ажээ. Энэ сэдэв түүний сонирхлыг ихэд татсан учир, дараагийн удаа бид ярилцлагыг хамтдаа авахаар шийдэв. Мария судруудын талаар сайн мэддэг байсан бөгөөд асуултаудын урт жагсаалт бэлтгэдэг байлаа. Ахлагч нар зарим асуултанд шууд хариулж, заримыг судалж байж хариулахын тулд гэр уруугаа авч явдаг байв. Тэд долоо хоног бүр заавал асуултаудын хариулттай



“Мормоны Ном үнэн үү? Хэрэв үнэн бол би хэзээ баптисм хүртэх вэ?” гэж Тэнгэрлэг Эцэгээс асуулаа.

ирдэг байсан бөгөөд Анна Мария дахиад олон асуулт жагсаан бичсэн байдаг байлаа.

Биднийг ярилцлагаа дуусгасны дараахан Анна Мария баптисм хийлгэхээр миний зөвшөөрлийг хүссэнд би хэчнээн их гайхсан гэвч. Хэрэв эхнэр минь үнэхээр хөрвөсөн юм бол түүнийг баптисм хийлгэхэд би дургүйцэхгүй гэв. Би 1995 оны 3-р сарын 5-нд түүний баптисмын ёслолд оролцохдоо гайхамшигтай сайхан мэдрэмжийг мэдэрч билээ.

Би Сүмийн тухай ихэд сонирхон уншсаар, мөн номлогчид ч намайг үргэлж урамшуулан дэмждэг байлаа. Эцэстээ би Моронайн амлалтыг туршаад үзье гэж шийдлээ (Моронай 10:4–5-ыг үз). Мормоны Ном Бурханаас ирсэн үү, эсвэл энэ нь зүгээр нэг аятайхан роман уу гэдгийг би мэдэхийг хүссэн юм.

1995 оны 6-р сарын нэгэн өдөр би гэртээ ганцаараа байхдаа орныхоо дэргэд өвдөг сөгдөн, “Мормоны Ном үнэн үү? Хэрэв үнэн бол би хэзээ баптисм хүртэх вэ?” гэж Тэнгэрлэг Эцэгээс асуулаа. Би гэнэт зүрх сэтгэл, оюун ухаандаа “Мормоны

Ном үнэн” гэж хэлэх тод томруун дуу хоолойг мэдэрлээ. Тэгээд хэзээ баптисм хүртвэл зохих нь надад тодорхой болов. Долоо хоногийн дараа дахин залбиртал мөн адил хариу ирэв. Зүрх цохилон, магнай хагартлаа баярлалаа. Бурхан надад хандан: Мормоны Ном Бурханаас сүнсээр нөлөөлөгдсөн бөгөөд Иосеф Смит бол үнэн бошиглогч мөн хэмээн хэлснийг би мэдэж байлаа.

Эцэст нь би номлогчидтой уулзаж эхэлснээс хойш жил хагасын дараа 1995 оны 9-р сарын 17-нд баптисмын усанд орж билээ. Удалгүй манай охин Аба Чиара Сүмийг сонирхож эхлэн бас баптисм хүртэв. 1997 оны 1-р сард манай гэр бүл Швейцарийн Берний Ариун сүмд лацдан холбууллаа.

Энэ Сүм бол бошиглогч болон санваараар дамжуулан Есүс Христийн удирддаг үнэн Сүм гэдгийг бид мэднэ. Бид Их Эзэнд Түүний хайрын төлөө, биднийг номлогчид уруу удирдсаных нь төлөө, сайн мэдээг бидэнд мэдүүлснийх нь төлөө баярлан талархаж явдаг билээ. ■

Франческо Феррарези Ломбарди, Итали

Хэлтэн болон хүн бүрд

Лиa МкКланахан
Сүмийн сэтгүүлүүд

Мормоны Номын бошиглогч Алма өөрийн хүмүүсийн цэдгийг хүү Хиламандаа итгэмжлэн хүлээлгэж өгөх үед судруудыг хадгалж хамгаалах “мэргэн зорилго” Их Эзэнд бий гэдгийг хүүдээ хэлжээ (Алма 37:12). Тэрбээр цэдгүүдийн тухай, “тэдгээр нь хадгалагдаж, мөн нэг үеэс нөгөөд гардуулагдан, тэдгээр нь үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүс болгонд очих хүртэл буюу” (Алма 37:4) гэж хэлжээ.

1827 онд Иосеф Смит цэдгүүдийг олж аван, 1829 гэхэд Бурханы бэлэг болон хүчээр тэдгээрийг англи хэлэнд орчуулж дуусчээ. 1830 онд хэвлэгдсэн энэ ном Есүс Христийн сайн мэдээ үнэн гэдэгт уншигчдаа итгүүлэх номлолын хүчирхэг хэрэгсэл мөн. Гэвч анхны удаа 5000 хувь хэвлэгдсэн Мормоны Номыг “үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүс болгонд” хүргэх зам урт удаан мэт санагдаж байлаа.

Гэсэн хэдий ч, “хүн болгон сайн мэдээний бүрэн байдлыг төрөлх хэл дээрээ, мөн өөрийн хэлээр сонсох” (С ба Г 90:11) өдөр ирэх болно гэдгийг Их Эзэн 1833 онд бошиглогч Иосеф Смитэд өгсөн энэхүү бошиглод дахин нотолсон юм. “Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг . . . агуулдаг” (С ба Г 20:9) Мормоны Ном энэ бошиглолын биелэлтэнд үндсэн үүрэг гүйцэтгэж байна.

1800-гаад оны дундуур номлогчид сайн мэдээг Европт хүргэжээ. Мормоны Ном 1851 онд дани хэлээр дараа нь франц, герман, итали, 1852 онд уэльс хэлээр хэвлэгджээ. Өнөөдөр Мормоны Номыг бүрнээр нь 82 хэлээр, сонгож авсан бүлгүүдийг нь 25 хэлээр тус тус хэвлээд байна. Бүх хүмүүс сайн мэдээг төрөлх хэлээрээ сонсох болно гэсэн бошиглол нь орчуулга болоод номлолын ажил урагш ахихын хэрээр жилээс жилд биелэгдэж байна.



Мормоны Номыг анх 5000 хувь хэвлэжээ.

Орчуулгын ажил

Мормоны Номыг англи хэлнээс аль нэг өөр хэлэнд орчуулах үйл явц нь заримдаа хэдэн жил үргэлжилдэг. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга орчуулгын төслийг баталсны дараа орчуулагчдаар ажиллах хангалттай тооны төрөлх хэлээрээ яригч орчуулагчид байгаа тохиолдолд орчуулга эхэлдэг. Орчуулагчид болон хянагчдад нягт нямбай боловсруулсан удирдамжийг өгч, орчуулах үедээ Сүнстэй ойр байх зааврыг өгдөг. Орчуулга дууссаны дараа шашны сургаалын хувьд бүх талыг хамарсан хяналт эхэлдэг.

Хэвлэгдсэний дараа

гишүүд Хангамжийн Төвөөр дамжуулан орчуулагдсан номыг захиалдаг. Урьд нь эдгээр гишүүдээс олон нь зөвхөн Мормоны Номын сонгож авсан бүлгүүдтэй эсвэл зарим тохиолдолд зөвхөн номлогчдын гэрчлэлтэй байсан ажээ.

Мормоны Ном ба номлолын ажил

Газарзүйн аль нэгэн бүс номлолын ажилд анх удаа нээлттэй болоход хэлний саад тогтор яггүй бэрхшээл учруулдаг байв. Тухайн нутгийн хэлээр хэвлэгдсэн Сүмийн гарын авлага, материалуудгүй газарт номлогчид тэдний хэлийг сурч гэрчлэлээ Сүнсний тусламжтайгаар хэлэх хэрэгтэй болдог. Дэлхийн зарим хэсэгт олон хүн хоёр дахь хэлээр ярьдаг бөгөөд номлогчид Мормоны Номыг тэдэнд энэ хэлээр нь өгдөг. Жишээ нь, Мормоны Номыг монгол хэлэнд орчуулахаас өмнө Монголын олон гишүүн орос хэлээр хэвлэгдсэн хувийг судалдаг байв.

Гэвч хүн сайн мэдээг төрөлх хэлээрээ илүү тодорхой, сайн ойлгодог. Словений Любляна Номлолд 2001–2003 онуудад үйлчилсэн Эрик Геммел Мормоны Номыг төрөлх хэлээрээ уншиж судалдаг, гишүүд, сонирхогчдод энэ ном ямар их ялгаатай



БОШИГЛОГЧ ГЭРЧИЛСЭН НЬ

“Эдүгээ бидний гар дээр ирээд зуу гаруй жил болоод байгаа бөгөөд энэ бүх үеийн туршид түүнийг нэг удаа нэг шалтгаанаар дараа нь өөр нэг шалтгаанаар дооглон тохуурхлаа ч, гутааж чадахгүй байгаа Мормоны Номыг Их Эзэний тусламжгүйгээр хэн нэгэн нь хэвлэн гаргаж чадна хэмээн оюун ухаант хүмүүн бодно гэдэг нь миний санаанд багтдаггүй. Их Эзэний мутарт зэмсэг болсон Иосеф Смитийн орчуулсан энэ ном өнөөдөр бүр хүчтэй зогсож байна. Өнөөдөр энэ ном сайн мэдээг тунхаглахад бидэнд хамгийн агуу номлогч болж байна. Үүнтэй харьцуулах өөр юу ч байхгүй юм.”

Ерөнхийлөгч Хебер Ж. Грант,
Gospel Standards, эмхтгэсэн
Г. Хомер Дархем (1941), 15.

нөлөөлдгийг харжээ. Тэр номлолынхоо эхний 18 сарыг Мормоны Ном словени хэлээр гараагүй байхад үйлчилсэн гэнэ.

Номлолын ажил хэцүү байлаа. Сүмийн анхны салбар ердөө аравхан жилийн өмнө зохион байгуулагдсан байлаа. Словени саяхан тусгаар тогтнолоо олж, өмнө нь төрийн хэл байсан серб-хорват хэлийг халах явцдаа байжээ. Номлогчид серб-хорват болон ихэнх залуу хүмүүсийн сургуульд үзсэн хэл болох англи хэлээр хэвлэгдсэн Мормоны Номыг ашигладаг байлаа. Гэвч олон тохиолдолд хүмүүс дээрх хоёр хэлний

алийг нь ч ойлгодоггүй байсан учир энэ номноос татгалздаг байлаа. Мормоны Номын агуу ач холбогдлын тухай гэрчлэлээ хүмүүстэй хуваалцаад энэ ном тэдний төрөлх хэлээр байхгүйг хэлэх нь хэчнээн таагүй байсныг Эрик санадаг ажээ.

Эрикийг номлолоосоо буцахаас зургаан сарын өмнө словени хэлээр хэвлэгдсэн Мормоны Номын анхны хувиуд иржээ. Салбарын нэг цуглаан дээр гишүүд, номлогч бүр өөрсдийн хувийг хүлээн авсан гэнэ. “Тэр үед цуглааны байр онцгой сүнсээр бялхан байлаа” гэж Эрик дурсан ярив.

Тийнхүү удаан хүлээсэн, үнэ цэнэтэй энэ номыг гартаа барих нь ямар санагдаж байсныг тэрээр өдрийн тэмдэглэлдээ тэмдэглэжээ. “Яг л алтан ялтсуудыг гартаа барьж байгаа юм шиг байлаа” хэмээн тэр бичжээ. Цуглааны дараа үлдсэн номыг номлогчид номлолын ажилдаа ашиглахаар авчээ. Эрик хамтрагчтайгаа байрандаа ирээд хайрцгуудыг онгойлгож, номнуудыг гаргаж ирэн энэ үйл явдлыг дурсан санахын тулд зураг авсан ажээ. Тэд номоо хүмүүстэй хуваалцахыг тэсч ядан хүлээж байв. Словени хэлээр хэвлэгдсэн Мормоны



Орчуулгын ажил урагш ахихын хэрээр дэлхий даяарх гишүүд түүний доктор Словений Леа, Флора Лотрик нар төрөлх хэлээрээ хэвлэгдсэн Мормоны Номыг анх удаа гартаа бариад баярлаж байна.



БОШИГЛОГЧ ГЭРЧИЛСЭН НЬ

“Энэ номыг нягт няхуураар судалж эхлэх мөчөөс та нарын амьдралд урсан орох хүч үүнд бий. Та нар уруу таталтыг эсэргүүцэн зогсох агуу хүчийг олох болно. Та нар хууран мэхлэлтээс зайлсхийх хүчтэй болно. Та нар нарийн бөгөөд давчуу зам дээр байх хүчийг олно.”

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994), “The Book of Mormon—Keystone of Our Religion,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 4; мөн энэ дугаарын хуудас 52.

Номтой болсноор номлогчид зөвхөн хүмүүстэй ажиллахад илүү амжилт олоод зогссонгүй, бас энэ ном сүмд ирээгүй олон жил болсон идэвх султай гишүүдийн гэрчлэлийг бэхжүүлэх арга зам болжээ.

Эрик номлолынхоо сүүлчийн зургаан сард Словений гишүүдийн гэрчлэл хурдан өсөн хөгжихийг харжээ. “Тэд төрөлх хэлээрээ Мормоны Номтой болсноос хойш үүнийг маш сайн ойлгодог болсон. Энэ ном хүмүүсийн зүрх сэтгэлд гүнзгий нөлөөлсөн юм” гэж тэр ярилаа. Урьд нь Сүмийн цуглаанууд дээр үг хэлэгчид болон багш нар судруудыг серб-хорват хэлээр уншиж, хэн нэгнээр орчуулга хийлгэн, үг хэллэгийг тайлбарладаг байлаа. “Ингэх нь бид

өөр хэлнээс зээлдсэн үг хэллэгүүд дундуур үхэр тэргээр сажлан явж байгаа юм шиг санагддаг байлаа” гэж Эрик дурсан ярилаа. Гишүүд Мормоны Номыг төрөлх хэлээрээ уншдаг болсноос хойш сайн мэдээг ойлгох нь тэр даруйд сайжирсан” гэж Эрик хэлэв.

Төрөлх хэлээр нь

Мойка Зелезникар бол Мормоны Ном словени хэлээр гарахаас өмнө Словени дахь Сүмд нэгдсэн гишүүдийн нэг юм. Эдгээр эмэгтэй номлогч нарын үгийг сонсож, Мормоны Номыг хорват болон англи хэлээр судалснаар сайн мэдээний тухай гэрчлэлтэй болсон ажээ. Словени хэлээрх орчуулга дууссаны дараа Мойка орчуулсан текстийг уншаад төрөлх

хэлнийхээ үг хэллэгийн хүчийг мэдэрсэн гэнэ. “Туйлын энгийн атлаа онцгой цэвэр байдлаар үнэн миний өмнө нээгдэхийг би мэдэрсэн. Энэ нь намайг Бүтээгч төрөлх хэлээр минь, ээж минь надтай ярьдаг байсан тэр хэлээр надад хандан ярьж байгаа юм шиг санагдсан” гэж тэр хэллээ.

Дэлхий даяарх гишүүд Мормоны Номыг төрөлх хэлээрээ хүлээн авсан үед тэдэнд ч ийм мэдрэмж төрдөг. 2003 онд Гватемала болон Белизийн Мая хүмүүсийн ярьдаг кекчи хэлэнд Мормоны Ном орчуулагдсаны дараа орчуулагчид орон нутгийн хэсэг гишүүдтэй хамт орчуулгыг хянасан ажээ. “Бид Сенахугийн цуглааны байранд хэсэг анхдагч гишүүдийг цуглуулан орчуулгыг



Орчуулга дууссаны дараа тухайн хэлээр яригч Сүмийн гишүүдээс орчуулсан номыг хянахыг хүсдэг. Зүүн талаас: Уолтер Бариллас Сото, Майк Пек, Сюленни Рюби Кукул Сиерра, Жон Брингест, Жозефина Кукул Тиюл Гватемалын Кобанд кекчи хэлээр хэвлэгдсэн Мормоны Номыг хянаж байгаа нь



БОШИГЛОГЧ ГЭРЧИЛСЭН НЬ

“Энэ номыг (Мормоны Ном) анх бичсэн хэлнээс нь, алтан ялтсууд дээрх сийлбэрээс Бурханы бэлэг болон хүчээр [Иосеф Смит] орчуулсныг бид уншиж байгаа бөгөөд энэ

нь үүрдийн Сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг билээ. Энэ ном үнэний тухай мэдлэгтэй болоход нь хүмүүнийг удирддаг бөгөөд тэд энэхүү мэдлэгээр аврагдаж, Бурханы оршихуйд буцаж очин, Түүний алдар суунаас хүртэж, үүрд мөнх амьдарч чадна.”

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918), *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 42.

унших үед хэсэг бүрийг дууссаны дараа тасалгаанд хүндэтгэлтэйгээр нам гүм болдог байв. Хүмүүс маш сайн ойлгож, Сүнс онцгой хүчтэйгээр мэдрэгдэж байлаа. Энэ бол үнэхээр ариун үйл явдал байлаа.”

Тэр цуглаан дээр байсан гишүүдийн нэг Элвира Ци өсвөр үеийнхэнд Мормоны Ном үй олон адислал авчрах учраас энэ ном кекчи хэлэнд орчуулагдсанда баярлан талархаж явдаг ажээ. Энэ номын орчуулга “Их Эзэний үгийг зүрх сэтгэлдээ шингэтэл ойлгож, Түүний шаардсан зүйлсэд хүндэтгэлтэй хандах боломжийг” залуу гишүүдэд олгох болно гэж тэр хэллээ.

Сүмийн гишүүдийн хувьд Мормоны Номыг судлах нь тоо томшгүй олон адислалын эх сурвалж юм. Гишүүд “судруудаас залбирч суралцан, залбирч заасан үед тэдний гэрчлэл өсч, мэдлэг нь нэмэгдэн, гэр бүлээ болон бусад хүмүүсийг хайрлах хайр нь улам

өсч, бусдад үйлчлэх чадвар нь дээшлэх болно, ингэснээр тэд уруу таталтыг эсэргүүцэж, үнэн ба зөвт байдлыг хамгаалах хүч чадалтай болно” хэмээн Тэргүүн Зөвлөл хэлж байна.¹

Арвин баялаг адислалууд

Мормоны Номыг уншиж судалдаг хүмүүсийн амьдралд энэ номын авчирдаг арвин баялаг адислалууд нь үүнийг бусадтай хуваалцах хүсэл эрмэлзлийг төрүүлж, бошиглолыг гүйцэлдүүлэхэд дөхөм үзүүлдэг. Дэлхий даяар жил бүр дөрвөн сая Мормоны Номыг хэвлэн тарааж байгаа бөгөөд гишүүд, номлогчид энэ номноос Есүс Христийн тухай гэрчлэлээ хуваалцдаг. Эрт үед Алмагийн өгүүлсэн “мэргэн зорилго” дэлхий даяар тараагдаж буй Мормоны Номонд илчлэгдсэн бөгөөд амьдралыг өөрчилсөөр байна. ■

ЭШЛЭЛ

1. Тэргүүн Зөвлөлийн захидал, 2008 оны 10-р сарын 15.

ДАРААХ ХЭЛБЭРҮҮДЭЭР БОЛОМЖТОЙ

Мормоны Номыг хэвлэн гаргаснаас гадна хүмүүн түүнийг уншиж судлах олон янзын арга зам бүхий хэлбэрүүд бас байдаг.

Интернет ба онлайн

Мормоны Номыг эдүгээ Интернетэд (scriptures.lds.org) холбооны хөдөлгөөнт хэрэгслүүдээр (mobile.lds.org)-аас уншиж болно. Эдүгээ онлайнд 21 хэлээр тавигдсан бөгөөд удахгүй бүр олон хэлээр тавигдах болно. Онлайн дахь харьцуулсан эшлэлүүд болон өгүүллүүдийг хайж олсноор судруудыг олон янзын аргаар судалж, шинэ ойлголттой болох боломжтой юм.

Аудио хувилбарууд


Эдүгээ Мормоны Номын аудио бичлэгүүд англи, япон, солонгос, португаль, испани хэлээр гараад байна. Та scriptures.lds.org-аас бичлэгүүдийг үнэгүй хуулж авах буюу Хангамжийн Төвүүдээр дамжуулан CD-ийг худалдаж авч болно (store.lds.org). Сонгож авсан бүлгүүд бас каксчвикел, мам, навахо, квиче, цоцил хэлүүдээр аудиокассетаар гарсан байгаа. Бусад хэлүүдээр аудио бичлэг хийх ажил хийгдэж байна.



Бусад хэвлэлүүд

Мормоны Номын Түүхүүд нэртэй өнгөт зурагтай, хялбаршуулсан текст нь уншиж сурч байгаа хүмүүст зориулсан үзүүлэн юм. Энэ ном 70 гаруй хэлээр хэвлэгдээд байна. Мормоны Номын Түүхүүд нь онлайнд scripturestories.lds.org-т байгаа болно.

Түүнчлэн Америкийн дохионы хэлээрх иж бүрдэл DVD-гийн томруулсан хэвлэлийг (англи, португаль, испани хэлээр) мөн Английн Брейлле хэвлэлийг Хангамжийн Төвүүдээр дамжуулан олж авч болно.



МОРМОНЫ НОМЫН ТУХАЙ ТОГТМОЛ АСУУДАГ АСУУЛТУУД



Мормоны Ном гэж юу вэ? Энэ номыг Библи-тэй хэрхэн харьцуулж болох вэ?

Мормоны Ном бол Библи-тэй адилхан судрын ном юм. Энэ бол Есүс Христийн бас нэгэн гэрээ.¹ Библи ихэвчлэн эртний Израилын амьдрал, сургаалуудыг авч үздэг. Мормоны Ном нь Америк тивд очин суурьшсан нэлээд хэдэн бүлэг хүмүүс, түүний дотор МЭӨ 600 онд Иерусалимыг орхин явсан нэг гэр бүлийн тухай цэдгийг агуулдаг. Эдгээр хүмүүс бол бас Израилын угсааны үр удмынхан юм. Тийнхүү Библи, Мормоны Ном хоёрыг дэлхийн хоёр өөр хэсэг дэх адил өв уламжлалтай хүмүүс бичжээ.

Библийн адил Мормоны Ном нь түүхийн цэдгээс илүү юм. Энэ ном “Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал” (С ба Г 20:9): Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христийн тухай гэрчилдэг сургаал, номлол, бошиглолуудыг агуулдаг.

Мормоны Ном нь “Аврагч Амилалтынхаа дараа энэ тивд (Америк) хүрч ирэн, Сайн мэдээг бүрэн байдлаар нь, баялаг агуулгаар нь, хүч болон адислалаар нь үндэслэн бий болгосныг, тэндхийн хүмүүс зүүн тивийнхтэй адил Төлөөлөгчид, Бошиглогчид, Пасторууд, Багш нар болон Сургаалыг номлогчид, мөн тэдний адил жаяг, адилхан санваар,

Мормоны Номын тухай найз нар болон гэр бүлийн гишүүд, үнэхээр сонирхсон хүмүүс эсвэл биднийг эсэргүүцэгчид биднээс олон асуулт асуудаг. Энд зарим хариултуудыг өгөв.



адилхан ёслолууд, бэлгүүд, хүч болон адислалуудтай байсныг; . . . тэдний дундах сүүлчийн бошиглогчид өөрсдийн бошиглолууд, өөрсдийн түүхийн товч хураангуйг бичиж, газарт булахаар зарлиг болгогдсоныг мөн энэ нь хожим гарч ирэн эцсийн өдрүүд дэх Бурханы зорилгуудыг гүйцэлдүүлэхийн тулд Библи-тэй нэгдэх ёстойг бидэнд өгүүлдгийг Бошиглогч Иосеф Смит тайлбарласан юм.”²

Сүмийн гишүүд Библи, Мормоны Ном хоёрыг хоёуланг нь судалдаг. Ням гарагийн хичээлийн дөрвөн жилээс хоёр нь Библийг судлахад зориулагддаг. (Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг энэ



дугаарын хуудас 16, 24, 52-оос үз.)

Мормоны Номыг хэн бичсэн бэ?

Эртний бошиглогчид Нифай, Иаков, Мормон, Мормоны хүү Моронай нар бол үндсэн зохиогчид нь юм. Өөрсдийн түүх, бошиглоууд болон сургаалуудын талаар бошиглогчдын хөтөлсөн цэдгүүдийг Мормон түүвэрлэн хураангуйлжээ. Тэрбээр бас хувийнхаа зарим туршлагыг оруулсан байна. Мормон энэ цэдгийг алтан шаргал өнгөтэй металл ялтсууд дээр сийлбэрлэснийг ихэвчлэн алтан ялтсууд хэмээн нэрлэдэг.

Мормоныг нас барсны дараа Моронай цэдгийг дуусгаж, өнөө үеийнхэнд зориулж нэг гүвээнд булжээ. Тэнгэр элч болсон Моронай 1823 онд Иосеф Смит дээр хүрч ирэн цэдэг булсан газрыг үзүүлсэн байна. Дөрвөн жилийн дараа цэдгийг гаргаж авахыг Иосефт зөвшөөрсөн ажээ. Тэрбээр “Бурханы хүч болон бэлгээр цэдгийг бичсэн эртний хэлнээс англи хэлэнд орчуулжээ.”³ Дараа нь тэр Мормоны Номыг

Өөр ямар хүмүүс цэдгүүдийг үзсэн бэ?

хэвлүүлж тараажээ. (Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг энэ дугаарын хуудас 22, 72-оос үзнэ үү.)

Анхны цэдэг—алтан ялтсуудыг яасан бэ?

Иосеф Смит ялтсуудыг 1827 оны есдүгээр сард хүлээн аваад 1829 оны зун хүртэл өөртөө байлгасан ажээ. Тэрээр 1838 онд өөрийн түүхэнд мөнөөх цэдгүүдийн талаар: “Тохиролцсоны дагуу, уг элч (Моронай) тэдгээрийг хүсэхэд би түүнд тэдгээрийг гардуулж өгсөн билээ; мөн тэрээр тэдгээрийг өөрийн мэдэлд энэ өдөр болох нэг мянга найман зуун гучин найман оны тавдугаар сарын хоёр дахь өдрийг хүртэл байлгаж буй болой” (Иосеф Смит—Түүх 1:60) хэмээн бичжээ.

Өөр ямар хүмүүс цэдгүүдийг үзсэн бэ?

Иосеф Смитээс гадна нэлээд хэдэн эрэгтэй, эмэгтэйчүүд ялтсуудыг үзэж, ялтсууд үнэхээр байсныг гэрчилсэн юм. Цэдгүүдийг харсан гурван гэрч, гараараа барьж үзсэн найман гэрч хэмээн нэрлэгддэг арваннэгэн хүн харсан тухайгаа



гэрчлэн бичжээ. Тэдний гэрчлэл Мормоны Ном бүрийн эхэнд байдаг.

Эдгээр эрчүүд Мормоны Номын хөдөлшгүй гэрчүүд болсон бөгөөд тэднээс зарим нь “Иосефт хэсэг хугацаагаар дайсагнасан ч,” үүнийг улам баттайгаар гэрчилсэн юм хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд нотолжээ. Гэсэн ч тэд “тэнгэр элчийг харснаа болон ялтсуудыг барьж үзсэнээ амь насаараа дэнчин тавин гэрчилсэн. ‘Тэдгээр нь бидэнд хүний хүчээр бус, Бурханы хүчээр үзүүлэгдсэн юм’ хэмээн тэд мэдэгдсэн билээ ‘Иймээс бид энэ ажил үнэн гэдгийг мэднэ.’”⁴



Мормоны Ном үнэн гэдгийг нотлох биет баримт байдаг уу?

Хэдийгээр бид өөрсдийн итгэлийг биет нотолгоон дээр үндэслэдэггүй ч Мормоны Номын хэл, түүхийн болон эртний судлалын нотолгоо байдаг. Жишээ нь, металл ялтсууд дээр цэдгийг бичих санааг нэгэнтээ дооглон тохуурхаж байсан ч ариун цэдгүүдийг металл ялтсууд дээр бичиж, чулуун хайрцганд нуусан олон жишээ ойрын жилүүдэд илэрсэн билээ.

Мормоны Номын үг хэллэг англи хэлээр эвгүй сонсогддог ч Мормоны Номын хүмүүсийн мэддэг харин залуу Иосеф Смитийн мэддэггүй байсан еврей болон холбогдох

бусад хэлээр яруу сайхан сонсогддог байсныг хэл шинжээчид тэмдэглэсэн байдаг.

Гэвч эдгээр нотолгоонууд нь Мормоны Ном үнэн гэдэгт биднийг итгүүлэх зүйлс биш. Энэ бол итгэлийн болон хувь хүний илчлэлтийн асуудал мөн.

Мормоны Ном үнэн гэдгийг би яаж мэдэх вэ?

Өөрөө мэдэх цорын ганц найдвартай арга бол Ариун Сүнсээр дамжуулан мэдэх явдал мөн. Энэ номыг уншиж, тунгаан бодож, энэ нь үнэн үү гэдгийг Есүс Христийн нэрээр Тэнгэрлэг Эцэгээс асуухад бүх хүмүүсийг урьсан урилга Мормоны Номын сүүлчийн хуудсанд байдаг. Энэ урилгыг хүлээн авсан хүмүүс уг ном үнэн гэдгийг Ариун Сүнсний хүчээр мэдэх болно (Моронай 10:3–5-ыг үз). Сүмийн сая сая гишүүн залбирч, Мормоны Ном үнэн гэдгийг Ариун Сүнсний гэрчлэлээр мэддэг. (Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг энэ дугаарын хуудас 4, 60, 80-аас үзнэ үү.)



МОРМОНЫ НОМЫН ТУХАЙ ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭХИЙН ТУЛД

Мормоны Номын тухай илүү ихийг мэдэж, уг мэдээллийг гэр бүл, найз нөхөдтэйгөө хуваалцахад тань туслах арвин баялаг мэдээлэл онлайнд нэлээд хэдэн хэлээр байгаа.

- Мормоны Номыг онлайнгаас уншихын тулд scriptures .lds.org/bm хаягаар орж үзнэ үү.
- Мормоны Номын тухай дэлгэрэнгүй мэдээлэл авах, асуултууд асуух буюу номлогчидтой ярилцахын тулд mormon.org/book-of-mormon хаягаар ор.
- Мормоны Номыг үнэгүй авахын тулд mormon.org/free-book-of-mormon хаягаар орж хүсэлтээ тавь.
- Нэмэлт мэдээлэл, өгүүллэгүүд болон тайлбарыг lds.org/study/topics/book-of-mormon?lang=eng хаягаар үзнэ үү.

Илчлэлт 22:18–19 нь Бурханы үгэн дээр юу ч нэмэхгүй байхыг бидэнд хандан хэлснээс болж эргэлздэг байлаа.

Бурхан Өөрийн хүслийг дэлхий дээрх хүүхдүүддээ үргэлж илчилсээр ирсэн, цаашид ч илчлэх болно гэдэг нь бидний тулгуур итгэл бишрэлийн нэг юм. Библи бол Бурханы үг гэдэгт бид итгэдэг ч, энэ нь Бурханаас өгсөн эсвэл Түүнээс бошиглогчдоо өгсөн бүх илчлэлтийг агуулдаг гэдэгт бид итгэдэггүй. Бүр өнөөдөр ч гэсэн Тэрбээр Өөрийн хүслийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн суурь болсон амьд бошиглогчид, төлөөлөгчдөөр дамжуулан илчилсээр байна (Ефес 2:20-ийг үз).

Төлөөлөгч Иохан Илчлэлтийн номыг бичиж байхад энэ ном Библийн сүүлчийн ном байгаагүй. МЭ гуравдугаар зууныг хүртэл Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ хоёр Библи хэмээн нэрлэгддэг ном байгаагүй юм.

Мөн Дэд Хууль 4:2-ч бас Мосегийн үгс дээр юу ч нэмэхгүй байхыг бидэнд захисан байдаг.

Мэдээж, Хуучин Гэрээний эхэн дэх энэ шүлэг Библийн үлдсэн хэсгийг хэрэггүй болгодоггүй. Мосе ч, Иохан ч тэр үед байгаагүй номыг өөрчлөх тухай дурдаагүй харин сайн мэдээ үнэн сургаалуудыг өөрчлөхгүй байхыг анхааруулсан юм.

Сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг Мормоны Ном Бурханы үгийг өөрчлөөгүй харин үүнийг дахин баталдаг. (Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг энэ дугаарыг хуудас 24, 38-аас үзнэ үү.)

Анх хэвлэгдсэнээс нь хойш Мормоны Номонд өөрчлөлт оруулсаар ирсэн гэж би сонссон. Юуг, яагаад өөрчилсөн юм бол?

Энэ асуултын хариулт нь Мормоны Номыг орчуулсан болон хэвлэсэн үйл явцын тухай арай тодорхой ойлгохоос хамааралтай юм.

1. Иосеф Смит Бурханы хүчээр алтан ялтсуудыг орчуулахдаа үгсийг бичээчид хэлж бичүүлсэн. Бичээч нар түүний үгсийг тэмдэглэхдээ зарим үед зөв бичгийн болон дүрмийн алдаа гаргадаг байжээ.



Мормоны Ном үнэн гэдгийг би яаж мэдэх вэ?

Жишээ нь, 1 Нифай 7:20-д “харамсан байв” гэдэг үгийг “харамлан байв” гэж тэмдэглэсэн байжээ. Бичээч нар боловсролгүй хүмүүс байснаас гадна зөв бичгийн дүрмийг тэр үед журамлаагүй байв.

2. Орчуулгын анхны гар бичмэлийг хэвлэгчид зориулсан шинэ гар бичмэл хийхийн тулд хувилан олшруулсан ажээ. Энэ үе шатанд зөв бичгийн болон дүрмийн зарим алдааг залруулж, цэг тэмдгийг нэмжээ. Гэвч зарим үгсийг буруу болгон олшруулж шинээр нэлээд алдаа гаргасан байна.

3. Хэвлэгч хэвлэлийн эхийг нягт нямбай бэлтгээгүй харин ч үе үе өөр алдаануудыг гаргасан байлаа. Жишээ нь, Алма 57:25-д тэрээр “баясал” гэдэг үгийг буруу уншиж, “барцад” гэж бичсэн байжээ.

4. Бошиглогч Иосеф Смит Мормоны Номын эхний гурван хэвлэлийг анхааралтай хянаж, сайжруулах болон засвар оруулахад тусалсаар байжээ. Гэвч зарим алдааг сүүлийн үеийн хэвлэлүүдийг хүртэл олоогүй байжээ. Алма 16:5 дахь “явах эсэхийг” гэсэн хэвлэгчийн

алдааг бүр 1981 онд залруулж, алтан ялтсуудаас Бошиглогчийн орчуулсан анхны гар бичмэлтэй нь тохируулан “тийш явахыг” болгожээ.

5. Бусад өөрчлөлтүүдэд шинэ бүлэг, шинэ шүлэг болон харьцуулах эшлэл бүхий зүүвэр тайлбар орно.

Мормоны Номноос хуваалц

Хүмүүс Мормоны Номын тухай ямар ч асуулт асуусан, ном өөрийнхөө хамгийн сайн хамгаалагч байдаг. Та энэ номын тухай гэрчилж, үүнээс хуваалцан, үнэн эсэхийг нь өөрсдөө залбирч үзэхийг бусдаас хүс. Хэрэв хүн энэ ном үнэн эсэхийг мэдэхийг чин сэтгэлээсээ хүсэх юм бол, Их Эзэн “үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр [тэр хүнд] үзүүлэх болно” (Моронай 10:4). ■

Эшлэл

1. Жишээ нь, Бонд К.Пакер, “The Book of Mormon: Another Testament of Jesus Christ,” *Луахона*, 2002 оны 1-р сар, 71.
2. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 64.
3. *Teachings: Joseph Smith*, 60.
4. Жеффри Р.Холланд, “Safety for the Soul,” *Луахона*, 2009 оны 11-р сар, 90.

Ахлагч
Жеффри Р.Холланд
Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын



ГЭРЧЛЭЛ, ГЭРЭЭ БА ГЭРЧ


Аврагч болон Түүний сэргээгдсэн Сүмийн тухай ариун баталгаа намайг залуу байхдаа Мормоны Номыг унших үед ирсэн юм. Энэхүү ариун цэдгийг унших үед энэ ном үнэн гэдгийг Ариун Сүнс үгүйсгэх аргагүйгээр бодгальд минь шивнэдгийг би дахин дахин мэдэрсэн билээ.

Энэ номыг уншсан нь миний гэрчлэлийн эхлэл болсон. Энэ ном бол Бурхан амьд бөгөөд Тэр бол миний Тэнгэрлэг Эцэг, аз жаргалын төлөөлөгөө мөнх амьдралд миний төлөө зориулагдсан гэдгийг мэдсэн анхдагч эх сурвалж. Энэ ном Ариун Библи болон Сүмийн бусад жишиг бүтээлүүдэд намайг дуртай болгосон юм. Энэ нь Их Эзэн Есүс Христийг хайрлах хайрыг, Түүний энэрэнгүй нинжин сэтгэл хийгээд Түүний цагаатгагч золиослолын ач ивээл, агуу мөн чанарыг харж ойлгохыг надад заасан билээ.

Мормоны Ном нь Есүс бол Христ гэдгийн үнэн гэрч, бас нэгэн шинэ гэрээ болохыг би өөрөө мэдсэн учраас Иосеф Смит бол Бурханы бошиглогч байсныг би бас мэдсэн юм. Миний хуланц эцэг Сэргээлтийн эхний өдрүүдэд, “Ёс бус хүн үүн шиг ном бичиж чадахгүй; хэрэв энэ нь үнэн бус бөгөөд ийм ном бичихийг Бурхан түүнд зарлиг болгоогүй л бол сайн хүн ч ийм ном бичиж чадахгүй.”¹

Өдгөө миний амьдралыг, амьдралын минь зорилгыг болон гэрчлэлийн бат бөх үндэс суурийг гүнзгий утга учиртай болгож буй гэгээрүүлэгч, ариусгагч бусад зүйлс миний анхны итгэл үнэмшил дээр нэмэгдээд байна.

Би Жаредын ахтай хамт далай тэнгисийг гатлан хөвөөгүй, Бенжамин хааны тэнгэр элчийнхтэй адил



*Мормоны Ном
бол шинэ гэрээ,
Шинэ Дэлхий-
гээс бүх дэл-
хийд хандсан
шинэ гэрээ мөн
гэдгийг би гэр-
чилж байна.*

номлолыг сонсоогүй. Би Амилсан Их Эзэний шархны сорвиудад нифайчуудын адил гараа хүргэж үзээгүй, нэгэн бүхэл соёл иргэншил устгагдахыг хараад Мормон, Моронай хоёртой хамт уйлаагүй хүн. Гэвч энэ цэдгийн тухай миний гэрчлэл, хүмүүний зүрх сэтгэлд үүний авчирдаг амар амгалан нь Ариун Сүнсний шивнээгээр дамжуулан тэднийхтэй адил тод томруун гэрчлэлийг та нарт бас өгсөн. Би энэ номны тухай, Гурван гэрчтэй хамт тэнгэр элч Моронайг харсан юм шигээр, эсвэл Найман гэрчтэй хамт байж, алтан ялтсуудыг барьж үзсэн юм шигээр гэрчилж байна.

Хэрэв хүн Мормоны Ном болон энэ номын гэрчилдэг Их Эзэн Есүс Христийн бурханлаг мөн чанарыг баяртайгаар хүлээн авахгүй бол бидний хэн нь ч өнөө үед амар амгалан болоод тайтгарлыг бүрэн дүүрнээр олж, энэхүү хожмын үеийн ажилд бүрэн итгэлтэй болж чадахгүйг би гэрчилж байна. Мормон хамгийн хүнд үеүдийн нэгэнд Моронайд хэлсэн лүгээ адил би өнөөгийн хэцүү бэрх цагт: “Христэд итгэлтэй байгтун. . . Дээр тэнгэрт хаан ширээндээ залардаг Бурхан Эцэгийн ач ивээл, түүний баруун гар талд залардаг бидний Их Эзэн Есүс болон түүний хүч . . . та нартай хамт үүрд мөнхөд байх болтугай (Моронай 9:25–26).

Мормоны Ном бол хүн төрөлхтөнтэй байгуулсан Христийн сүүлчийн агуу ариун гэрээ мөн. Энэ бол шинэ гэрээ, Шинэ Дэлхийгээс бүх дэлхийтэй хийсэн шинэ гэрээ мөн. Миний замаа гэрэлтүүлдэг гэрэл бол Түүний гэрэл. Түүний нигүүлсэл хийгээд агуу мөн чанар намайг бас та нарыг Түүний тухай гэрчлэлээ дэлхийтэй хуваалцахад удирдан хөтөлдөг билээ. ■

ЭШЛЭЛ

1. Жорж Каннон, Андриу Женсоны хянан тохиолдуулсан “The Twelve Apostles”-д эш татжээ, *The Historical Record*, 6:175.




Тэрбээр тэднийг нэг бүрчлэн эдгээв, Гари Капп

“Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг нааш авчрагтун. . .

“ . . . Учир нь та нарыг эдгээхэд итгэл тань хангалттайг би харж байна.

“Мөнхүү улиран тохиох дор түүнийг тийн ярихад, бүх

цугласан олон нэгэн зэрэг, мөн өвчтэй, мөн зовж зүдэрсэн, мөн доголон, мөн хараагүй мөн хэлгүй, мөн ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн тэд бүгдтэйгээ урагшлав; мөн тэрбээр тэднийг түүнд авчрахад нэг бүрчлэн эдгээв”
(3 Нифай 17:7–9).



“Мөн эдүгээ . . . дэлхийн өнцөг булан бүр та нар бүгд, эдгээр үгсийг анхааран сонсож мөн Христэд итгэ; мөн хэрэв та нар эдгээр үгсэд үл итгэх аваас, Христэд итгэ. Мөн хэрэв та нар итгэх болбоос та нар эдгээр үгсэд итгэх болно, учир нь эдгээр нь Христийн үгс, мөн тэрээр эдгээрийг надад өгсөн юм; мөн эдгээр нь тэд сайныг хийвэл зохихыг бүх хүмүүнд заадаг билээ.

Мөн хэрэв эдгээр нь Христийн үгс биш аваас та нар шүүн тунгаа, өөрөөр хэлбэл Христ та нарт эцсийн өдөр эдгээр нь түүний үгс гэдгийг агуу их сүр жавхлан хийгээд хүчээр үзүүлэх болно” (2 Нифай 33:10-11).